СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2022 ОНЫ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот

2022 он

АГУУЛГА

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1.1 Зохион байгуулалтын бүтэц, орон тоо

ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭРЭГЖИЛТ

2.1. Хүний нөөцийн бодлого төлөвлөлт

2.2. Хүний нөөцийг хөгжүүлэх сургалтын талаар

2.3. ТҮСУ, ТҮ-ийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах хөтөлбөр

2.4. Хэвлэл мэдээлэл, олон нийт

2.5. Жендерийн эрх тэгш байдал

ГУРАВ. СОЁЛЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛСАН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1. Соёлын өвийг хамгаалахтай холбогдох бодлогын баримт бичиг

3.2. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт

ДӨРӨВ. ТӨСӨВ САНХҮҮ

4.1 Төсвийн төлөвлөлт

4.2 Төсвийн зарцуулалт

4.3 Худалдан авалт

4.4 Шилэн дансны хэрэгжилт

ТАВ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ, ДҮГНЭЛТ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1.1. Зохион байгуулалтын бүтэц, орон тоо

Соёлын яамны харьяа Соёлын өвийн үндэсний төв нь анх 1988 онд Соёлын яамны харьяа “Музейн сэргээн засварлах урлан”, 1995 онд Соёлын өвийн төв, Засгийн газрын 2017 оны 239 дүгээр тогтоолоор “Соёлын өвийн үндэсний төв” болон өргөжиж, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/235 тоот тушаалаар “Соёлын өвийн үндэсний төвийн дүрэм” болон бүтцийг тус тус баталсан билээ.

Соёлын өвийн үндэсний төв нь соёлын өвийг таньж тогтоох, бүртгэн баримтжуулах, мэдээллийн сан бүрдүүлэх, сэргээн засварлах, авран хамгаалах, мэргэжил арга зүйгээр хангах үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохион байгуулдаг ба байгууллагыг зориулалтын байртай болгох зорилгоор 2008 оноос үе үеийн соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ажилласны үр дүнд 2021 оны 6 дугаар сард Хан-Уул дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах 8000 м^2 талбай бүхий 130 гаруй өрөө тасалгаатай шинэ байранд шилжин орсон.

Соёлын салбар дахь соёлын биет болон биет бус өвийг хадгалж, хамгаалахтай холбоотой үйл ажиллагааг нэгдсэн бодлого төлөвлөлттэйгөөр хэрэгжүүлэх, салбар дундын хамтын ажиллагааг бий болгох, олон улсын хэмжээнд хүрэхүйц боловсон хүчин, материаллаг бааз суурьяр бэхжүүлэх зэрэг зорилгын хүрээнд 2021 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн шинэчилсэн найруулгаар батлагдсан “Соёлыг өвийг хамгаалах тухай хууль”-ийн 20.3-д “Соёлын өвийн үндэсний төв нь соёлын өвийг бүртгэх, судлах, хадгалах, сэргээн засварлах, авран хамгаалах, сурталчлах чиг үүрэг бүхий соёл, эрдэм шинжилгээний байгууллага байна.” хэмээн зааж, тус төвд “судлах”, “хадгалах”, “сурталчлах” чиг үүргийг нэмсний сацуу эрдэм шинжилгээний байгууллага байхаар тус тус заасан байна.

2021 онд шинэчлэн байгуулагдсан Соёлын яамны стратегийн чиглэлд соёлын өвийн бодлого төлөвлөлт тэргүүлэх байр суурийг эзэлж байгаагийн хувьд Соёлын өвийн үндэсний төвийг боловсон хүчин болон техник тоног төхөөрөмжөөр бэхжүүлэх, чадавхжуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, 2022 онд байгууллагын орон тоог 35 хүнээр нэмэгдүүлж, байгууллагын дүрэм, бүтцийг шинэчлэн баталсан.

2017 оны Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын А/295 дугаар тушаалаар батлагдсан бүтцэд тус төв нь:

- Захиргаа удирдлагын газар,
- Соёлын өвийн бүртгэл, судалгааны газар,
- Соёлын өвийг авран хамгаалах газар,
- Соёлын биет өвийг сэргээн засварлах газар,
- Мэдээллийн технологи, аюулгүй байдлын газар гэсэн 5 газар болон орон тооны бус Захиргааны зөвлөл, Соёлын биет өвийг таньж тогтоох шинжээчийн зөвлөл, Соёлын биет бус өв, өвлөн уламжлагчийг таньж тогтоох шинжээчийн зөвлөл, Барилга архитектурын дурсгалыг сэргээн засварлах ажилд хяналт, дүн шинжилгээ хийх шинжээчийн зөвлөл гэсэн 4 зөвлөлтэй, 30 албан хаагчтай байв.

2022 оны 1 дүгээр сарын 01-нээс мөрдөгдөж эхэлсэн “Соёлын өвийг хамгаалах тухай хууль”-ийн 20.3-д заасны дагуу тус төвийн чиг үүрэгт шинээр нэмэгдсэн “судлах”, “хадгалах”, “сурталчлах” чиг үүрэг, эрдэм шинжилгээний байгууллага болгон өргөтгөсөнтэй холбогдуулан соёлын өвийг хамгаалахтай холбоотой хууль, эрхзүйн баримт бичигт заасан чиг үүргийг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага үүссэн.

Соёлын сайдын 2022 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн А/116 тоот тушаалаар тус төвийн дүрэм, бүтцэд дараах өөрчлөлт хийж, бүтэц зохион байгуулалтыг өргөтгөсөн юм.

- Захиргаа удирдлагын газар,
- Бүртгэл, мэдээллийн газар,
- Хадгалалт хамгаалалт, технологи судалгааны газар,
- Сэргээн засварлах газар,
- Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалыг хамгаалах газар,
- Авран хамгаалах, эрсдэлийн судалгааны газар,
- Мэдээллийн технологийн газар гэсэн 7 газар болон Захиргааны зөвлөл, Эрдмийн зөвлөл, Соёлын биет өвийг таньж тогтоох шинжээчийн зөвлөл, Соёлын биет бус өв, өвлөн уламжлагчийг таньж тогтоох шинжээчийн зөвлөл, гэсэн 4 зөвлөлтэй, 65 албан хаагчтай байна.

2017 онд батлагдсан хуучин бүтцээс Үндэсний төвийн зохион байгуулалтын бүтцэд шинээр “Хадгалалт хамгаалалт, технологи судалгааны газар”, “Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалыг хамгаалах газар” гэсэн 2 газар нэмэгдэв.

Зураг 1. Соёлын сайдын 2022 оны А/116 тоот тушаалаар батлагдсан Соёлын өвийн үндэсний төвийн зохион байгуулалтын бүтэц

Үндэсний төвийн захирлын дэргэд 4 зөвлөл дор дурдсан чиглэлээр ажилладаг. Үүнд:

- **Захиргааны зөвлөл** нь байгууллагын дотоод үйл ажиллагаатай холбогдсон асуудлыг хэлэлцэж санал дүгнэлт гарган захиралд зөвлөх үүрэгтэйгээр ажиллана.
- **Эрдмийн зөвлөл** нь монгол үндэстний соёлын биет болон биет бус өвийг хадгалж хамгаалахад өөрийн орны байгаль, нийгмийн соёл, онцлогт тохирсон бүртгэл, хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалт, гамшиг эрсдэл, мэдээллийн технологийн чиглэлээр үндэсний болон бүс нутаг, олон улсын хэмжээнд суурь

болон төрөлжсөн эрдэм судлал хийх санал, төлөвлөлтийг захиралд танилцуулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүрэгтэйгээр ажиллана.

- **Соёлын биет өвийг таньж тогтоох шинжээчийн зөвлөл** нь хувь хүн, аж ахуй нэгж, хууль хяналтын байгууллагын хүсэлтээр эд өлгийн зүйлсийг соёлын өвд хамаатах эсэхийг судлан үзэж, таньж тогтоон, дүгнэлт гаргах үүрэгтэйгээр ажиллана.
- **Соёлын биет бус өв, өвлөн уламжлагчийг таньж тогтоох шинжээчийн зөвлөл** нь монгол нутагт амьдарч буй үндэстэн, угсаатны бүлгийн амьдрах хэв маяг, аж төрөх ёсны олон төрөл зүйлийн зан үйл, үйлдлийн оршин тогтнох чадавх, өвлөгдөл гээгдэл зэргийг судлан, тогтоох; олон төрлийн зан үйл, үйлдлийг үйлдэж буй хүн, өрх айл, бүлэг, хамт олныг таньж тогтоох, дүгнэлт гаргах үүрэгтэйгээр ажиллана.

2022 онд шинэчлэн зохион байгуулагдсан 7 газар тус бүрийн үйл ажиллагааг танилцуулбал:

- **Бүртгэл, мэдээллийн газар** нь соёлын биет болон биет бус өв, түүнийг өвлөн уламжлагч хүнийг таньж тогтоох, тодорхойлох; соёлын өвийг цаасан болон цахим хэлбэрээр бүртгэн, баримтжуулах; бүртгэл, тайлан мэдээг хүлээн авч улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, архивлан хадгалах; иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг үндэслэн соёлын өвийн лавлагаа мэдээллээр хангах; өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрөл, холбогдох журмын дагуу соёлын өвийг олон нийтэд сурталчлах; шат шатны бүртгэл, мэдээллийн санг арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавих; гадаад улс оронд хадгалагдаж байгаа монголын түүх, соёлд холбогдох соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх; соёлын өвийн ангилал, төрөл зүйлээр статистик мэдээлэл гаргах, тоо бүртгэл хөтлөх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжүүлнэ. Тус газарт газрын дарга, ерөнхий бүртгэл, мэдээллийн санч, түүх, соёлын үл хөдлөх дурсгал хариуцсан бүртгэл, мэдээллийн санч, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл хариуцсан бүртгэл, мэдээллийн санч, соёлын биет бус өв хариуцсан бүртгэл, мэдээллийн санч, соёлын биет бус өв хариуцсан шинжээч, баримтат өв хариуцсан бүртгэл, мэдээллийн санч, архив хариуцсан бүртгэл, мэдээллийн санч гэсэн албан тушаалд нийт 12 албан хаагч ажиллаж байна.
- **Хадгалалт хамгаалалт, технологи судалгааны газар** нь соёлын биет өвийг урт удаан хугацаанд хадгалах арга хэмжээ авах, сэргээн засварлах зорилгоор эвдрэл гэмтлийн болон материал, бүтцийг судлах, оношлох; соёлын өвд нөлөөлөх байгаль, цаг уур, хүрээлэн буй орчны судалгаа шинжилгээг судалгааны байгууллагатай хамтран хийх; соёлын биет өвийг бүтээсэн арга ажиллагаа, технологийн судалгаа хийж, соёлын өвийг хамгаалах уламжлалт мэдлэг арга ухааныг орчин үеийн шинжлэх ухааны олон талт дэвшилтэт технологитой хослуулан, олон улсын зарчим, хэм хэмжээний дагуу хамгаалах ажлыг үндэсний хэмжээнд хийж, соёлын өвийг өмчлөгч, эзэмшигч байгууллагыг хадгалалт хамгаалалтын шинжлэх ухаанд суурилсан удирдлага, мэргэжил, арга зүйгээр хангах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжүүлнэ. Тус газарт газрын дарга, ерөнхий технологич, сэргээн засварлагч, ариутгалын технологич гэсэн албан тушаалд 5 албан хаагч ажиллаж байна.

- **Сэргээн засварлах газар** нь өмчлөгч, эзэмшигчийн хүсэлтийн дагуу эвдрэл гэмтэлтэй төрөл бүрийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, археологийн малталт судалгаагаар илэрч олдсон олдвор, эд өлгийн зүйл, чулуун дурсгал зэргийг тухайн газар дээр нь болон сэргээн засварлах төрөлжсөн урлан, лаборатори, сан хөмрөгийн өрөөнд түр хадгалж, цэвэрлэх, бэхжүүлэх, сэргээн засварлах; соёлын биет өвийг авран хамгаалах, зөөж тээвэрлэх, шилжүүлэх үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх; соёлын биет өвөөс хэв, дардас авах, хуулбар хийх; музей, соёлын өвийн чиглэлийн үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагын ажилтнуудад сэргээн засварлах арга зүй, сургалт зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг хариуцан хэрэгжүүлнэ. Тус газарт газрын дарга, ерөнхий сэргээн засварлагч, уран зураг сэргээн засварлагч, монгол зураг сэргээн засварлагч, металл эдлэл сэргээн засварлагч, модон эдлэл сэргээн засварлагч, чулуун эдлэл, баримал, сэргээн засварлагч, даавуу зөөлөн эдлэл сэргээн засварлагч, арьсан эдлэл сэргээн засварлагч, танка зураг сэргээн засварлагч, цаасан эдлэл сэргээн засварлагч, сан хөмрөгч гэсэн албан тушаалд нийт 15 албан хаагч ажиллаж байна.
- **Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалыг хамгаалах газар** нь түүхэн дурсгалт барилгын хувийн хэрэг бүртгэл хөтлөх; түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын хадгалалт хамгаалалтын нөхцөл байдалд судалгаа шинжилгээ хийх; сэргээн засварлах (хүчитгэх, бэхжүүлэх) ажлыг төлөвлөх; сэргээн засварлалтын ажлын зураг төсөл, төсөв болон сэргээн засварлалтын ажил гүйцэтгэж буй явцад хяналт тавих, мэргэжлийн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, дүн шинжилгээ хийх; сэргээн засварлалт, хадгалалт хамгаалалтын чиглэлээр холбогдох байгууллагад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, уламжлалт болон орчин үеийн арга техник хосолсон дэвшилтэт технологийг нэвтрүүлэхэд хамтран ажиллах, сэргээн засварлалтын ажлын тайланг хүлээн авч, нэгтгэх, дүгнэх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжүүлнэ. Тус газарт газрын дарга, дурсгалт уран барилгын мэргэжилтэн, архитектурын зураг төслийн мэргэжилтэн албан тушаалд нийт 4 албан хаагч ажиллаж байна.
- **Авран хамгаалах, эрсдэлийн судалгааны газар** нь соёлын биет болон биет бус өвийг авран хамгаалах арга хэмжээг иргэн, аж ахуй нэгж, байгууллагын хүсэлт захиалга, төлөвлөгөөт болон цаг үеийн шаардлагаар оролцогч талуудын хамтын ажиллагаа, холбогдох эрдэм шинжилгээний байгууллагаар гүйцэтгүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах; улс, орон нутаг, байгууллагын хэмжээнд соёлын өвд сөрөг нөлөөлөх байгалийн гамшиг эрсдэл болон нийгмийн хүчин зүйлийн эрсдэлийн төрөлжсөн судалгаа, үнэлгээг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран хийж дүгнэлт гаргах; урьдчилан сэргийлэх, авран хамгаалах төлөвлөгөөг боловсруулж, дээд удирдах байгууллагад танилцуулах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжүүлнэ. Тус газарт газрын дарга, түүх, соёлын үл хөдлөх дурсгалын эрсдэлийн шинжээч, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн эрсдэлийн шинжээч, соёлын биет бус өвийн эрсдэлийн шинжээч гэсэн албан тушаалд нийт 4 албан хаагч ажиллаж байна.
- **Мэдээллийн технологийн газар** нь соёлын биет болон биет бус өвийн цахим мэдээллийн сангийн үндэсний сүлжээ, программ хангамж, серверийн хэвийн үйл ажиллагааг хангах; соёлын өвийн орон зайн мэдээлэлд суурилсан төрөлжсөн мэдээллийн сан бий болгох; соёлын өвийг гэрэл зураг, дүрс бичлэг, 3 хэмжээст

мэдээллээр баримтжуулах, соёлын биет бус өвийн “Бага театр”-ын техник хэрэгслийг хэвийн үйл ажиллагааг хангах; олон нийтэд цахим үйлчилгээ үзүүлэх, танилцуулах, сурталчлахад мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах; байгууллагын цахим төхөөрөмж, харуул хамгаалалт, аюулгүй байдлын камер, холбоо, дохиоллын системийн хэвийн үйл ажиллагааг хангах; шат шатны бүртгэл, мэдээллийн санг арга зүйгээр хангах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжүүлнэ. Тус газарт программист, газарзүйн мэдээллийн инженер, сүлжээний инженер, компьютер графикч гэсэн албан тушаалд нийт 5 албан хаагч ажиллаж байна.

- **Захиргаа, удирдлагын газар** нь байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор хүний нөөц, санхүү, хөрөнгө оруулалт, аж ахуйн үйл ажиллагааг эрхлэх; хууль эрх зүйн хүрээнд үйл ажиллагаандаа хяналт, мониторинг хийх; гадаад, дотоодын хамтын ажиллагаа тогтоох, олон нийттэй харилцах, сурталчлах зэрэг байгууллагын менежмент, маркетингийн үйл ажиллагааг зохион байгуулах; ЮНЕСКО, олон улсын байгууллагатай соёлын өвийн чиглэлээр хамтран ажиллах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулна. Тус газар нь дотроо Санхүүгийн алба, Аж ахуйн албатай, газрын дарга, албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, тооцооны нягтлан бодогч, хүний нөөц, дотоод хяналт хариуцсан ажилтан, архив, бичиг хэргийн эрхлэгч, нярав, сантехникч, цахилгаанчин, үйлчлэгч гэсэн албан тушаалд нийт 12 албан хаагч ажиллаж байна.

ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭРЭГЖИЛТ

Байгууллагын хүний нөөц ажилтны орон тоо 30 хүнээр нэмэгдсэнтэй холбогдуулан шинээр ажилд орсон ажилтнуудын ажлын байрны сонгон шалгаруулалтад Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийн үндсэн зарчим бодлогын хүрээнд зарлагдсан албан тушаалд нас, хүйсээр ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг баримтлан төрийн албаны чадахуйн (мерит) зарчмаар мэргэжил, мэдлэгийн чадвар, ажлын дадлага туршлагыг харгалзан үзэж тухайн албан тушаалд томилсон.

2022 онд Үндэсний төвд ажиллаж буй нийт 58 ажилтан, албан хаагчдын хүйсийн харьцаа тэнцвэртэй, эрэгтэй 31 (53.4%), эмэгтэй 27(46.5%) байна.

Төрийн үйлчилгээний байгууллагын ТҮ-11, ТУСУ-7, ТУСУ-6 ангиллын удирдах 11 албан тушаалтны 6 нь эрэгтэй, 5 нь эмэгтэй байгаа нь Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийн Төрийн албан дахь жендэрийн тэгш байдлын баталгааны тухай 10.1.4 дүгээр зүйлд заасан төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтны дотор хүйсийн тэгш байдлыг бүрэн ханган ажиллаж байна.

Соёлын яамнаас 2022 оны 09 дүгээр сарын 26-нд авсан Соёлын салбарт баримтлах жендэрийн стратеги, үйл ажиллагааны хүрээнд Үндэсний төвийн 21 албан хаагчдын үнэлгээний асуулга судалгааг авч жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтыг хангаж ажиллаж байгааг гэсэн үр дүн гарсан.

2.1. Хүний нөөцийн бодлого төлөвлөлтийн чиглэлээр:

Үндэсний төвийн шинэчлэгдэн батлагдсан бүтэц, зохион байгуулалт, орон тоотой уялдуулан 7-н газрын 65 орон тооны ажилтнуудын “Ажил мэргэжлийн лавлах”, “Албан тушаалын тодорхойлолт”-ыг тус тус шинэчлэн боловсруулж, Үндэсний төвийн захирлын 2022 оны А/27 дугаар тушаалаар батлан, хэрэгжилтид хяналт тавин ажиллаж байна.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын дагуу Үндэсний төвийн ажилтан албан хаагчдын хувийн хэргийн баяжилт, шинэчлэлт, хөдөлгөөнийг тухай бүр бүрэн хийж бүрдүүлж байна.

Түүнчлэн Төрийн албаны зөвлөлөөс боловсруулсан хүний нөөцийн программ /https://hrm.csc.gov.mn/, E-Mongolia академиас хөгжүүлсэн Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем /https://erp.e-mongolia.mn/-д ажилтнуудын цахим мэдээллийг шинэчлэн оруулж цахим мэдээллийн санд бүрдүүлсэн.

Төрийн албаны тухай хуулийн 3.1.3, 3.1.4 дугаар зүйлд тус тус заасанчлан чадахүйн зарчим (мерит)-ийг баримтлан шинээр бий болсон орон тоо болон сул гарсан тоонд ажлын байрны сонгон шалгаруулалтаар хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлагад тулгуурлан салбарын музей, соёлын байгууллагын ажиллагсад, их дээд сургуулийг төгсөгчдийг соёлын өвийн бүртгэл, сэргээн засварлах, хадгалалт хамгаалалт, авран хамгаалах эрсдэлийн судалгаа, барилга архитектур, мэдээллийн технологи чиглэлээр ажилд авсан байна. Үүнд:

- шинээр бий болсон албан тушаалд 20 ажилтан,
- сул гарсан орон тоон дээр 3 ажилтанг тус тус ажилд авсан.
- бүтцийн өөрчлөлтөөр 11 ажилтны албан тушаалыг өөрчлөн томилсон, чиг үүргийнхэн дагуу дотооддоо холбогдох газар нэгжид шилжүүлсэн зэрэг бүтэц, зохион байгуулалтын дагуу ажлын байрыг оновчтой тогтоон байршуулах өөрчлөлтүүд хийгдсэн.

Хөдөлмөрийн тухай хуулийн 144.2 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангаж хөгжлийн бэрхшээлтэй 2 иргэнийг үндсэн ажилтнаар ажилд томилон ажиллуулж байна.

2022 оны байдлаар тус Үндэсний төвд 58 ажилтан, албан хаагч ажиллаж байгаагийн эрэгтэй 31 (53.4%), эмэгтэй 27(46.5%) байна.

Насны ангиллаар авч үзвэл 18-24 насных-5, 25-34 насных-17, 35-44 насных-20, 45-54 насных-11, 55-59 насных-3, 60 дээш насных-2 тус тус байна (Зураг 2).



Зураг 2. Соёлын өвийн үндэсний төвийн ажилтнууд нас, хүйсний ангилал

Тус төвд 2022 онд шинээр нэмэгдэж байгаа 30 орон тоог шинэчлэн зохион байгуулагдаж буй бүтцэд хэрхэн оновчтой хуваарилсан байршуулсан талаар мэдээллийг танилцуулъя.

Орон тоог хуваарилан байршуулахдаа Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт болох “Соёл, урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, 3 дугаар хавсралт болох “Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл”-ийг тус тус баримтлан холбогдох албан тушаалын нэрээр тусгав.

Үүнд:

Бүртгэл, мэдээллийн газар	Хадгалалт хамгаалалт, технологи судалгааны газар	Сэргээн засварлах газар	Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалыг хамгаалах газар	Авран хамгаалах, эрсдэлийн судалгааны газар	Мэдээллийн технологийн газар	Захиргаа, удирдлагын газар
5	3	6	5	3	4	4

Бүртгэл мэдээллийн газарт:

- Сан хөмрөгч (архивч) 1 (ТҮСУ-5),
- Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл хариуцсан бүртгэл, мэдээллийн санч 1 (ТҮСУ-5),
- Соёлын биет бус өв хариуцсан бүртгэл, мэдээллийн санч 1 (ТҮСУ-5),
- Баримтат өв хариуцсан бүртгэл, мэдээллийн санч 1 (ТҮСУ-5),
- Соёлын өвийн шинжээч 1 (ТҮСУ-5) нийт 5.

Хадгалалт хамгаалалт, технологи судалгааны газарт:

- Ариутгалын технологич (химич) 1 (ТҮСУ-4),
- Сэргээн засварлагч 2 (ТҮСУ-5), нийт 3.

Сэргээн засварлах газарт:

- Сан хөмрөгч 1 (ТҮСУ-5),
- Чулуу сэргээн засварлагч 1 (ТҮСУ-5),

- Даавуу зөөлөн эдлэл сэргээн засварлагч 1(ТҮСУ-5) ,
- Арьсан эдлэл сэргээн засварлагч 1(ТҮСУ-5) ,
- Танка зураг сэргээн засварлагч 1 (ТҮСУ-5),
- Цаасан эдлэл сэргээн засварлагч 1 (ТҮСУ-5), нийт 6.

Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалыг хамгаалах газарт:
- Нэгжийн дарга 1 (ТҮСУ-6) ,
- Инженер 1 (ТҮСУ-4),
- Дурсгалт уран барилгын мэргэжилтэн 2 (ТҮСУ-4),
- Архитектурын зураг төслийн мэргэжилтэн 1(ТҮСУ-4), нийт 5.

Авран хамгаалах, эрсдэлийн судалгааны газарт:
- Түүх, соёлын үл хөдлөх дурсгал хариуцсан шинжээч 1 (ТҮСУ-5),
- Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл хариуцсан шинжээч 1 (ТҮСУ-5),
- Соёлын биет бус өвийн шинжээч 1 (ТҮСУ-5), нийт 3.

Мэдээллийн технологийн газарт:
- Нэгжийн дарга 1 (ТҮСУ-6),
- Программист 1 (ТҮСУ-5),
- Сүлжээний инженер 1 (ТҮСУ-5),
- Компьютер графикч 1 (ТҮСУ-4), нийт 4.

Захиргаа, удирдлагын газарт:
- Хүний нөөцийн ажилтан 1 (ТҮ-7),
- Олон нийттэй харилцах ажилтан 1 (ТҮ-7),
- Төрийн үйлчилгээний төсвийн байгууллагын мэргэжилтэн 1 (ТҮ-7),
- Төрийн үйлчилгээний төсвийн байгууллагын зохион байгуулагч 1 (ТҮ-6), нийт 4.

Шинээр нэмэгдэж буй 30 орон тоог байршуулахад ТҮСУ-4 зэрэглэлд 6 албан тушаал, ТҮСУ-5 зэрэглэлд 18 албан тушаал, ТҮСУ-6 зэрэглэлд 2 албан тушаал, ТҮ-6 зэрэглэлд 1 албан тушаал, ТҮ-7 зэрэглэлд 3 албан тушаалтан тус тус хамрагдав.

Соёлын өвийн үндэсний төвийн бүтэц, зохион байгуулалтыг шинэчилснээр дараах үр дүн гарна. Үүнд:

- Салбарт өмнө нь огт байгаагүй соёлын биет өвийн хадгалалт хамгаалалтыг технологи, материал, бүтцийн судалгаа, эвдрэл гэмтлийн оношилгооны төрөлжсөн лаборатори бий болж, сэргээн засварлалын өмнөх урьдчилсан суурь судалгаа хийгдэх болсон.

- Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалыг сэргээн засварлах ажлыг хувийн хэвшилд шилжүүлсэн 30 орчим жилд энэ төрлийн үйл ажиллагаа уналтад орсныг сэргээх зорилгоор тус төвийн дэргэд мэргэжлийн баг ажиллуулж, сэргээн засварлалттай холбоотой бүх үе шатанд зөвлөн туслах, хянах, хамтран ажиллах чиглэлийг бий болгосон нь хувийн хэвшил, төрийн болон мэргэжлийн байгууллагын хамтын ажиллагаанд ахиц дэвшил гарна.

- Соёлын өвийг байгалийн гамшиг эрсдэл, байгалийн болон нийгмийн хүчин зүйлийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, авран хамгаалах чиглэлээр

тусгайлсан нэгж байгуулсан нь олон улсын соёлын өвийг хамгаалах эрх зүйн бичиг баримттай нийцэж, олон улсын түвшинд хүрэх алхмыг хийсэн байна.

- Соёлын биет өв болох чулуу, цаас, арьсан эдлэлийг сэргээн засварлахад шинэ ажлын байр, орон тоо бий болгосон нь энэ төрлийн соёлын өвийн хадгалалт хамгаалалтад сайнаар нөлөөлж, сэргээн засварлагдах үзмэрийн тоо, чанарын үзүүлэлтэд сайнаар нөлөөлж байна.
- Соёлын өвийн цаасан болон цахим мэдээллийн сангийн бүртгэл хөтлөлт, хадгалалт, мэдээллийн системийн аюулгүй байдалд тоон болон чанарын үзүүлэлтэд ахиц дэвшил гарна.
- Соёлын өвийг хамгаалах хуулиар хүлээсэн чиг үүргийг биелүүлэхэд энэхүү шинэчилсэн бүтэц нь цаг үеэ олсон нэн чухал хэрэгцээтэй бөгөөд тус байгууллагын шинэ байрны ашиглалт, гадаад дотоодын судалгааны байгууллага, судлаачидтай хамтран ажиллахад олон улсын хэм хэмжээнд нийцсэн гэдгээрээ онцлогтой байна.

2.2. Хүний нөөцийг хөгжүүлэх сургалтын талаар

Соёлын өвийн үндэсний төвийн нийт ажилтнуудаас эрдмийн зэрэгтэй 16 (27.5%) ажилтны доктор Ph.D 4, магистр 12 байна. Бакалаврын зэргийн боловсролтой 35 ажилтан (60%), бусад 7 (12%) ажилтан тус тус байна.

Соёлын өвийн бүртгэл мэдээлэл, сэргээн засварлалт, хадгалалт хамгаалалтын чиглэлээр ажилтнуудын мэдлэг, эрдмийн зэргийг дээшлүүлэхэд анхаарч Соёл, урлагийн их сургууль, Монгол Улсын их сургууль, БНСУ-ын Кенхеогийн их сургуулт зэрэг их дээд сургуулиудын докторантурт 3 ажилтан, Соёл, урлагийн их сургууль, Монгол Улсын их сургууль, ШУТИС зэрэг их сургуулиудын магистрантурт 6 ажилтан тус тус суралцаж байна.



Зураг 3. Соёлын өвийн үндэсний төвийн ажилтнууд эрдмийн болон боловсролын зэргийн байдал

2022 онд Үндэсний төвийн ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн сургалт хөгжлийн хүрээнд мэргэшүүлэх 2 сургалт, ажлын байран дахь хөгжүүлэх 5 сургалт, хууль эрх зүй, бодлогын баримт бичигтэй холбоотой 2 сургалтад тус тус ажилтан, албан хаагчдыг чиг үүргийнхэн дагуу хамруулсан байна.

Мэргэшүүлэх чиглэлээр:

- ОХУ-д “Уран зургийн сэргээн засварлалт” богино хугацааны сургалтад 2 ажилтан;
- Архив, албан хэрэг албан хэрэг хөтлөлтийн сургалтад 2 ажилтан;
- “Соёлын боловсролын үндэсний сургагч” багш бэлтгэх сургалтад 1 ажилтан.

Ажлын байран дахь хөгжүүлэх сургалтын хүрээнд:

- Монгол бичгийн мэдлэгийг дээшлүүлэх "анхан" болон "ахисан" түвшний шаталсан хэлбэрээр 2 удаа зохион байгуулсан сургалтад 53 (давхардсан тоогоор) ажилтан;
- БНСУ-ын Соёлын өвийн судалгааны үндэсний төвөөс мэргэжилтэн урьж, “Чулуун соёлын өвийн хадгалалт хамгаалалт” сургалтад 26 ажилтан;
- Япон улсын Токио хотын хадгалалт хамгаалалтын хүрээлэнгийн мэргэжилтнүүдтэй хамтран "Музейн орчин дахь органик хүчлийн нөлөө болон түүнээс сэргийлэх аргачлалын тухай" сэдэвт цахим сургалт сургалтад 27 ажилтан;
- “Соёлын өвийн хадгалалт хамгаалалтад хэрэглэж байгаа химийн бодис, бодистой ажиллах аюулгүй ажиллагаа” сургалтад 27 ажилтан;
- Япон улсын Тохоку Урлагийн их сургуультай хамтран “Трехалос сахарын уусмалыг соёлын өвийн хадгалалт хамгаалалтад ашиглах нь” сургалт 27 ажилтан;
- Үндэсний төвийн шинэ ажилтнуудад зориулсан “Соёлын өвийн үндэсний төвийн үйл ажиллагаа, чиг үүрэг” танилцуулах 2 удаагийн сургалтад 28 ажилтан.
- Хууль, эрх зүй, бодлогын баримт бичигтэй холбоотой сургалтын хүрээнд:
- Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хүрээнд “Алсын хараа”-2050 “Шинэ сэргэлтийн бодлого” цахим, танхим хосолсон сургалтад 2 ажилтан сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан.
- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4.1.1.10.3-т заасан “Авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулах” зорилтын хүрээнд яамны болон харьяа байгууллагын албан хаагчдад авлигын эсрэг хууль тогтоомж, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор Соёлын яам, Авлигатай тэмцэх газартай хамтран зохион байгуулсан 1 удаагийн цахим сургалтад байгууллагын ажилтнууд бүрэн хамрагдсан.

2.3. ТҮСУ, ТҮ-ийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиглэлээр:

- Соёлын яамнаас ажлын албан хэрэгцээнд 29ш, Дорноговь аймгийн музей 2ш, Дундговь аймгийн музей 3ш ном тус тус нийт 34 ш ном хандиваар ирж байгууллагын номын санд ажилтнуудын албан хэрэгцээнд ашиглаж байна.

- ХБНГУ-ын Макс Планкийн хүрээлэнгийн МАРЗЗ төслийн судалгааны багтай хамтран археологийн дурсгалын мэдээллийн сан үүсгэх төслийн хүрээнд I7 компьютер 1ш, 27 inch дэлгэц 2ш, өнгөт принтер 1ш, хурдан скайнер 1ш, сата хард

4тв 2ш, зөөврийн хард 2тв 2ш, зөөврийн хард 1тв 1ш тус тус нийт 10 ширхэг техник тоног төхөөрөмжөөр хангаж соёлын өвийн бүртгэл баримтжуулалтад ашиглаж байна.

- БНТУ-ын Олон улсын хамтын ажиллагаа, зохицуулах агентлаг (ТИКА)-гийн тусламжаар “Чулуун дурсгалыг сэргээн засварлах лаборатори”-ийг байгуулж, уг лабораторид “бичил цаг уурын төхөөрөмж”, төрөл бүрийн “хэмжигч багажууд”, “вакумжуулж хөлдөөж хатаагч төхөөрөмж”, “зөөврийн компьютер”, “хэт авианы хэмжилтийн багаж”, “чулууны дотоод хагарал, цуурлыг хэт авиагаар хэмжигч багаж”, “хэт улаан туяаны дижитал камер”, “мульти спектрийн камер дрон”, “гар өргөгч”, “лазер цэвэрлэгээний төхөөрөмж” зэрэг 15 төрлийн орчин үеийн багаж, тоног төхөөрөмжүүдийг хандивласан юм. “Чулуун дурсгалыг сэргээн засварлах лаборатори”-ийг байгуулснаар хадны зураг бичээс, хүн болон буган чулуун хөшөө зэрэг эртний чулуун дурсгалын хадгалалт хамгаалалтын орчныг судалгаа хийх, сэргээн засварлах бэхжүүлэх ажлын хүчин чадлыг нэмэгдүүлж, ажиллах орчин нөхцөл хангагдаж байна.

- Ажилтнуудын хандив санаачлагаар өргөлт, суниалтын спорт дасгалын 170 кг-ын штанг, вандан сандал, тавиур зэрэг тоног төхөөрөмжөөр байгууллагын биеийн тамир, фитнессийн өрөөг нэмж тохижуулан, ажилтнуудын чөлөөт цаг, спортын арга хэмжээнд хэрэглэж байна.

- Хоол 106,528,000 төгрөг, унааны зардалд 24,848,000 төгрөг, нийт 131, 376, 000 төгрөг зарцуулсан;

- Ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах арга хэмжээнд 41,703,500 төгрөг зарцуулсан.

2.4. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах талаар:

Соёлын өвийн үндэсний төв нь хэвлэл, мэдээлэл олон нийттэй нээлттэй харилцан ажиллаж байна. Соёлын биет ба биет бус өвийг олон нийтэд таниулах, сурталчлах, Монголын түүх, соёл, уламжлалт өвийн танин мэдэхүйн контент, мэдээллийг олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулж байна. Соёлын өвийн үндэсний төвийн албан ёсны https://www.youtube.com/ суваг, www.ncch.gov.mn вэб сайт, https://www.facebook.com/ncch.gov.mn нүүр хуудсаар болон МҮОНТВ, МҮОНТР болон чөлөөт хэвлэл, хувийн хэвшлийн телевиз, радио, цахим сайт, өдөр тутмын тогтмол хэвлэл, редакци зэрэг 20 гаруй байгууллагатай хамтран ажиллаж давхардсан тоогоор нийт 100 гаруй удаагийн ярилцлага, мэдээлэл, контентыг давхардсан тоогоор 3000 гаруй иргэдэд сурталчилсан байна.

1. Монголын Урлагийн Зөвлөлийн дэмжлэг, “Рио Тинто” ХХКомпанийн 400 сая төгрөгийн санхүүжилтээр “Өв Эрдэнэ” театрын интерьер дизайныг “Спринт Архитект” зураг төслийн компани боловсруулж, “Рэдлайн ХХК” дотоод заслын ажил гүйцэтгэж, тайзны гэрэлтүүлгийг D-Light компани, дуу хөгжмийн тоног төхөөрөмжийг “ITC Solution ХХК” суурилуулж 2022 оны 7 дугаар сарын 5-нд ашиглалтад хүлээлгэн өгсөн. Нээлтийн үеэр театрын үндсэн үйл ажиллагааг олон нийтэд түгээх, сурталчлах телевиз, хэвлэл мэдээлэлийн 20 байгууллага оролцсон бөгөөд олон нийтэд цахим сүлжээгээр шууд дамжуулав.

2. Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн нутагт орших "улс" болон "аймгийн" хамгаалалтын жагсаалтад бүртгэгдсэн түүх, соёлын 30 үл хөдлөх дурсгалын тухай

контент хийж, сар бүр 3 хүртэлх контентыг олон нийтэд нийгмийн цахим сүлжээгээр түгээсэн.

3. Монголын Бурханы Шашинтны Төв Гандантэгчэнлин хийдэд хадгалагдаж буй түүх, соёлын хосгүй үнэт 5 дурсгалт зүйл (Очирдара 2ш, Майдар 2ш, Сосорбарам)-ийн 1-3 минутын дүрс бичлэг, тайлбар бүхий видео контентыг бэлтгэн олон нийтэд GTV сувгаар сурталчилж байна.

4. ЮНЕСКО-д бүртгэгдсэн соёлын биет бус өвийн Төлөөллийн болон Яаралтай хамгаалах шаардлагатай 15 өвийн зүйл, соёлын биет бус 15 өв нийт 30 өв тус бүр 3 хүртэлх минутын видео танилцуулгыг боловсруулж байгууллагын албан ёсны www.youtube.com сувгаар дамжуулан олон нийтэд хүргэсэн.

5. Монголын МҮОНТВ-ийн “Өглөө хөтөлбөр” шууд нэвтрүүлэгт соёлын өвийн танилцуулга, хамгаалах ач холбогдолын тухай 3 удаагийн цуврал ярилцлага, МҮОНТВ-ийн “Өв Эрдэнэ” нэвтрүүлэгт 2 удаагийн ярилцлага, Зууны мэдээ сонинд 14 хоног тутам соёлын өвийн мэдээ, мэдээлэл бэлтгэн өгч, соёлын өвийг сурталчлав.

6. Монгол Улсын Соёлын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газраас зохион байгуулсан “Нүүдэлчин Монгол 2022” Соёлын биет бус өвийн наадмын хүрээнд “Соёлын өвийн хүрээ” – “Нүүдлийн соёл иргэншлийн үнэт зүйлс- Хүн төрөлхтний соёлын биет бус өв” өргөөг олон нийтэд танилцуулан сурталчилсан.

7. Олон улсын түвшинд ЮНЕСКО-гийн ивээл дор II зэрэглэлийн төв болох Ази-Номхон далайн бүс нутгийн Соёлын биет бус өвийн мэдээлэл, хамтын ажиллагааны төвийн IchLinks www.ichlinks.com портал дээр байршуулан түгээн сурталчилж байна.

8. “Монгол Улсын баримтат өвийн бүртгэл”-д нэр дэвшүүлэх дурсгалыг бүртгэх аргачлал гарын авлагыг боловсруулж, хянуулж хэвлэхэд бэлэн болгосон. Цаасны хэмжээ А/6 86 нүүр бүхий аргачлал, зөвлөмж багтаж байгаа бөгөөд 2022 онд багтаж Соёлын яамны санхүүжилтээр хэвлэгдэнэ. Уг “Монгол Улсын баримтат өвийн бүртгэл”-д нэр дэвшүүлэх дурсгалыг бүртгэх аргачлал гарын авлагын цахим хувилбарыг тус Үндэсний төвийн ncch.gov.mn цахим хуудсанд байршуулсан.

2.5. Жендерийн эрх тэгш байдлын талаар:

Байгууллагын хүний нөөц ажилтны орон тоо 30 хүнээр нэмэгдсэнтэй холбогдуулан шинээр ажилд орсон ажилтнуудын ажлын байрны сонгон шалгаруулалтад Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийн үндсэн зарчим бодлогын хүрээнд зарлагдсан албан тушаалд нас, хүйсээр ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг баримтлан төрийн албаны чадахуйн (мерит) зарчмаар мэргэжил, мэдлэгийн чадвар, ажлын дадлага туршлагыг харгалзан үзэж тухайн албан тушаалд томилсон.

2022 онд Үндэсний төвд ажиллаж буй нийт 58 ажилтан, албан хаагчдын хүйсийн харьцаа тэнцвэртэй, эрэгтэй 31 (53.4%), эмэгтэй 27(46.5%) байна.

Төрийн үйлчилгээний байгууллагын ТҮ-11, ТУСУ-7, ТУСУ-6 ангиллын удирдах 11 албан тушаалтны 6 нь эрэгтэй, 5 нь эмэгтэй байгаа нь Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийн Төрийн албан дахь жендэрийн тэгш байдлын баталгааны

тухай 10.1.4 дүгээр зүйлд заасан төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтны дотор хүйсийн тэгш байдлыг бүрэн ханган ажиллаж байна.

Соёлын яамнаас 2022 оны 09 дүгээр сарын 26-нд авсан Соёлын салбарт баримтлах жендэрийн стратеги, үйл ажиллагааны хүрээнд Үндэсний төвийн 21 албан хаагчдын үнэлгээний асуулга судалгааг авч жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтыг хангаж ажиллаж байгааг гэсэн үр дүн гарсан.

ГУРАВ. СОЁЛЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛСАН ҮЙЛ АЖИЛЛАГАА

БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Соёлын яамны Стратеги төлөвлөгөө 2021-2024-ийн хэрэгжилтийг хангах.

Зорилт 1. Соёлын салбарын мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн мэдээллийг “Цахим соёл” арга хэмжээ, “GLAM” системтэй холбох, системийг ашиглалтад оруулахад соёлын өвийн бүртгэл, мэдээллээр хангаж ажиллана.

1.1.*“GLAM системийн нэгдсэн хөгжүүлэлт” нэгдсэн системд хөгжүүлэхэд хамтран оролцоно.*

Соёлын яамны Цахим бодлого, мэдээллийн технологийн хэлтэс болон бусад оролцогч талуудтай хамтарсан уулзалтыг 2 удаа хийж, GLAM системийн хэрэглэгчийн шаардлага тодорхойлох баримт бичигт орох соёлын өвийн бүртгэлд холбогдох тодорхой санал өгөв. Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн цахим системтэй холбогдон ажиллах боломжтой байхаар техникийн баримт бичигт тусгуулав.

Улс, аймгийн музейн REGISTER программд бүртгэгдсэн 102.242 дэсийн 216.219 ширхэг (үүнээс улсын 9 музейн 57.688 дэсийн 120.680 ширхэг, аймаг орон нутгийн 24 музейн 44.554 дэсийн 95.539 ширхэг) үзмэр, эд өлгийн зүйлийн мэдээллийг цэгцлэн “GLAM” системд хөрвүүлэх бэлтгэл ажлыг хангаад байна. GLAM системд хөрвүүлэгдэх улсын болон аймаг, орон нутгийн музейн нэр, хөдлөх дурсгалт зүйлийн тоон дүнг дараах хүснэгтээр үзүүлэв (Хүснэгт 1).

Хүснэгт 1. GLAM системд хөрвүүлэгдэхэд бэлэн болсон улс аймаг, орон нутгийн музейн нэр, хөдлөх дурсгалт зүйлийн тоон дүн.*

Д/д	Байгууллагын нэр	Дэс	Тоо ширхэг
Улсын 9 музей			
1	Монголын үндэсний музей	20433	60172
2	Байгалийн түүхийн музей	11083	13799
3	Богд хааны ордон музей	4209	8643
4	Чойжин ламын сүм музей	1001	6384
5	Дүрслэх урлагийн музей	10008	16808

* *Чингис хаан музейн сан хөмрөгт хадгалагдаж буй түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тоон дүн тайлант хугацаанд эцэслэгдэж гараагүй болно.*

6	Уран зургийн галлерей	3472	3731
7	Театрын музей	6620	9588
8	Хархорум музей	717	1380
9	Хөшөө цайдам музей	145	175
Аймаг, орон нутгийн 24 музей			
1	Архангай аймгийн музей	1733	3941
2	Баян-Өлгий аймгийн музей	1393	5385
3	Баянхонгор аймгийн музей	4427	10618
4	Булган аймгийн музей	2618	4978
5	Говь-Алтай аймгийн музей	2507	2539
6	Говьсүмбэр аймгийн музей	744	1020
7	Дархан-Уул аймгийн музей	969	1362
8	Дорноговь аймгийн музей	2282	5668
9	Дорнод аймгийн музей	2010	4142
10	Дундговь аймгийн музей	3401	4915
11	Завхан аймгийн музей	2454	10501
12	Орхон аймгийн музей	1266	1742
13	Өвөрхангай аймгийн музей	1210	2396
14	Өмнөговь аймгийн музей	1225	2769
15	Сүхбаатар аймгийн музей	1333	2297
16	Сэлэнгэ аймгийн музей	2268	3199
17	Төв аймгийн музей	2954	5623
18	Увс аймгийн музей	2761	5801
19	Ховд аймгийн музей	929	3028
20	Хөвсгөл аймгийн музей	1877	3711
21	Хэнтий аймгийн музей	1212	2127
22	Улаанбаатар хотын музей	780	3425
23	Дорнод.Ялалт музей	391	491
24	Өвөрхангай.Эрдэнэ Зуу музей	1810	7345

Зорилт 1.2 Монгол бичгийг нийтийн болон албан хэргийн түвшинд хэрэглэж хэвшүүлэх ажлыг эхлүүлнэ. (Соёлын яамны Стратеги төлөвлөгөө 2021-2024-ийн Стратегийн зорилт 4, Монгол бичгийн үндэсний хөтөлбөр)

1.2. *Байгууллагын ажилтан, албан хаагчдын Монгол бичгийн мэдлэгийн түвшинг дүгнэж, анхан болон түвшин ахиулж, монгол бичгээр уншиж, бичиж сурсан байна.*

Нийт ажилтнуудын Монгол бичгийн мэдлэгийн талаарх судалгааг авч судалсны үндсэн дээр Монгол бичгийн хичээлийн хөтөлбөр, удирдамж боловсруулж, Үндэсний төвийн захирлаар батлуулан 2 удаа сургалт зохион байгуулсан. Эхний сургалт 2022.03.07-04.28-ны хооронд "анхан" болон "ахисан" түвшний шаталсан хэлбэрээр зохион байгуулагдсан ба “анхан” шатны сургалтын 9 цагийн хичээлд 18 ажилтан, “ахисан” түвшний 8 цагийн хичээлд 28 (давхардсан тоогоор) ажилтан хамрагдсан.

Соёлын сайдын 2022 оны А/116 дугаар тушаал батлагдсантай холбогдуулан байгууллагын ажилтны орон тоо 35 хүртэл хүнээр нэмэгдсэн ба шинээр ажилд орсон ажилтнуудаас Монгол бичгийн мэдлэг, чадвараа сайжруулах шаардлагатай

25 ажилтанг хамруулсан 2 дахь удаагийн “ахисан” түвшний 11 цагийн цагийн сургалт 2022.11.21-12.15-ны хооронд зохион байгуулагдаж байна.

Монгол хэл, бичгийн мэргэжлийн багшийн заасан Монгол бичгийн “анхан” шатны түвшний нийт 9 цагийн сургалтад 18 ажилтан, “ахисан” түвшний нийт 19 цагийн сургалтад 53 (давхардсан тоогоор) ажилтан тус тус хамрагдав. Хоёр удаа зохион байгуулсан дээрх сургалтад нийт ажилтнууд 100% хамрагдан Монгол бичгээр унших, бичих мэдлэгээ ахиулан амжилттай сайн суралцлаа.

Нийт 10 долоон хоног зохион байгуулагдсан сургалтын чанар, үр дүнг “цээж бичиг”, “хуулан бичлэг”, “уншлага” зэрэг хичээлээр дүгнэхэд ажилтнуудын Монгол бичгээр унших, бичих мэдлэг чадвар жигд дээшилсэн үр дүнтэй арга хэмжээ болсон. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа 2050"-ын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 1.3 дугаар зорилтыг хэрэгжилтийн бэлтгэл ажил хангаж Монгол бичгийг нийтийн болон албан хэргийн түвшинд хэрэглэж хэвшүүлэх ажлыг эхлүүлж ажилтнуудын дунд “сайхан монгол бичигтэн”-г шалгаруулах, албан нэрийн хуудас, байгууллагын албан өрөө тасалгааны хаягжилтыг хос бичгээр хийгээд байна.

Зураг 4. Монгол бичгийн сургалт

ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД:

Зорилт 2.1. Төрийн байгууллага, аймгийн Соёлын газар, үндэсний, улсын, бүс нутгийн музей, судалгааны байгууллагатай хамтран улсын хэмжээнд соёлын өвийн бүртгэл, судалгаа, баримтжуулалтын ажлыг хамтран зохион байгуулна. (СӨХ тухай хуулийн 23.2)

2.1.1. *Улсын хэмжээнд 2021-2022 онд шилжилт хөдөлгөөнд орсон соёлын өвийн тоон дүн, мэдээг салбарын хэмжээнд нэгтгэн, Соёлын яаманд тайлагнах ажлыг зохион байгуулна.*

Соёлын өвийн үндэсний төвийн соёлын өвийн бүртгэл, мэдээллийн газар “Соёлын өвийг хамгаалах тухай хууль”-ийн 23.2 дахь заалтыг хэрэгжүүлэх, эрх бүхий байгууллага, хуулийн этгээд, олон нийтийг үнэн зөв мэдээллээр хангах зорилгоор соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн 2021 оны тоон дүнгийн мэдээллийг нэгтгэх ажлыг 2022 оны 1 дүгээр улиралд зохион байгуулаа. Соёлын өвийн тоон дүн мэдээг түүх, соёлын үл хөдлөх дурсгал, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, соёлын биет бус өв, өвлөн уламжлагч гэсэн соёлын өвийн 3 ангиллын дагуу нэгтгэв.

2021 онд Монгол Улсын хэмжээнд:

- Түүх, соёлын үл хөдлөх 195 дурсгалт газрын 1127 дурсгал,

- Музейн сан хөмрөгт (2,635,265,304 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий) 1192 дэсийн 1829 ширхэг түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл,
- Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч 340 хүн шинээр тус тус бүртгэгдэв.

2022 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд:

- 21 аймгийн 330 сум, нийслэлийн 9 дүүргийн нутаг дэвсгэрт 10843 дурсгалт газрын 90998 түүх, соёлын үл хөдлөх дурсгал,
- Нийтийн өмчийн 317 байгууллагын 139714 дэсийн 329279 ширхэг (144,082,452,290 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий) түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл,
- 21 аймаг, нийслэлийн бүртгэл, мэдээллийн санд соёлын биет бус 362 өвийн 11189 өвлөн уламжлагчийн мэдээлэл бүртгэгджээ.

Энэхүү ажлын үр дүнд музей, аймаг, нийслэл болон улсын хэмжээний соёлын өвийн тоон статистик дүн мэдээний нэгтгэл бий болж, улсын хэмжээний соёлын өвийн шилжилт хөдөлгөөн, хадгалалт хамгаалалт, ашиглалтын байдлын нэгдсэн, бодит судалгаа гарч, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 23.2, 32.2.3 дахь заалт хэрэгжиж байна.

Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн 2021 оны соёлын өвийн тоон дүн мэдээний тайланг Соёлын яам, холбогдох байгууллагад хүргүүлж, www.ncch.gov.mn цахим системд байршуулж олон нийтэд мэдээллийг нээлттэй түгээн сурталчилж байна.

Зураг 4. Аймаг, нийслэлийн БМСангаас ирүүлсэн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэлийн мэдээний тоон дүнгийн график үзүүлэлт.

Зураг 5. 2021 оны Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тоон дүнгийн үзүүлэлт.



Зураг 6. Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үзүүлэлт.

2.1.2. *Төвийн болон Хангайн бүсийн 5 аймгийн Соёлын газартай хамтран соёлын өвийн УНБМСан дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалын мэдээллийн санг бүртгэл судалгаа, гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулж, баяжуулна.*

Тухайн ажлын хүрээнд Дундговь, Дорноговь, Увс аймгийн нутагт орших түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудыг гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулах ажлыг "Монголын баялаг, өв соёл" ХХК-тай хамтран хэрэгжүүлж буй "Монголын баялаг 330" төсөлтэй уялдуулан зохион байгуулав. Энэхүү баримтжуулалтын ажилд

- Дорноговь аймгийн нутагт орших Улсын хамгаалалтын 6 дурсгал, Аймаг, нийслэлийн хамгаалалтын 25 дурсгал, хамгаалалтын зэрэглэлд багтаагүй 18 дурсгал,
- Дундговь аймгийн нутагт орших Улсын хамгаалалтын 6 дурсгал, Аймаг, нийслэлийн хамгаалалтын 30 дурсгал, хамгаалалтын зэрэглэлд багтаагүй 15 орчим дурсгал,
- Увс аймгийн нутагт орших Улсын хамгаалалтын 5 дурсгал, Аймаг, нийслэлийн хамгаалалтын 4 дурсгал, хамгаалалтын зэрэглэлд багтаагүй 15 орчим дурсгал нийт 124 түүх соёлын үл хөдлөх дурсгалыг гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулсан.

Уг ажлын үр дүнд дүрс бичлэг, гэрэл зургийн 10 ТВ цахим файлаар СӨУНБМСан баяжигдсан, тайлант хугацаанд Дорноговь аймгийн нутаг дэвсгэр

орших түүх, соёлын 49 дурсгал мэргэжлийн тайлбар, дүрс бүхий контент хэлбэрээр олон нийтэд хүрч, сурталчлагдав. Цаашид баримтжуулалтад хамрагдсан бусад дурсгалын контентыг үе шаттайгаар олон нийтэд хүргэнэ.

Зураг 7. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэн, баримтжуулалтын явц

2.1.3. *Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын байршлын орон зайн мэдээллийг аймгийн Соёлын газартай хамтран газар зүйн мэдээллийн системд оруулан улсын тусгай хэрэгцээний ангилалд оруулах бэлтгэл ажлыг хийж, Соёлын яаманд хүргүүлсэн байна.*

Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын байршлын орон зайн мэдээллийг аймгийн Соёл, урлагийн газартай хамтран газар зүйн мэдээллийн системд оруулан улсын тусгай хэрэгцээний ангилалд оруулах бэлтгэл ажлыг хийж, Соёлын яаманд хүргүүлэв.

Улсын хамгаалалтад байх түүх соёлын үл хөдлөх дурсгалын хамрах хүрээний бүсийг тогтоосноор тухайн дурсгалт газрын мэдээллийг улсын газрын мэдээллийн нэгдсэн сангийн дундын мэдээллийн санд оруулж, хадгалалт хамгаалалт, эвдрэл гэмтлийг тодорхойлж, аялал жуулчлалын бүтээгдэхүүнд ашиглах, хамгаалалтыг сайжруулах хэлбэр юм. Түүх соёлын үл хөдлөх дурсгал, дурсгалт газар нь газрын харилцаатай хоршин ажиллах тал дээр уялдаа муу байгаа тул энэ ажлын хүрээнд Засгийн газрын тогтоолоор батлагдсан ТСҮХД-ын 197 дурсгалт газрын 214 ширхэг дурсгал, дурсгалт газрын орон зайн мэдээллийг газрын мэдээллийн санд оруулах ажлын эхлэл болов. Засгийн газрын 2020 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан Улсын хамгаалалтад байх ТСҮХД-ын жагсаалтыг дотор нь 3 ангилж үзэв.

Үүнд:

- Засгийн газрын тогтоолоор баталсан хамгаалалтын бүс татсан,
- Дэлхийн өвд бүртгэгдсэн,
- Улсын хамгаалалтад орсон хамгаалалтын бүс тогтоогдоогүй.

Засгийн газрын тогтоолоор баталсан хамгаалалтын бүс тогтоосон болон Дэлхийн өвд бүртгэгдсэн зарим ТСҮХД-ыг Тусгай хамгаалалтай газар нутгийн хуулийн нэгдүгээр бүлэг 3 дугаар зүйлийн ангилал, мөн тус хуулийн тавдугаар бүлэг 23 дугаар зүйлд заасны дагуу түүх, соёлын дурсгалт газар ангилалд оруулахад бэлтгээд байна. Хамгаалалтын бүсгүй улсын хамгаалалтад орсон дурсгалт газрын хамрах хүрээг эрх бүхий байгууллага болон, орон нутгийн соёл урлагийн газруудтай хамтран тогтоож хилийн бүсийг зураглав. Газрын тухай хуулийн хоёрдугаар бүлгийн 10 дугаар зүйлийн 10.1.6 тусгай хэрэгцээний газар ангилал, 16 дугаар зүйлийн 16.1.1 болон 16.1.15 заасны дагуу газрын нэгдмэл санд авах, хамгаалалтын бүсийг тогтоохдоо соёлын өвийг хамгаалах тухай хуулийн наймдугаар бүлэг 45 дугаар зүйлийг 45.1-д заасны дагуу хуулийн дагуу хамгаалалтын бүс тогтоож шалгуур үзүүлэлтийн дагуу тус батална.

Улсын хамгаалалтад орсон дурсгал, дурсгалт газрын орон зайн анхан шатны мэдээллийг үүсгэхдээ Google Eart болон ArcGis Earth ашиглан байршлын мэдээллийг тодруулж, анхан шатны хамрах хүрээг тодорхойлсны дагуу дурсгалт газрыг зайнаас тандан дунд нарийвчлалын Landsat-8 болон Senitel хиймэл дагуулын зураг, OpenStreetmap-ын нарийвчлал сайтай сансрын зураг ашиглан хамрах хүрээг тодруулан Газарзүйн мэдээллийн системын програм хангамж ArcGIS ашилган зураглаж оронзайн мэдээллийг бий болгов.

Дээрх ажлын хүрээнд өмнөх бэлтгэсэн оронзайн мэдээллийг 21 аймгийн соёл урлагийн газарт 1/120 тоот албан бичгээр Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хамгаалалтын бүсийн байршлын орон зайн мэдээллийг орон нутгийн газар олголттой давхадсан эсэх, засварлах санал авах тухай хүргүүлсэн. 2022 оны 6 сарын 1 хүртэл албан бичгийн хариуд 17 байгууллагаас хариу ирүүлэв. Мэдээллийг газарзүйн мэдээллийн системын програм хангамж ашиглан засварлан зураглаж орон зайн мэдээллийг Улсын хамгаалалтын жигсаалтын хувьд батлагдсан хамгаалалтын бүстэй болон хамгаалалтын бүсгүй хэмээн ангилан орон зайн мэдээлэл үүсгэв.

Хамгаалалтын бүсгүй 187 дурсгалт газар, хамгаалалтын бүс тогтосон дурсгалт газар нь Чулуун соёл өв хөтөлбөр, Дэлхийн өвд бүртгэгдэн, Засгийн газрын тогтоолоор батлагдсан хамгаалалтын бүс татсан улсын хамгаалалтын жагсаалтад орсон 26 дурсгалт газрын нийт 213 дурсгалт газрын орон зайн мэдээллийг үүсгээд байна.



Зураг 8. 1. Соёлын өвийн орон зайн мэдээлэл 2. Газрын харилцааны орон зайн мэдээлэл 3. Map 4. File Geodatabase бүтэц 5. Тоо ширхэг

2.1.4. *Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг өмчлөгч, эзэмшигч байгууллагатай хамтран бүртгэл судалгаа, гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулж, соёлын өвийн УНБМСан дахь түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн мэдээллийн санг баяжуулна.*

2022 онд нийт түүх, соёлын 21 хосгүй үнэт дурсгалт зүйлийг гэрэл зураг, дүрс бичлэг, 3D, дижитал баримтжуулалт, 17 төрөл зүйлийн 12418 ширхэг баримтат өвийн төрөлжсөн бүртгэлээр соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан баяжигдав. Үүнд:

1. Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутагт орших Шанхын Баруун Хүрээ хийдэд хадгалагдаж буй түүх, соёлын хосгүй үнэт зэрэглэлд батлагдсан дурсгалыг гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулах ажлыг 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн №22-2-14 тоот гэрээний дагуу 2022 оны 09 дүгээр сарын 02-оос 04-ний өдрүүдэд зохион байгууллаа.

Баримтжуулалтын арга хэмжээг Соёлын өвийн үндэсний төвийн Ерөнхий бүртгэл, мэдээллийн санч Б.Эрдэнэсувд ахлан, Хадгалалт хамгаалалт, технологийн судалгааны газрын дарга М.Оюунтулга зөвлөн туслаж, дурсгалт зүйлийг нэг бүрчлэн мэргэжлийн өндөр түвшинд дүрс бичлэгээр баримтжуулах ажлыг Дүрс бичлэгийн оператор Б.Мөнхбаатар, дурсгалт зүйлийг нэг бүрчлэн мэргэжлийн өндөр түвшинд гэрэл зургаар баримтжуулах ажлыг Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл хариуцсан бүртгэл, мэдээллийн санч Э.Ганбат, дурсгалт зүйлийн хөдөлгөөн орох үеийн аюулгүй байдлыг Шанхын баруун хүрээ хийдийн санхөмрөгч Д.Сайнбилэг нар хариуцан гүйцэтгэв.

Шанхын баруун хүрээ хийдэд Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 103, 2011 оны 214 тогтоолоор батлагдсан нийт 19 дэсийн түүх, соёлын хосгүй үнэт зэрэглэлд батлагдсан дурсгалт зүйл хадгалагдаж буй бөгөөд дурсгалт зүйлийг гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулах явцад тус хийдийн Тэргүүн лам А.Пүрэвсүрэнболд, Гэсгүй Г.Баттулга нар хяналт тавьж ажилласан.

Цутгуур, хөөмөл зэрэг гурван хэмжээст түүх, соёлын дурсгалт зүйлийг нүүрэн тал, ар тал, баруун, зүүн тал, баруун, зүүн хагас хажуу талууд, шүншиг, бад суурины дээд тавцан хэсэг, талуудын план зургийг авахдаа нэг бүрчлэн 10-30 хүртэлх хэсэгчилсэн деталь, бурхны гар мутарлага, барьц, хөл, хормойн хэсэг, титэм, чимэг зүүлт, сэв, гэмтэл зэргийг хэсэгчилэн деталь гэрэл зураг, дүрс бичлэг хийв. Шүтээн зураг, даавуу эдлэлд мөн адил гол бурхан, түүний эргэн тойрон, дээд доод хэсгийн дүрслэлийг нэг бүрчлэн баримтжуулав. Ажлын үр дүнд 26.15 GB хэмжээтэй 1132 кадр гэрэл зураг, 115 GB хэмжээтэй 3 цаг 17 минут 33 секундын дүрс бичлэгийн файлыг СӨУНБМСанд товьёгжуулж хадгалав.

Хосгүй үнэт дурсгалт зүйлсийг баримтжуулах ажлын явцад дурсгалын нэр, материал, хэмжээ, хувийн дугаар зэрэг өгөгдөл мэдээллийг “Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл” болон Засгийн газрын тогтоолтой тулган тус тогтоолд “дурсгалын нэр” зөрүүтэй, “хэмжээ” дутуу, эзэмшигч ташаарч бичигдсэнийг олж тогтоон тэмдэглэв.

Хүснэгт 2. Шанхын баруун хүрээ хийдэд хадгалагдаж буй түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн бариимтжуулалтад хамрагдсан дурсгалт зүйлийн жагсаалт

№	Засгийн газрын тогтоолын огноо, дугаар	Тогтоол дахь заалтын дугаар	Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн нэр	Тайлбар	Дүрс бичлэг (хугацаа, хэмжээ)	Гэрэл зураг (кадр, хэмжээ)
1	2	3	4	5		
1	2008 оны 103 дугаар тогтоол	275	Очирдара	Хүрэл цутгамал, алт шармал, 34х22х12.5 см, жин 6.040 гр	16 минут 51 секунд 6.08 GB	54 кадр 1.80GB
2	2008 оны 103 дугаар тогтоол	276	Цагаан дара эх	Хүрэл цутгамал, алт шармал 24.5х17х11.5 см, жин 3400 гр	20 минут 12 секунд 13.1 GB	58 кадр 0.52GB
3	2008 оны 103 дугаар тогтоол	277	Ногоон дара эх	Хүрэл цутгамал, алт шармал 25х18х12.5 см, жин 4200 гр	13 минут 30 секунд 4.86GB	47 кадр 1.56GB
4	2008 оны 103 дугаар тогтоол	278	Босоо Майдар	Гуулин цутгамал, алт шармал 80.3х20х11 см, жин 19400 гр Сэнтий 92см х 26см х 26см	12 минут 20 секунд 8.34GB	26 кадр 0.06GB
5	2008 оны 103 дугаар тогтоол	279	Шамбалын орны байгуулалт	Шүтээн зураг. Даавуу, шороон будаг, 113х76 см	14 минут 13 секунд 10.2GB	113 кадр 4.05GB
6	2008 оны 103 дугаар тогтоол	280	Дүйнхор-Цогт цагийн хүрдэн бурхны Лагшингийн хот мандлын Зүүн зүгийн бурхад	Шүтээн зураг. Даавуу, шороон будаг, 127х85 см	11 минут 21 секунд 3.81GB	117 кадр 4.31GB
7	2008 оны 103 дугаар тогтоол	281	Дүйнхор-Цогт цагийн хүрдэн бурхны Лагшингийн хот мандлын Урд зүгийн бурхад	Шүтээн зураг. Даавуу, шороон будаг, 127х85 см	11 минут 50 секунд 3.98GB	91 кадр 3.34GB
8	2008 оны 103 дугаар тогтоол	282	Дүйнхор-Цогт цагийн хүрдэн бурхны Лагшингийн хот мандлын Баруун зүгийн бурхад	Шүтээн зураг. Даавуу, шороон будаг, 127х85 см	10 минут 26 секунд 3.85GB	37 кадр 0.64GB
9	2008 оны 103 дугаар тогтоол	283	Дүйнхор-Цогт цагийн хүрдэн бурхны Лагшингийн хот мандлын Хойд зүгийн бурхад	Шүтээн зураг. Даавуу, шороон будаг, 127х85 см	11 минут 41 секунд 4.20GB	53 кадр 0.22GB
10	2008 оны 103 дугаар тогтоол	284	Дүйнхор-Цогт цагийн хүрдэн бурхны Зарлигийн хот мандлын бурхад	Шүтээн зураг. Даавуу, шороон будаг, 127х85 см	10 минут 48 секунд 3.89GB	92 кадр 3.41GB

11	2008 оны 103 дугаар тогтоол	285	Дүйнхор-Цогт цагийн хүрдэн бурхны Тааллын хот мандлын бурхад	Шүтээн зураг. Даавуу, шороон будаг, 127х85 см	11 минут 38 секунд 8.23GB	25 кадр 0.95GB
12	2008 оны 103 дугаар тогтоол	286	Дүйнхор-Цогт цагийн хүрдэн бурхны Дорж шүг сахиус	Шүтээн зураг. Даавуу, шороон будаг, 127х85 см	14 минут 44 секунд 5.27GB	145 кадр 2.44GB
13	2008 оны 103 дугаар тогтоол	287	Богд Зонхова	Шүтээн зураг. Даавуу, шороон будаг, 63х45 см	10 минут 36 секунд 3.78GB	23 кадр 0.98GB
14	2008 оны 103 дугаар тогтоол	288	Дархан их бүрээ	Найман тахилтай мөнгөн бөгжтэй, зэс хөөмөл, гурав сунадаг, хос, урт 260 см, диаметр 20 см	14 минут 56 секунд 10.4GB	49 кадр 1.63GB
15	2008 оны 103 дугаар тогтоол	289	ҮIII Богдын хөрөг	Гэрэл зургийн цаасан дээр шороон будгаар зурсан, 80х53 см	10 минут 44 секунд 3.83GB	27 кадр 0.94GB
16	2011 оны 214 дүгээр тогтоол	597	Г.Занабазарын хүүхэд ахуйн хувраг дээл	Торго, даавуу. 136 см х 98 см	9 минут 15 секунд 6.48GB	56 кадр 1.89GB
17	2011 оны 214 дүгээр тогтоол	598	Г.Занабазарын хүүхэд ахуйн номын хувцас	Торго, улаан хүрэн тэрэм. 77см х 33 см	15 минут 44 секунд 5.67GB	44 кадр 1.50GB
18	2011 оны 214 дүгээр тогтоол	599	Хос цан (г.занабазарын хүүхэд ахуйдаа хэрэглэж байсан)	Цан /металл/. Голч 20 см, жин 720 гр	7 минут 1 секунд 2.50GB	18 кадр 0.62GB
19	2004 оны 108 дугаар тогтоол	228	Богд хаант монгол улсын төрийн далбаа	Хатгасан. 2.82 х 1.05 см	8 минут 30 секунд 5.96GB	57 кадр 2.09GB

Зураг 9. Шанхын баруун хүрээ хийдэд ажиллаж буй явц

2. Засгийн газрын 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдааны 24 дүгээр тэмдэглэлд тусгагдсан үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх хүрээнд Монголын Бурханы шашинтны Төв Гандантэгчэнлин хийдтэй хамтран ажиллах санамж бичиг

байгуулан, хуралдааны тэмдэглэлд заасан ажлуудыг төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байна. Төлөвлөсний дагуу 2022 оны 11 дүгээр сард тус хийдэд хадгалагдаж буй түүх, соёлын хосгүй үнэт зэрэглэлийн “Бурхан багш”, “Жүжигшал Жанрайсиг” 2 дурсгалт зүйл бурхан шүтээнийг 3D дижитал хэлбэрээр баримтжуулан 12 GB цахим сан Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл,мэдээллийн санд хадгалав.



Зураг 10. Гандантэгчэнлин хийдэд ажиллаж буй явц

3. Баримтат өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, Үндэсний баримтат өвийн урьдчилсан жагсаалт бүрдүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын хэмжээнд нийт 17 төрөл зүйлийн 12418 ширхэг баримтат өв бүртгэлээ. Үүнд: Музей, номын сан-21, сүм хийд-26, сум-52, хувь хүн-446 хамрагдав. Баримтат өвийн судалгааг төрөл зүйлээр ангилж мэдээ тайланг нэгтгэн, СӨУНБМСанд хадгалав.

2	Манж хэлээр: Dergici toktobuha ge ti ciowan lu bithe Монгол хэлээр: Дээрээс тогтоосон дүрсийн тус бүрийг бүртгэсэн бичиг	Манжийн Энх-Амгалан хааны зарилгаар франц хэлнээс манж хэлээр орчуулсан орчуулагч нь 1698 онд Манжид ирсэн шашны элч Доминик Пареннин (1665-1741). С.Жамъян гүн хулсан үзгээр хуулж бичсэн, анатомийн зургийг нь Зөвлөлтийн мэргэжилтэн В.И.Лисовский гэрэлтдэг цаасан дээр хуулж зурсан.	Их хүрээ	1720 он XVIII Зуун						С.Жамъян гүн хулсан үзгээр хуулж бичсэн анатомийн зургийг нь Зөвлөлтийн мэргэжилтэн В.И.Лисовский гэрэлтдэг цаасан дээр хуулж зурсан.	+		

Зураг 10. Баримтат өвийн бүртгэлээс.

2.1.5. *Соёлын биет бус өвийн гар урлал, уламжлалт технологи, байгалийн болон сав шим ертөнцийн тухай мэдлэг зан үйл, мал маллах арга ухааны төрлөөр соёлын өвийн УНБМСангийн соёлын биет бус өвийн мэдээллийн цахим санг бүртгэл судалгаа, гэрэл зураг, дүрс бичлэгээр баяжуулна.*

“Төвийн болон хангайн бүсийн 4 аймагт соёлын биет бус өвийг угсаатны зүйн судалгааны арга зүйн дагуу тодруулж, тэмдэглэх; өв болон өвлөн уламжлагчийн дуу, дүрс бичлэгийг хийх; өвийн тархалтын мэдээллийг газарзүйн мэдээллийн системд оруулахтай холбогдуулан өвлөн уламжлагчийн нутагшлын мэдээллийг тэмдэглэх зэрэг зорилтын хүрээнд соёлын биет бус өвийн баримтжуулалтын ажлыг зохион байгуулав. Судалгааны ажлыг Дархан-Уул аймгийн Дархан хот болон Хонгор

сум, Орхон сум, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хот, Алтанбулаг, Жавхлант, Шаамар, Түшиг, Цагааннуур, Зүүнбүрэн, Хушаат, Баруунбүрэн, Зүүнхараа, Баруунхараа сум, Түнхэл тосгонд нийт 12 хоногийн хугацаатай хийж гүйцэтгэлээ.

Үр дүнд төвийн болон хангайн бүсийн 4 аймагт соёлын биет бус өвийн баримтжуулалтын ажлыг зохион байгуулав. Дээрх ажлын хүрээнд төвийн болон хангайн бүсийн Дархан-Уул, Сэлэнгэ, Өвөрхангай, Төв аймгийн нийт соёлын биет бус өвийн 4 ай савын 23 төрөл зүйлд хамаарах 45 өвлөн уламжлагчийг бүртгэж, нийт 2691 ширхэг гэрэл зураг, 1341.092 GB дүрс бичлэгээр баримтжуулав. Үр дүнд: Уламжлалт арга ухааны төрөлд 9, гар урлалын төрөлд 31 хүн, мал маллах арга ухааны төрөлд 4, байгалийн болон сав шим ертөнцийн тухай мэдлэг зан үйлийн төрөлд 1, нийт 45 өвлөн уламжлагчийг баримтжуулж, 2691 кадр гэрэл зураг, 1341.092 GB дүрс бичлэг бүхий цахим файл СӨУНБМСанд хадгалагдав.

Зураг 11. Бүртгэн баримтжуулалтын явц.

2.1.6. Монгол Улсаас Дэлхийн өвийн жагсаалтад Соёлын ангиллаар бүртгүүлэхээр бэлтгэж байгаа ”Говийн хадны зураг”, “Буган чулуун хөшөө” бүхий газруудад эрсдэлийн нөхцөл байдлын шинжилгээг газар дээр нь маягтын дагуу хийх, шаардлгатай бүртгэн баримтжуулах, сэргээн засварлах ажлыг хийж гүйцэтгэх хээрийн судалгааг 2022 оны 9 дүгээр сард зохион байгуулав.

Хээрийн судалгаагаар Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших Жавхлант хайрхан уулын хадны зураг, Баянхонгор аймгийн Баянлиг сумын нутагт орших Бичигтийн хадны зураг, Архангай аймгийн Ихтамир сумын Хойд Тамирын буган хөшөөд, Алтан сандал уулын буган хөшөөний цогцолбор газруудад тус Үндэсний төвөөс боловсруулсан эрсдэлийн маягтын дагуу нөхцөл байдлын шинжилгээ хийж, гэрэл зураг (7.45 GB) болон видео бичлэг (35 GB), (гол хадны зураг төвлөрсөн хэсгийг) 3 хэмжээст загвараар бүртгэн баримтжуулалт хийв.

Энэхүү буган чулууны эрсдэл нөхцөл байдлын шинжилгээ сэргээн засварлах ажлын хүрээнд Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Уушигийн өврийн 9 дүгээр буган чулуун хөшөөнд сэргээн засварлалт хийсэн. (Сэргээн засварлалт хийсэн тухай тайлангийн 2.3.3-д бий.)

Хээрийн судалгааны ажлын тайлан болон файлыг нэгтгэн Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд шилжүүлэн хадгалав.

Зураг 12. Архангай аймгийн Батцэнгэл сум. Шивэртийн амны буган хөшөөний цогцолбор

2.1.7. *ЮНЕСКО-ийн Соёлын биет бус өвийн жагсаалтад 3 өвийг нэр дэвшүүлэхэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хамтран ажиллана.*

ЮНЕСКО-гийн Соёлын биет бус өвийн жагсаалтад нэр дэвшүүлэх 3 өвийн судалгаа, баримт бичгийн боловсруулалтад хамтран ажиллав. Үүнд:

1. Казак түмний “Наурыз баяр” өвийн судалгаа, бүртгэн баримтжуулалтын хүрээнд Баян-Өлгий аймагт ажиллаж, судалгааны тайлан баримт бичгийг боловсруулах, ЮНЕСКО-гийн Үндэсний комисст илгээх, өвийн зүйлийг ЮНЕСКО-гийн Соёлын биет бус өвийг хамгаалах тухай 2003 оны конвенцийн Нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлэх ажлыг гүйцэтгэв. Тайланг Монгол болон Англи хэл дээр тус төвийн албан ёсны веб сайтд байрлуулав. Линк: http://ncch.gov.mn/ich?ItemID=8 (Зураг 13).
2. Монгол Улсын соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэлийн "Уламжлалт арга ухаан" ай савд хамаарах "Монгол уламжлалт анагаах ухаан", “Монгол нүүдлийн зан үйл” өвийг ЮНЕСКО-гийн СББӨ-ийн холбогдох жагсаалтад нэр дэвшүүлэх, судалгаа, баримт бичгийг бүрдүүлэх ажлын хүрээнд тус өвийг өвлөн уламжлагчийг бүртгэх, гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулах хээрийн судалгааны ажлыг IV улиралд хийж гүйцэтгэв. Үүнд: Баянхонгор аймгийн Бууцагаан, Говь-Алтайн Алтай аймгийн Шарга, Ховд аймгийн Жаргалан, Дарви, Манхан, Баян-Өлгий аймгийн Өлгий, Буянт Сагсай зэрэг 8 сумыг хамруулж нийт 2 өвийн 18 өвлөн уламжлагчийн 931GB гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулсан. Үр дүнд: “Наурыз баяр” өвийн судалгааны тайлан баримт бичиг боловсруулагдаж хүргэгдсэн, "Монгол уламжлалт анагаах ухаан" өвийг нэр дэвшүүлэх, баримт бичиг боловсруулах судалгаанд ашиглагдах анхан шатны хэрэглэгдэхүүний бүрдэл хангагдсан (Зураг 14).



Зураг 13. “Наурызын баяр” өвийн удалгаа, бүртгэн бариимтжуулалтын явц.

Зураг 14. Судалгаа, бүртгэн бариимтжуулалтын явц.

2.1.8. *Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн системийн техникийн даалгавар боловсруулж, систем хөгжүүлэлт хийхэд хамтран ажиллана.*

Register болон RCH программуудад хийхээр төлөвлөсөн нэмэлт хөгжүүлэлт нь Соёлын яамнаас хийж буй “Соёлын өвийн бүртгэлийн нэгдсэн цахим систем"-тэй цаашид уялдах тул тус яамны Мэдээллийн технологийн хэлтсээс дээрх программуудын нэмэлт хөгжүүлэлтэд санхүүгийн зардал гаргахгүй байхыг чиглэл болгосон.

“Соёлын өвийн бүртгэлийн нэгдсэн цахим систем"-ийн техникийн даалгавар буюу бүрэн хэмжээний хэрэглэгчийн шаардлага тодорхойлолт бүхий баримт бичгийг Соёлын яамны Мэдээллийн технологийн хэлтэстэй хамтран 2022 оны 5 дугаар сарын 26-29-ний өдрүүдэд боловсруулав. “СӨБНЦС” цахим систем нь дотроо түүх, соёлын үл хөдлөх дурсгалын, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн, соёлын биет бус өв, өвлөн уламжлагчийн, баримтат өвийн мэдээллийн дэд сангууд болон бүртгэлийн, статистик, тайлангийн, хайлт, шүүлтийн, гуравдагч байгууллагад зориулсан лавлагаа мэдээллийн, хувь хүнд зориулсан үйлчилгээний, орон зайн мэдээллийн, гэрэл зурагтай ажиллах, мэдэгдлийн, удирдлага, хяналтын (актлагдсан, дутсан, солигдсон г.м), хаяг тэмдэг бүртгэлийн, хэвлэх, экспортлох дэд системийн бүртгэлтэй байхаар төлөвлөв.

Баримт бичгийг үндэслэн төрийн худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалт явагдах бөгөөд шалгарсан технологийн компанийн хөгжүүлэлтийн ажил дуусахад цахим систем хэрэглээнд нэвтрэхэд бэлэн болох юм. Энэхүү ажил хэрэгжсэнээр соёлын өвийн мэдээллийн чанар, хүртээмж сайжрах, соёлын өвийн бүртгэл, судалгаа, хадгалалт хамгаалалт, хяналт, ашиглалтын нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгох, салбарын бодлого шийдвэр үр нөлөөгөө өгөх, иргэдэд төрийн үйлчилгээ, соёлын өвийн мэдээ мэдээлэл түргэн шуурхай хүрэх зэрэг олон давуу талууд бий болно.

Зураг 15. Ажлын явц

Зорилт 2.2. Соёлын өвийн хадгалалт хамгаалалтын орчныг сайжруулах, стратеги боловсруулах зорилгоор шинжлэх ухааны судалгааны байгууллага, үндэсний, улсын, бүс нутгийн музейтэй хамтран соёлын биет болон биет бус өвийн хадгалалт хамгаалалт, эвдрэл гэмтэл, хүрээлэн буй орчин болон материалын төрөлжсөн судалгаа хийнэ. (СӨХ тухай хуулийн 20.3 дугаар заалт)

2.2.1. *Эзэмшигчийн хүсэлтээр соёлын биет өвд бүтэц, орц найрлагын судалгаа хийж, үзмэрийн бүртгэл тодорхойлолтыг нэмэлт мэдээллээр хангаж, сэргээн засварлалтын өмнөх оношлох судалгаанд ашиглана.*

Эзэмшигчийн хүсэлтээр соёлын биет өвд бүтэц, орц найрлагын судалгаа хийж, үзмэрийн бүртгэл тодорхойлолтыг нэмэлт мэдээллээр хангаж, сэргээн засварлалтын өмнөх оношлох судалгаанд ашиглах ажлын хүрээнд 8 хүртэлх байгууллагын 100 хүртэлх үзмэрт материалын судалгаа хийж, үр дүнг эзэмшигч байгууллагад мэдэгдэх зорилт тавин ажиллав.

Материалын судалгаанд 9 байгууллага, 1 иргэний нийт 328 үзмэр, дээж хамруулж, өнгө будаг, металл, минерал будгийн орц найрлагад шинжилгээ хийсэн. Үүнд: ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн 46 ширхэг, Монголын Үндэсний музейн 20 ширхэг, Улаанбаатар их сургуулийн 26 ширхэг, Үндэсний төв архивын 25 ширхэг, Чингис хаан музейн 43 ширхэг, Хархорум музейн 6 ширхэг үзмэрт элементийн тодорхойлолт хийж, дурсгалт уран барилгын өнгө будгийн бүтэц найрлага тогтоох болон цавуулаг тогтоох судалгааг Богд хааны ордон музейн 80 ширхэг дээжид, Чойжин ламын сүм музейн 32 дээжид тус тус хийж уламжлалт материалын орц найрлага, өнгө будгийн төрөл зүйлийг тодорхойлж хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалт хийх арга зүйг боловсруулж, дээрх байгууллагуудад хүлээлгэн өгсөн. Эрүүгийн Цагдаагийн газраас ирүүлсэн 36 ширхэг дээж, 1 иргэний хүсэлтээр 10 ширхэг дээж, мөн Археологийн хүрээлэнгийн 4 ширхэг дээжинд SRF-ээр найрлага тодорхойлох шинжилгээ хийж, үр дүн боловсруулсан.

Хэрэгжилтийн үр дүнгээс үзвэл, 2022 оны зорилтот түвшингээсээ давсан буюу судалгаанд хамрагдсан байгууллагын тоо нь 13,75%, үзмэрийн тоо 328 %-тай биелэжээ. Материалын судалгааны ажлыг тогтмолжуулсанаар 1. Үзмэр дурсгалын хадгалалт хамгаалалтын орчныг сайжруулах, сэргээн засварлалтыг чанартай, үр дүн сайтай хийх үндэслэл бүрдэж байгаагийн зэрэгцээ мэргэжил арга зүйн зөвөлгөө боловсруулж, соёлын өвийг эзэмшигч, өмчлөгч төрийн болон, төрийн бус байгууллага, иргэдэд үйлчлэх үйл ажиллагаандаа чанарын ахиц гаргалаа. 2. Судлаачид судалгаа шинжилгээний ажилд суралцах, дадлагажихад ихээхэн түлхэц болсон.

Бид цашид, материалын гистологи бүтэц, үүсэл гарвал, он цаг тогтоох шинжилгээ судалгааны лабораторитой болох шаардлагатай байгаа ба энэ нь манай СӨҮТ нь ойрын жилүүдэд эрдэм, шинжилгээ судалгааны хүрээлэн болж хөгжих гол зорилт биелэх юм.



Зураг 16. Эд зүйлийн орц, найрлагын дүн

2.2.2. *Музейн гал түймрийн гамшиг эрсдэлийн үнэлгээний судалгаа хийж, эрсдэлийн менежментийн загвар боловсруулж, музейд танилцуулна.*

Музейн гал түймрийн гамшиг эрсдэлийн нөхцөл байдлын судалгаа хийх, эрсдэлийн менежментийн загвар боловсруулахад 2022 оны 02 сарын 17-ний 01/71

тоот албан бичгээр Онцгой байдлын ерөнхий газарт хандаж арга зүйн зөвлөгөө авсан бөгөөд Монголын Үндэсний музей, Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей, Чойжин ламын музей, Хархорум музей, Баян-Өлгий, Баянхонгор, Сүхбаатар, Ховд аймгийн музей нийт зэрэг 8-н музейгээс үндсэн 4 агуулга бүхий 28 асуулгаар нөхцөл байдлын тодорхойлох судалгааг авч нэгтгэв.

Дээрх судалгааны нэгтгэлд тулгуурлан музейд гал түймрийн эрсдэл үүсгэх хүчин зүйлсийг үнэлж, эрэмбэлэн, эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.

Монголын музейн салбарт гал түймрийн эрсдэлийн нөхцөл байдлын судалгааг улс, аймгийн музейн түвшинд анх удаа хийж байгаа бөгөөд нөхцөл байдлын үнэлгээний үр дүнд энэ төрлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх менежментийн төлөвлөгөөний загварыг боловсруулж, музейн удирдлага цаашид мөрдөх, үйл ажиллагаандаа төлөвлөх боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой юм.

Ингэснээрээ музейн барилгад гал түймрийн эрсдэл учруулах хүчин зүйлсийг олж илрүүлэх, эрсдэлийг эрэмбэлэн Онцгой байдлын Ерөнхий газрын холбогдох төлөөлөлтэй соёлын өвийн эрсдэлийн чиглэлээр хамтран ажиллах эхлэл тавигдах боломж бүрдэж Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар бүлгийн 34.1.2 Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах ,зөвлөгөө авах хуулийн заалтыг ханган ажиллаж байна.



МУЗЕЙН ГАЛ ТҮЙМРИЙН ГАМШИГ ЭРСДЭЛИЙН
НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА

Байгууллагын нэр: Чойжин ламын сүм музей

1. Музейн барилгын аюулын зураг байдаг уу? (хуулбарыг цахимаар ирүүлэх)
□ тийм ☑ үгүй □ мэдэхгүй
2. Танай музей хэдэн барилга байгууламжаас бүрддэг вэ?
тоо *тууч, соёлын үл хөдлөх дурсгал 12 дэсийн 14 ширхэг, байгууллагын үндсэн хөрөнгө 2 ширхэг, нийт 14 барилга байгууламжтай.*
3. Барилга хэдэн онд ашиглалтад орсон бэ?
Он *1908 он*
4. Барилгын үүрэг зориулалт, ашиглалтын хэлбэр ямар вэ?
а/ өмнө ашиглаж байсан үүрэг зориулалт *Сүм хийдийн зориулалттай.*
б/ одоогийн үүрэг зориулалт *Чойжин ламын сүм музей*
/Жишээ нь: Өмнөх үүрэг зориулалт:Худалдааны чиглэлээр, одоогийнх Занабазарын нэрэмжит Дүрслэх Урлагийн музей гэх мэт /
5. Тус барилга хэдэн удаа сэргээн засварлагдсан бэ?
2022 оны 02 дугаар сарын байдлаар гаргасан судалгаагаар нийт 14 удаагийн сэргээн засварлалтын ажил явагдсан байна. Гэхдээ үл хөдлөх дурсгалт зүйлийн онцгоогоос шалтгаалж хаалттай адилгүй сэргээн засварлалтын ажлууд хийгдэж байсан болохыг дурдах нь зүйтэй. Музей нь дурсгалт барилгын сэргээн засварлалтын асуудалд холбогдох дараах судалгааны бүтээлүүдийг хэвлүүлж олон нийтийн хүртээл болгосон. Үүнд:

МУЗЕЙН ГАЛ ТҮЙМРИЙН ГАМШИГ ЭРСДЭЛИЙН
НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА

1. Музейн барилгын аюулын зураг байдаг уу? (хуулбарыг цахимаар ирүүлэх)
□ тийм ☑ үгүй □ мэдэхгүй
2. Танай музей хэдэн барилга байгууламжаас бүрддэг вэ?
тоо ...3...
3. Барилга хэдэн онд ашиглалтад орсон бэ?
он ...①..Уран зургийн музей 1971, ② Байгалийн музей 1980 ③ Сүм музей 1757
4. Барилгын үүрэг зориулалт, ашиглалтын хэлбэр ямар вэ?
а/ өмнө ашиглаж байсан үүрэг зориулалт ①Дотоод хэрэгтэй ...хоймор.....
②Байгалийн музей.....③...машины зөөлөн ашиглалтаа.....
б/ одоогийн үүрэг зориулалт .....музейн музей...нарийн...дотоод.....
/Жишээ нь: Өмнөх үүрэг зориулалт:Худалдааны чиглэлээр, одоогийнх Занабазарын нэрэмжит Дүрслэх Урлагийн музей гэх мэт /
5. Тус барилга хэдэн удаа сэргээн засварлагдсан бэ?
тоо ...①. – 1 ② – 1 ③ – 1
6. Музейн барилга ямар хийц бүтээцтэй вэ?
☑ модон ☑ төмөр бетон □ ган хийц □ бусад
7. Барилгын хэв загвар ямар вэ?
□ ордон ☑ сүм хэлбэрийн □ орчин үеийн ☑ зориулалтын
8. Музейд галын дохиоллын систем байгаа юу?
☑ байдаг □ үгүй □ ажилладаггүй ☑ ажилладаг

Зураг 17. Судалгааны асуумж, хариулт

2.2.3. *Сүм хийд, дурсгалт барилгын сэргээн засварлалтын нөхцөл байдалд чанарын судалгаа хийж, Соёлын яаманд танилцуулна.*

Түүхэн дурсгалт сүм хийдийн барилга болон үл хөдлөх дурсгалын нөхцөл байдал чанарын судалгааг дараах нэр бүхий 3 аймгийн 4 дурсгалт газрын 9 дурсгалд, 3 хүртэлх объектийг судалгаанд хамруулж, чанарын судалгаа хийх зорилт тавьсан. Энэхүү судалгаанд 2 аймаг, 3 сумын нийт 3 объектын нөхцөл байдалд чанарын судалгаа хийж тайлагнасан. Үүнд:

1. 2022 оны 7 дугаар сард Соёлын өвийн үндэсний төвийн 2022 оны 07 сарын 25 өдрийн А/33 тоот Хээрийн судалгааны баг томилолтоор ажиллах тухай тушаалын дагуу Эрдэнэзуу хийдийн (Гол гурван зуу, Алтан суварга, Лавиран дуган) 5 барилгад БНСУ-ын Соёлын өвийн судалгааны үндэсний хүрээлэнгийн Эрсдэл гамшгаас хамгаалах хэлтэстэй хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд ажилласан.

Архитектурын соёлын өв: Архитектурын технологийн судалгаа, анхны төрх байдлын судалгаа.
Бүтэц болон материалын мониторинг: Суулт болон бүтцийн өөрчлөлтийн судалгаа, Урьдчилан сэргийлэх арга.
Материал: Эвдрэл гэмтлийн дүгнэлт 3D хэмжилт судалгаа болон гар хэмжилтийн зураг боловсруулалт. Дээврийн ваар, шавардлага болон өнгөлгөөний эвдрэлийн дүгнэлт зэрэг ажлуудыг хийсэн болно.
Судалгаанд ашигласан тоног төхөөрөмж: Агаарын зураг авах дрон, 3D скайн, 360° камер зэргийг ашиглав.

Дээрх ажлын үр дүнд Зүүн зуугийн хийдийн тоосгон өрлөг зүүн тийш суулт өгсөн, Дээврийн ваар хагарал өгч эвдрэл гэмтэл үүссэн, Алтан суварга хазайлт өгч доошоо хөрсний суулт илэрсэн, Лавиран дуган нь сүүлийн үед сэргээн засварлалт хийсэн тул онцгой байдал ажиглагдаагүй болно. Хоёр улсын хамтарсан судалгааны тайланг хоёр жилд нэг удаа ном болгон хэвлүүлэхээр төлөвлөж байна.

Зураг 18. Эрдэнэзуу хийд, Харбалгас

2. 2022 оны 9 дүгээр сард Дундговь аймгийн Адаацаг сумын нутагт орших "Сүм хөх бүрд"-ийн тууринд эрсдэлийн судалгаа, гар хэмжилт, материалын дээж, агаарын болон гэрэл зургаар баримтжуулалт хийж, 3D модель үүсгэсэн. Энэхүү үүсгэсэн модель мэдээллийг ШУА-ийн Археологийн хүрээлэнгээс тус газарт 2019 онд хийгдсэн сорилын хайгуул малтлага судалгааны гэрэл болон гар зургуудтай харьцуулж, дурсгалыг сэргээн засварлах талаарх зөвлөмжийг боловсруулсан. Хойд талын ханын баруун, зүүн булангуудад мөн ханын гол хэсэгт зэрэгцээ (параллель) хоёр том ан цав үүссэн байна. Тус барилгын хойд тасалгааны гурван хана чулуун өрлөгөөр барьцалдуулан холбоотой байсан хананууд хазайлт өгсөн байна. Борооны усны улмаас ханын (1.5м зузаан) гадаргуу дээр тогтсон ус чулуу хоорондын барьцалдуулсан шаврыг тогтмол элэгдүүлж байгаа нь ан цав үүсэх нэг суурь шалтгаан болсон. Чулуу хоорондын барьцалдуулсан шаврыг ханын дотор, гадна талаас тусгай материалаар бэхжүүлснээр цаашид шаврын элэгдэл хорогдлыг буруулна. Барилгын урд талд байрлах хэрмийн хоёр захын хана үргэлжилсэн Г хэлбэрийн төгсгөлтэй байсныг илтгэх суурь үлдсэн байна. 2019 оны ШУА-н түүх, угсаатан зүйн хүрээлэнгээс хэрэгжүүлсэн Сүм хөх бүрдийн туурьд явуулсан

судалгааны хүрээнд хийсэн гэрэл болон гар зургийг үндэслэн анхны өнгө төрхөд нийцүүлж нөхөн сэргээх шаардлагатай.

Гүйцэтгэсэн ажлууд:

1. Нөхцөл байдлын судалгаа
2. Хэмжилт
3. Материалын дээж авсан (барьцалдуулсан шавар)
4. Агаарын болон гэрэл зургаар баримтжуулсан
5. Газарзүйн мэдээллийн санд оруулсан, 3D модель үүсгэсэн.

Дүгнэлт: 2016 онд тус аймгийн бүтээн байгуулалтын хүрээнд хийгдсэн явган хүний замыг хийхдээ цементээр чулууг барьцалдуулж суулгасан байсан. Балгасын чулуун өрлөгтэй ижил төсөөтэй чулуу олдсоныг гэрэл зургаар баримтжуулсан. Явган хүний чулуун замыг өндөрлөн нуурын дундуур аралтай холбосон бөгөөд ойролцоогоор 2635м2 талбайг хамарч байна. Түүхэн дурсгалт газраас нутгийн иргэд чулууг зөөх үйлдлийг төмөр хашаагаар хашаалж, хамгаалалтад авснаар зогсоосон. Тухайн хашаа хайс нь экологийн тэнцвэртэй тогтолцоонд, ан амьтанд нөлөө үзүүлж байгааг судлах, шаардлагатай бол дахин хамгаалалтын бүсийг тогтоон, төмөр хашааг нүүлгэн байршуулах. Мөн хөх бүрдээс ундаалах говь нутгийн малын тоо толгойг тодорхойлж, ундны усны асуудлыг харгалзан үзэх шаардлагатай. Сүм хөх бүрдийн балгастай ижил цаг үед баригдсан чулуун өрлөгтэй дурсгалт барилга байгууламжийг харьцуулсан судалгаа хийх, цаашид чулуун барилга байгууламжийн хадгалалт хамгаалалтын арга зүйн журам боловсруулах хэрэгцээ, шаардлага үүсэж байна. Төвөд хийцийн чулуун барилгын болон уламжлалт орон сууцад авч хэрэгжүүлсэн барилгыг хүчитгэх замаар ашиглалтын хугацааг уртасгасан арга хэлбэрийг судлах, үр дүнтэй арга хэлбэрийг сонгон ашиглах. Гар ажиллагаагаар чулуу болгон дээр тэмдэглэл хийж, системтэйгээр хэсэгчлэн буулгаж дахин өмнөх төрхөөр нь өрлөгийн ажлыг хийж гүйцэтгэх боломжтой. Дэл хадтай гүвээнээс дахин чулуу олборлох боломжтойг судлах. Түүх дурсгалын музейн зориулалтаар 2016 онд шинээр баригдсан барилга одоогоор хаалттай, хаягдсан нөхцөл байдалтай байна. Тухайн барилгын гадаад хэлбэр төрх нь Сүм хөх бүрдийн хэв шинжээс өөр байгааг нийцүүлэн өөрчлөх, ашиглалтын хэлбэрийг сайжруулах саналыг аймгийн музейгээс 2022 оны 10 сарын 26-ны 1/86 тоотоор ирүүлсэн саналыг тусгах саналтай байна. Мөн задгай тоглолтын тайзыг жижиг арлаас нүүлгэн шилжүүлэх, байгалийн хуучин төрхийг сэргээх. Хоёр барилгын чулуун өрлөгийн барьцалдуулагч шавраас авсан хоёр дээжийг нуурын шавартай харьцуулах, цаашид нуурын шаврыг ашиглаж болох эсэхийг судлан, бэхжүүлэлтийн ажилд ашиглах боломжтойг тодорхойлох.

Зураг 19. Дундговь аймгийн Адаацаг сум. Сүм хөх бүрд (2022.9)

3. 2022 оны 9 дүгээр сард Өмнөговь аймгийн Номгон сумын Сангийн далайн хийд дээр ажиллаж, хэмжилт судалгааны зураг боловсруулах дадлага ажлыг гүйцэтгэж, дроноор 3D скайн хийж, агаарын зургууд бэлтгэн баримтжуулсан. Сангийн далай хийдийн Дүйнхор, Гүнрэг, Хайлан, Жүд, Дооров, Майдар зэрэг 6 дуганы 46 хуудас зураг боловсруулахдаа дуганууудын өнөөгийн нөхцөл байдал, эвдрэл гэмтлийг хэмжилтийн зурагт тусган баримтжуулсан. Энэ нь Сангийн далай хийдийг цаашид сэргээн засварлахад суурь мэдээлэл болох ач холбогдолтой.

Зураг 20.Өмнөговь аймгийн Номгон сум. Сангийн далай хийд (2022.9)

4. Өвөрхангай аймгийн Бат-Өлзийт сумын нутагт байрлах Төвхөн хийд, мөн аймгийн Хархорин сумын нутагт орших ЭрдэнэЗуу хийдэд агаарын тандалт судалгаагаар мулти спектор камер ашиглан RTK системд суурилсан хэлбэрээр тус хийдүүдийн орчны бүсийн ургамлын индексийг тодорхойлсон. Дээрх судалгааны үр дүнд органик болон органик бус үл хөдлөх дурсгалын хүрээлэн буй орчны эрсдэлийн нөлөөлөл, хүчин зүйлийг тодорхойлон ангилах, гэмтлийн шалтгааныг тодорхой болгож мэдээллийн сан бүрдүүлэх, хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалд хийх аргазүй боловсруулан нутагшуулах үндсэн мэдээллийн сан болгож ашиглах, харьцуулсан судалгаа хийх суурь судалгааны эхлэлийг тавьсан. Өвөрхангай аймгийн Бат-Өлзийт сумын нутагт байрладаг Төвхөн хийдийн агаарын тандалт судалгаагаар ургамлын индекс тодорхойлсон.

5. Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын 2-р багийн нутагт байдаг Чойрын Богд ууланд бүтээгдсэн, Улсын хамгаалалттай соёлын өвд бүртгэлтэй Дагвасүндэл бурхны дурсгалыг будаж, бохирдуулсан тухай мэдээлэл авч, орон нутагт нь очиж ажиллан шинжээчийн дүгнэлт гаргаж, цэвэрлэн сэргээсэн.

6. Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг дахь Эрдэнэ-Зуу хийд байрлаж буй талбайн ургамлын индексийг мулти спектор камер ашиглан RTK системд суурилсан агаарын тандалт судалгаагаар тодорхойлсон.Эдгээр судалгааны үр дүнд органик болон органик бус үл хөдлөх дурсгалын хүрээлэн буй орчны эрсдэлийн нөлөөлөл, хүчин зүйлийг тодорхойлон ангилах, гэмтлийн шалтгааныг тодорхой болгож мэдээллийн сан бүрдүүлэх, хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалт хийх аргазүй боловсруулан нутагшуулах үндсэн мэдээллийн сан болгож ашиглах, харьцуулсан судалгаа хийх суурь судалгааны эхлэлийг тавьсан.



Зураг 21. Эрдэнэ зуу хийдийн Гол гурван зуу, Алтан суварга, Лавиран дуганы бариимтжуулалт

2.2.4. *Судалгааны байгууллагатай хамтран бүс нутгийн хэмжээнд угсаатны бүлгийн соёлын биет бус өвийн оршин тогтнох чадавхад тандалт судалгаа хийж, үр дүнг Соёлын яаманд танилцуулна.*

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын даргын 2022 оны А/42 дугаар тушаалын дагуу “Соёлын биет бус өвийн үзлэг, бүсчилсэн судалгаа”-г Соёлын өвийн үндэсний төв, Шинжлэх ухааны академийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, Нүүдлийн соёл, иргэншлийг судлах олон улсын хүрээлэнтэй хамтран IV улиралд зүүн бүсийн 3 аймаг, Улаанбаатар хотыг хамруулан зохион байгуулав. “Соёлын биет бус өвийн үзлэг, бүсчилсэн судалгаа”-ны зорилго нь СББӨ-ийг сурвалжлан олох, судалгаа шинжилгээ хийх, хадгалалт хамгаалалтын нөхцөл байдал, эерэг болон сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг судлах, тархалтыг тогтоох, үзлэгийн мөрөөр авах арга хэмжээний санал боловсруулах, шаардлагатай хэрэглэгдэхүүн, мэдээлэл цуглуулах юм. Судалгаанд Дорнод, Хэнтий, Сүхбаатар болон Улаанбаатар хотын 9 дүүрэг хамрагдав.

Судалгааны үр дүнд: Дорнод аймгийн 78 өвлөн уламжлагч, Хэнтий аймгийн 106 өвлөн уламжлагч, Сүхбаатар аймгийн 79 өвлөн уламжлагч, Улаанбаатар хотын 100 өвлөн уламжлагч, нийт 363 өвлөн уламжлагч хамрагдсан байна. Судалгаагаар Сүхбаатар аймгийн 424GB, Хэнтий аймгийн 703GB, Нийслэлийн 1791 MB хэмжээтэй гэрэл, зураг дүрс бичлэгийн цахим сан бий болов.

Зураг 22. Соёлын биет бус өвийн үзлэг, бүсчилсэн судалгаа

Зорилт 2.3. Соёлын биет өв, түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалыг судлах, судалгаа шинжилгээний үндсэн дээр сэргээн засварлана. (СӨХ тухай хуулийн 20.3 дугаар заалт)

2.3.1. *Нийтийн өмчийн түүх, соёлын дурсгалт зүйлийг эзэмшигчийн хүсэлтийн дагуу газар дээр нь болон өөрийн тусгай байрны лаборатори, урланд сэргээн засварлаж, хүлээлгэн өгнө.*

Нийтийн өмчийн түүх, соёлын дурсгалт зүйлийг сэргээн засварлах хүрээнд нийт 15 байгууллагын 60 ш үзмэр сэргээн засварлахаар төлөвлөж, 25 байгууллагын

163 ш үзмэр сэргээн засварлав. Үүнд: даавуу, зөөлөн эдлэл 41ш, металл 10 ш, мод 29 ш, арьсан эдлэл 6ш, уран зураг 6ш, баримал 10 ш, шаазан эдлэл 1ш, танка зураг 11 ш, цаасан эдлэл 5ш, археологийн олдвор 6 ш байна. Мөн Эрдэнэ зуу музейн хүсэлтээр (нэмэлтээр) 38ш шавар шуумал, гипс, модон барималыг газар дээр нь очиж сэргээн засварласан. Улс, аймгийн 25 музей/байгууллагын 163 ш үзмэр эд өлгийн зүйлс сэргээн засварлагдсан нь зорилтот түвшинтэй харьцуулбал даван биелэсэн буюу байгууллагын тоо 166,66%, үзмэрийн тоо 271,66%- тай биелэсэн үзүүлэлт гарч байна. Ийнхүү өндөр хувьтай даван биелэсэн нь манай СӨҮТ бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэлээр өргөжин тэлж, олон мэргэжилтэн судлаачаар эгнээгээ тэлсэний үр дүн тодорхой хэмжээгээр байна. Мөн цаг үеийн шаардлагаар урган гарсан нэмэлт ажлууд 2022 оны хувьд хэт их байлаа. “Чингис хаан” музейн нээлттэй холбоотойгоор сайдын тушаал гарч, олон тооны нэмэгдэл үзмэр сэргээн засварласан.

Зураг 23. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн сэргээн засварлалт

2.3.2. *Яаралтай авран хамгаалах археологийн малтлага судалгааанаас илэрсэн олдвор, эд өлгийн зүйлийг байгууллагын хүсэлтээр бэхжүүлэх, цэвэрлэх, ажлыг газар дээр нь болон өөрийн тусгай байрны лаборатори, урланд хийж, хүлээлгэн өгнө.*

Тайлант хугацаанд археологийн хээрийн малтлага судалгаанаас илэрсэн 200 хүртэлх олдворт хадгалалт хамгаалалт, цэвэрлэгээ, бэхжүүлэлт, сэргээн засварлалт хийсэн байхаар төлөвлөж 3 байгууллагын 206 эд өлгийн зүйлийг цэвэрлэх, бэхжүүлэх ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Чингис хаан музейн үзмэрийн шавар 77 ш, чулуун 15 ш, яс 14 ш, гууль 28 ш нийт 134 үзмэрийг яаралтай сэргээн засварласан.

- МУИС-ийн хүсэлтээр Сүхбаатар аймгийн Онгон сумын нутаг, Таван толгойгоос илрүүлсэн 51 дэсийн 71 ширхэг биет өвийг тээвэрлэн зөөх шаардлага хангасан сав баглаа боодол хийж, аюулгүй тээвэрлэх нөхцөлийг хангах ажлыг газар нь дээр очиж хийн, Үндэсний төвийн лабораторит авчирч хадгалалт хамгаалалт, судалгаа шинжилгээний ажлыг эхлүүлсэн.
- Өвөрхангай аймгийн Хархорин сумын Хархорин музейд сахрын уусмал ашиглан Хар балгасын малтлагаас илэрсэн модон эдлэлийн гадаргуу хэсгийн талстыг цэвэрлэн, хадгалалт хамгаалалтын нөхцлийг сайжруулж, цаашид хэрхэн хадгалалт хамгаалалтын горимыг баримтлан ажиллах талаар мэргэжил арга зүйн зөвөлгөө өгч хүлээлгэн өгсөн ба тус музейн ЭША, Сэргээн засварлагчдад ажиглалт судалгааг тогтмол хийж байх аргачлал боловсруулан өгч, удирдан хийлгэж байна. Энэ мэтээр хадгалалт хамгаалалт хийгдсэн олдвор дурсгалууд дээр байнгын ажиглалт хийж, тэмдэглэл хөтлөж байх нь цаашид судалгаа шинжилгээнд үндэслэсэн, өөрийн орны орчин нөхцөлд тохирсон арга, аргачлал боловсруулах суурь судалгааны ажил болох юм.



Зураг 24. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бэхжүүлэлт, цэвэрлэгээ

2.3.3. *Байгаль дээр ил задгай орших эвдрэл гэмтэлтэй чулуун дурсгалыг цэвэрлэх, бэхжүүлэх, сэргээн засварлах, хэв хуулбар хийх ажлыг аймаг орон нутгийн хүсэлтээр газар дээр нь болон өөрийн байранд хийж гүйцэтгэнэ.*

Энэ ажлыг 8 хүртэлх чулуун дурсгалд хийж дурсгалын эх төрх байдлыг сэргээхээр төлөвлөж, 4 аймгийн 3 дурсгалд цэвэрлэх, бэхжүүлэх ажиллагаа, 2 дурсгалын хэв хуулбар авах хийх ажил хийж гүйцэтгэв. Үүнд:

- Завхан аймгийн Нөмрөг сумын нутаг Өвөр шивэртийн голоос 3 хэсэг хугарсан буган чулууг татан гаргаж механик цэвэрлэгээ хийж, тус аймгийн музейтэй хамтран Ялаат нуурын зүүн эрэгт орших буган чулуун дурсгал бүхий газарт зөөн аваачиж, байрлуулсан.
- Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Уушигийн өврийн 9 дүгээр буган чулуун хөшөөнд сэргээн засварлалт хийв. Сэргээн засварлах ажлыг хүрээнд Уг хөшөөний дээд талын залгагдах хэсгийн шувууны сангасны бохирдлыг этилийн спирт, хөвөн, бийр, сойз гар багаж зэргийг ашиглаж цэвэрлэсэн. Чулууны овор хэмжээнд тохируулж мяндсан (файбер) арматур, титан (резьбатай) савхан бэлдэцээр холбогч шаантаг суулгасан. Шаантаг суулгах хэсгүүдийг тааруулж өрөмдөөд AKEPOX 2010 A+B чулууны цавуугаар наан холбож, залгаас хэсгийн алга болж дутсан хэсгүүдийг дүүргэлт хийж нөхөв.

- Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын 2 дугаар багийн нутагт байдаг Чойрын Богд уулын ханан хаданд зурсан, “Улсын хамгаалалтад байх түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийн жагсаалт”-д бүртгэгдсэн “Дагвасүндэл” бурхны зургийг бохирдуулсан байдалд газар дээр нь очиж үзэж шинжээчийн дүгнэлт гаргасан ба уг дурсгалыг алтан боронзоор будаж бохирдуулсаныг цэвэрлэж, сэргээн засварлав.
- Архангай аймгийн музейн хашаанд байрлах “Бугатын гэрэлт хөшөө”-ний хуулбар (Үндэсний төвд хадгалагдаж байсан)-ыг сэргээн засварласан.
- Архангай аймгийн Хашаат сумын нутаг “Хөшөө цайдам”-д орших Түрэгийн үеийн “Культегин”-ний хөшөөний толгойн хуулбараас хэв авч баримал цутгасан зэрэг нийт 5 дурсгалд цэвэрлэх, наах, шаантаглан холбох, нөхөх, зөөн байрлуулах, хэв авах, хуулбар хийх, шинжээчийн дүгнэлт гаргах зэрэг ажлуудыг хийж төлөвлөгөөгөө 100% биелүүлэв.

Анхны хуулбар

Дараах хуулбар

Зураг 25. Хуулбар хийгдсэн ажил

Зураг 26. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг нааж, бэхжүүлж буй нь

Зураг 27. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг цэвэрлэж хийж буй нь

Зураг 28. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг авран хамгаалж, цэвэрлэж буй нь

2.3.4.*Түүхэн дурсгалт барилга, архитектурын, дурсгалын сэргээн засварлалтын үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, зөвлөн тусалж, хамтран ажиллана.*

АНУ-ын Элчин сайдын нэрэмжит соёлын өвийг хамгаалах сангийн санхүүжилтээр Монголын Урлагийн зөвлөлөөс 2021 онд “Энэржин” ХХК-д тэтгэлэг олгож, Чойжин ламын сүм музейн “Ядамын сүм”-ийн сэргээн засварлалтын ажлыг гүйцэтгэлтэй танилцан явцыг зургаар баримтжуулсан.

Чойжин ламын сүм музейн барилгын хийцийн бүх гол үндсэн эдлэгдэхүүнүүдийг сорьцын шинжилгээнд оруулж найрлагыг тодорхойлуулсан тухай, мөн дээврийн сольж байгаа хавтан ваарын шинжилгээний бичиг зэрэг холбогдох баримтуудыг үзэж танилцав.

Тус ажлын хүрээнд Монголын Урлагийн зөвлөлийн Соёлын өвийн хөтөлбөрийн захирал Д.Баянмөнх болон “Энэржин” ХХК-ний захирал Д.Тулга нартай уулзаж, цаашид сүмийн сэргээн засварлалтын ажилд “Түүх, соёлын дурсгалыг сэргээн засварлах ажил гүйцэтгэх журам”, барилгын норм дүрэм болон стандартыг хангаж ажиллахыг анхааруулав. Сэргээн засварлалтыг хийж буй “Энэржин” ХХК-иас

ирүүлсэн хүсэлтийн дагуу тус музейн “Ядам сүм”-ийн гадна болон дотор талын цэвэрлэгээнд мэргэжлийн зөвлөгөө өгч, хамтран ажилласан.

Богд хааны ордон музейн Лаврин, Чойжин ламын сүм музейн Ядам зэрэг 2 сүмийн барилгаас 25 байршил цэгт өнгө будгийн дээж авч байгалийн гаралтай шороон будгийг орчин үеийн багаж ашиглан лабораторид судалснаар, тухайн цаг үед хэрэглэж байсан өнгө будгийн эрдэс, цавуулаг, давхаргын найрлага тогтоосон байна.

Зураг 29. Чойжин ламын сүм музейн Ядамын сүмийн бариментжуулалт

2.3.5. *Дүрслэх урлагийн музей, Улсын драмын эрдмийн театр, Дуурь бүжгийн эрдмийн театрын барилгыг хүчитгэх ажилд хамтран оролцох.*

Улсын Дуурь бүжгийн эрдмийн театрийн барилгын гадна засварын гүйцэтгэлийн ажилтай 2022 оны 11 дүгээр сарын 21, 26-ны өдрүүдэд танилцаж театрын хойд талын гадна хана, карнизийн доод хэсэгт байрлах гурван төрлийн 75 ширхэг маскын сэргээн засварласан байдал болон засварлаж амжаагүй гурван талын хананы маск, баримлуудын одоогийн нөхцөл байдлыг гэрэл зургаар баримтжуулж авсан. Тус театрын барилгын засварлагдаж эхлээд буй хэсэглэлүүдийг харьцуулах эх зураг, маскын дүрслэл, баримлын хийцлэлтэй холбогдох түүхэн баримт материал манай байгууллагын архивт байхгүй тул анхны төрх байдал алдагдсан гэж үзэх нотолгоо баримт батлагдаагүй.

Анх театрын барилгын дотор гадна чимэглэлийн ажлыг 1950 онд Архитектор Б.Чимэдээр ахлуулсан Монголын алдарт ахмад уран бүтээлчид бүтээсэн билээ. Архитектор Б.Чимэд театрын нүүр талыг Монгол гэрийн хэлбэр, хагас бөмбөгөр орой хийж, үндэсний баримал, үндэсний уламжлалт хийц хэсэглэлээр чимсэнээс гадна Хархорум хотын тууриас олдсон, өнөө Дүрслэх урлагийн музейд хадгалагдаж буй “Хархорум маск”-ийг шууд дүрээр нь авч, өрнө дахины театрын масктай

хослуулан карнизын доод хэсгээр барилгыг бүтэн тойруулж чимэглэсэн байдаг /Музей судлал 2020 он, хуудас 124/ гэж тодорхойлсон байна.

Сэргээн засварлалтын ажил нь олон талт асуудлыг шийдэх учраас шинжлэх ухааны мэргэжилтнүүд /түүхч, урлаг судлаач, сэргээн засварлалтын инженер, биологич, химич, геологич г.м/ оролцох, мэргэжилтнүүдээс зөвлөгөө авах шаардлагатай байдаг. Иймд:

1. Тус театрын барилгын их засварын гүйцэтгэлийн явцад гүйцэтгэгч байгууллага нь дээр дурдсан мэргэжилтнүүд болон соёлын биет өвийг сэргээн засварлах ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих үүрэг бүхий Мэргэжлийн зөвлөлөөс зөвлөгөө авч хамтран ажиллах;
2. Ашиглагч байгууллага нь театрын барилгын анхны эх зураг төсөл, баримлын анхны загвар зураг эсвэл түүхэн баримтат гэрэл зургийг олж манай байгууллагад хүргүүлэх;
3. Маскны дүрслэл, баримал дурсгалын анхны эх төрхийн талаар судлах;
4. Баримал тус бүр дээр анхан шатны баримжуулалт хийх /хэмжээс тавьж гэрэл зургаар баримтжуулах/;
5. Эвдрэл гэмтлийн тодорхойлолтыг баримал тус бүр дээр хийх /хагарал, цуурал г.м/;
6. Маскний дүрслэл болон барималын хонхор хэсэгт тогтсон тоос, тортогийг нэг бүрчлэн цэвэрлэж, өнгөлгөөний будгаар нимгэн будах;
7. Театрын барилгын гадна фасадын будаг, алаглаж будагдсан хэсгүүдийг дахин будаж жигдрүүлэх;
8. Театрын гол үүдний хэсгийн шинээр хийгдсэн чулуун шалны түвшинг засаж ижил түвшинтэй болгох;
9. Гадна фасадын өнгөлгөө будгийн ажил, хоёр өнгийн будгийн уулзвар хэсгийг ялгаж, цэвэрлэж будах;
10. Гүйцэтгэгч байгууллага нь дулааны улиралд барилгын их засварын ажил эхлэх үеэр ажиллах хүчээ нэмэгдүүлэн ажлыг эрчимжүүлж, холбогдох барилгын хууль, норм ба дүрэмд нийцүүлэн, төсөл арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллах шаардлагатай гэсэн зөвлөмжийг 2022 оны 02/458 тоот албан бичгээр тус барилгын гадна их засварын ажил гүйцэтгэгч “Марвелхаус констракшн” ХХК-д хүргүүлэв.

Зураг 30. Улсын драмын эрдмийн театр барилгын баримтжуулалтын явц

Зорилт 2.4. Цаг үеийн шаардлагаар нэн яаралтай соёлын өвийг хадгалах, авран хамгаалах үйл ажиллагааг орон нутаг, мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулна. (СӨХ тухай хуулийн 20.3 дугаар заалт, 27.8 дахь заалт)

2.4.1. *Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалт, ашиглалтын нөхцөл байдлын үнэлгээний судалгааг тусгай маягт ашиглан, бүсчлэн зохион байгуулж, дүн мэдээ үр дүнг Соёлын сайдад танилцуулна.*

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын төрөл зүйл тус бүрийн онцлогт тохирсон хадгалалт хамгаалалтын мэдээлэл цуглуулах маягт боловсруулан Архангай, Баянхонгор, Булган, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Увс зэрэг 7 аймгийн нутаг дэвсгэр дэх улсын болон аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтад бүртгэгдсэн 72 дурсгалт газрын 208 дурсгалын хадгалалт хамгаалалтын үнэлгээг хийсэн. Хадгалалт хамгаалалтын нөхцөл байдлын үнэлгээгээр 23 дурсгалт газар “сайн”, 27 дурсгалт газар “дунд”, 16 дурсгалт газар “муу”, 6 дурсгалт газар “маш муу” хэмээн үнэлэгдсэн байна.

Үнэлгээний ажлын хүрээнд цугларсан мэдээллийг нэгтгэн Соёлын өвиийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хадгалсан ба судалгааний үр дүн мэдээг Соёлын яаманд хүргүүлэхээр бэлтгэж байна.

Зураг 31. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалт, ашиглалтын нөхцөл байдлын үнэлгээний судалгаа хийж буй

2.4.2. *Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хамгаалалтын хашаа, хайсны үлгэрчилсэн загвар, хийцлэлийн заавар боловсруулан баталж, аймгийн Соёлын газарт хүргүүлсэн байна.*

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хун, мал амтны хөл, авто машин зэрэг байгаль, нийгмийн сөрөг хучин зүйлсээс хамгаалах зорилгоор төмөр хайсан хашааны үлгэрчилсэн загвар, барих аргачлал боловсруулан аймаг, нийслэлийн Соёл, урлагийн газарт 2022 оны 6 дугаар сарын 8-ны 01/213 тоот албан бичгээр хүргүүлсэн. Хамгаалалтын хашааны бэлдэц нь төв, орон нутгийн зах зээлд элбэг олдоцтой, загвар нь дурсгалын эх төрхийг алдагдуулахгүй, энгийн бөгөөд барьж угсрах арга ажиллагаа болон засаж сэлбэхэд хялбар байхаар аргачлалд тусгасан. Түүх, соёл, шинжлэх ухааны хувьд чухал ач холбогдолтой, эрсдэлд орсон дангаараа болон цогц байдлаар орших хөшөө дурсгал, булш, тахил тайлгын байгууламж, балгас, эртний хотын туурь, бага хэмжээтэй талбай бүхий дурсгалт барилга зэрэгт

хамгаалалтын хашаа хайс барих шаардлагатай байна. Хамгаалалтын хашаа, хайстай болгосноор дурсгалын хадгалалт хамгаалалтын нөхцөл байдал сайжрах юм.



Зураг 32. Хамгаалалтын төмөр хашааны ажлын зураг

2.4.3. *Цаг үеийн шаардлага, шийдвэрээр соёлын биет өвийг авран хамгаалах үйл ажиллагааг бусад байгууллагатай хамтран зохион байгуулж, үр дүнг тайлагнана.*

Тус ажлын хүрээнд 6 аймаг, 1 байгууллагыг хамарсан судалгаа хийж, 2 дурсгалт газар дахь соёлын өвийн үнэ цэн алдах эрсдэлийг бууруулах, авран хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах зөвлөмж боловсруулан дээрх аймгийн Соёл, урлагийн газруудад хүргүүлсэн. Мөн 3 аймгийн 2 хийд, 2 дурсгалд хүрээлэн буй орчны эрсдлийн тандалт судалгаа хийж, арга зүй боловсруулсан. Танка зургийн өнгө будагт XRF химийн элементийн шинжилгээ, даавуун эдлэлийн гарал үүслийн судалгаа хийж, 130ш дурсгалд гэмтлийн тодорхойлолт, археологийн дурсгалт газрын хөрсний дээжийн судалгаа хийж тодохойлолт, дүгнэлт, зөвлөмж гаргасанаас гадна олдворын гэмтэл тодорхойлох судалгаа хийж, цаашид хийгдэх сэргээн засварлалт, хадгалалт хамгаалалтын ажлын төлөвлөгөөг боловсруулж, төсөв гарган Соёлын яаманд хүргүүлсэн. Энэхүү судалгаанд даараах аймаг, байгууллага хамрагдав.

- Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутагт соёлын өв булагдсан гэх иргэдийн мэдээллийн дагуу шалгах, авран хамгаалах хээрийн судалгааг 8 дугаар сард зохион байгуулсан;
- Ховд аймгийн Үенч сумын нутаг Хараатын бэлчээрийн хадны зураг, Архангай аймгийн Ихтамир сумын нутаг Алтан тэвш уулын буган чулуун хөшөөдийн устах, соёлын өвийн үнэ цэнэ алдах эрсдэлийг бууруулах, авран хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах зөвлөмж боловсруулан дээрх аймгийн Соёл, урлагийн газруудад хүргүүлсэн;
- Өмнөговь аймаг Сангийн Далай хийд, Өвөрхангай аймаг Хархорин сумын нутагт орших Шанхын Баруун хүрээ хийд, мөн сумын нутагт орших Мэлхий толгой 1 чулуун

дурсгал, Төв аймаг Алтанбулаг сум, Өнгөтийн дурсгалуудад тус тус хүрээлэн буй орчны эрсдэлийн тандалт судалгааг хийж, арга зүй боловсруулсан.

- Чойжин ламын сүм музейн “Гомбо” танка зургийн өнгө будагт XRF химийн элементийн шинжилгээ, даавуун эдлэлийн гарал үүслийн судалгаа;
- Өвөрхангай аймаг Хархорин сум, ЭрдэнэЗуу хийдийн Лаврин сүмийн 130 ш дурсгалд гэмтлийн тодорхойлолт;
- Сүхбаатар аймаг Онгон сумын нутагт орших 13 дугаар зууны үеийн булш малтлагаас илэрсэн олдворын гэмтэл, цаашид хийгдэх сэргээн засварлалт, хадгалалт хамгаалалтын ажлын төлөвлөгөөг боловсруулж, булшнаас гарсан үр тарианы төрөл тодорхойлолт, эмээлд XRD, FTR, ICP, хөрсөнд механик бүрэлдэхүүн, химийн найрлага, даавуун эдлэлд нэхмэлийн ширхэглэг таних, нэхээсний төрөл зүйл тодорхойлолт, модон эдлэлд чийг тодорхойлох зэрэг судалгаа;
- Архангай аймгийн Өлзийт сум, Луут хотын малтлагаас авсан хөрсний дээжийн судалгааг тус тус хийж зохих тодорхойлолт, дүгнэлт, зөвлөмжийг гаргасан.
- Гадаад оронтой хамтын ажиллагааны хүрээнд Япон улсын Нара, Осака хотын хадгалалт хамгаалалт хүрээлэнгийн судалгааны багтай хамтран туршлага солилцох болон өнгө будгийн судалгааны ажлыг эхлүүлсэн. Хамтын ажиллагааны үр дүнд СӨҮТ, мэргэжлийн байгууллагууд чадавхжив.



Зураг 33. Ажлын явц

2.4.4. *Яаралтай хамгаалах шаардлагатай өндөр настай соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн мэдлэг, арга ухааныг бүртгэл, судалгаа, гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулж, мэдээллийн санд хадгална.*

2022 оны тайлант хугацаанд Соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөн эзэмшсэн "Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалт"-д бүртгэгдсэн өндөр настай өвлөн уламжлагчийн мэдлэг, арга ухааныг гэрэл, зураг дүрс бичлэгээр баримтжуулав. Үүнд.

- Дархан-Уул аймгийн Орхон сумын Ардын язгуур урлаг, Уламжлалт арга ухаан ай сав хамаарах 2 өвлөн уламжлагчийн 32ш (0.27GB цахим файл) гэрэл зураг,(10.98GB цахим файл) 01:05:02 секундын дүрс бичлэг,
- Сэлэнгэ аймгийн Дулаанхаан, Түшиг, Зүүнбүрэн сумын Эх хэл, аман уламжлал, илэрхийлэл, Уламжлалт арга ухааан, Уламжлалт гар урлалын ай сав хамаарах 3 өвлөн уламжлагчийн 66ш (0.53GB цахим файл) гэрэл зураг, (70.83 GB8 цахим файл) 05:33:04 секундын дүрс бичлэг,
- Дундговь аймгийн манлай сумын Уламжлалт арга ухаан ай савд хамаарах 1 уламжлагчийн 77ш (0.59GB цахим файл) гэрэл зураг, (35.9GB цахим файл) 01:39:35 секундын дүрс бичлэг,

- Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн Ардын язгуур урлаг, Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага ай сав хамаарах 2 өвлөн уламжлагчийн 89ш (10.6GB цахим файл), (35.1MB цахим файл), 00:42:12 секундын дүрс бичлэг,
- Улаанбаатар хотын Хан- Уул дүүргийн Уламжлалт гар урлалын ай савд хамаарах 1 өвлөн уламжлагчийн 52 ш (0.17 GB цахим файл), 11.2 GB дүрс,00:32:11 секундын дүрс бичлэг,
- Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн Ардын язгуур урлаг ай сав хамаарах (9,55 GB цахим файл) дүрс бичлэг, хэрэглэгдэхүүнийг УНБМСанд хадгалав. Баримтжуулалтад нийт Монгол Улсын Соёлын биет бус өвийн Төлөөллийн бүртгэлд орсон 7, Яаралтай хамгаалах шаардлагтай соёлын биет бус өвийн бүртгэлд орсон 3 өв, нийт 10 өв буюу нийт 3 аймаг, 4 сум, 3 дүүргийн 64-82 насны нийт 10 өвлөн уламжлагчийг хамруулсан байна. Баримтжуулалтын үр дүнд нийт 316 ш (1,75GB цахим файл), 92ш (142,58GB буюу 24MBцахим файл), 9 цагийн хэмжээтэй дүрс бичлэгийг цуглуулан СӨУНБМСанд хадгалав.

Зураг 32. Баримтжуулалтын явц

2.4.5. *Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалтад батлагдсан 102 хүртэлх өвлөн уламжлагчийг эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулж, тайлагнана.*

Тус ажлын хүрээнд Соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөн эзэмшиж, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 475 дугаар тогтоолоор Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалт"-д батлагдсан" 102 өвлөн уламжлагчийн харьяалал, холбоо барих дэлгэрэнгүй мэдээлэл, эрүүл мэндийн нөхцөл байдлийн судалгааг нэгтгэх ажлыг гүйцэтгэв.

Судалгааны дүн мэдээгээр 26 өвлөн уламжлагч нас барсан, 76 өвлөн уламжлагч амьд сэрүүн байна гэсэн тоон үзүүлэлт гарсан. Амьд сэрүүн 76 өвлөн уламжлагчийн дэлгэрэнгүй мэдээллийг Соёлын яаманд хүргүүлж, судалгаанд суурилж эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамрагдах нэн шаардлагатай 50 өвлөн уламжлагчдыг оношлогоонд хамруулах ажлыг тус яамтай хамтран IV улиралд зохион байгуулав. Үр дүнд соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөн эзэмшсэн өвлөн уламжлагч нар эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд үнэ төлбөргүй хамрагдаж, өөрсдийн биеийн онцлогт тохирсон зөвлөгөө авч, эмчилгээ хийлгэв.

Зураг 22. Эрүүл мэндийн үзлэгт хамруулж буй нь.

2.4.6. *“Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц”-ын хамгаалалтын бүс дэх соёлын биет бус өвийн бүртгэл, судалгаа хийж, төрөлжсөн мэдээллийн сан үүсгэсэн байна.*

“Эрдэнэбүрэн”-УЦС баригдах Ховд аймгийн Мянгад, Эрдэнэбүрэн, Увс аймгийн Өмнөговь, Баян-Өлгий аймгийн Баян нуур сумдын нутагт нутаглан суугаа монгол угсаатны томоохон бие даасан бүлгүүд болох Мянгад, Өөлд, Дөрвөд, түрэг угсааны нэгэн бүлэг монголын Казахууд нарын соёлын биет бус өвийн сөрөг нөлөө болон тус бүс нутагт орших түүх, соёлын үл хөдлөх дурсгалын археологийн авран хамгаалах ажил, зарим дурсгалыг нүүлгэн шилжүүлэхэд анхаарах талаар төслийн нэгжид 2022 оны 01/262 тоот албан бичгээр зөвлөмж хүргүүлсэн.

2.4.7. *Шүүхийн шийдвэрээр хураагдсан соёлын биет өвийг музейд шилжүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг тайлагнана.*

Тайлант хугацаанд Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүх, шийтгэх тогтоолоор хурааж, улсын орлого болгох шийдвэр гарсан түүх, соёлын дурсгалт зүйлд хамаарах 1 ширхэг “Таван оройт титэм” эд зүйл ирснийг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 52.8 дахь заалтын дагуу холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авч, Хэнтий аймгийн музейд шилжүүлэхээр бэлтгэл ажлыг хангаад байна.

ДОРНОГОВЬ АЙМАГ, ЗАМЫН-ҮҮД СУМ ШҮҮХИЙН ТАМГЫН ГААЛАР

2022.10.11 221

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВД

Тус шүүхийн 2020 оны 01 сарын 31-ны өдрийн 20 дугаартай шийтгэх тогтоолоор Боржигон овогт Дарсүрэнгийн Гончигдоржид холбогдох эрүүгийн 182002040053 дугаартай эрүүгийн хэрэгт эд мөрийн баримтаар хураагдан ирсэн түүхийн дурсгалт зүйлд хамаарах нэг багц 5 ширхэг бүхий модон дээр зурсан Рин-аа гэх бүрхэвч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 21.5 дугаар зүйлийн 6-д заасныг бүрэнэг хураж, улсын орлого болгон Монгол Улсын Соёлын өвийн сан шилжүүлэхээр шийдвэрлэсэн байх тул эд мөрийн баримтыг хүргүүлэв.

Хавсралт:5хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.ПҮРЭВЖАРГАЛ

1370332

Зураг 23. Шүүхийн шийдвэрээр хураагдсан эд зүйл.

Зорилт 2.5. Соёлын өвийн боловсрол олгох, соён гэгээрүүлэх, шавь сургалт зохион байгуулах, соёлын өвийг сурталчлах үйл ажиллагааг олон улс, хүүхэд залуучууд, олон нийтэд зориулан сэтгүүл, гарын авлага, цахим контент хэлбэрээр зохион байгуулна. (СӨХ тухай хуулийн 20.3, 24.2 дахь заалт)

2.5.1 *Соёлын өвийг сурталчлах, боловсрол олгох, шавь сургалт зохион байгуулах зорилгоор “Бага театр”-ыг ашиглалтад оруулж, хүүхэд залуучуудад соён гэгээрүүлэх, боловсрол олгох ажлыг эхлүүлнэ.*

Монголын Урлагийн Зөвлөлийн дэмжлэг, “Рио Тинто” ХХКомпанийн 400 сая төгрөгний санхүүжилтээр “Өв Эрдэнэ” театрын интерьер дизайныг “Спринт Архитект” зураг төслийн компани боловсруулж, “Рэдлайн ХХК” дотоод заслын ажил гүйцэтгэж, тайзны гэрэлтүүлгийг D-Light компани, дуу хөгжмийн тоног төхөөрөмжийг “ITC Solution ХХК” суурилуулж 2022 оны 7 дугаар сарын 5-нд ашиглалтад хүлээлгэн өгсөн.

Монгол гэр мэт дугуй интерьер дизайнтай, үндэсний болон орчин үеийн загвар шийдэл бүхий 100 үзэгчдийн багтаамжтай, дэвшилтэт технологийн гэрэлтүүлэг, дуу хөгжмийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон ардын язгуур урлагийн ай сав дахь соёлын биет бус өвлөн уламжлагч нар зориулсан анхны төрөлжсөн театр гэдгээрээ онцлог юм.

Төрийн байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын түншлэлийн хүрээнд бүтээн байгуулсан энэхүү театрт соёлын биет бус өв, өвлөн уламжлагчийн урын сан, мэдлэгийг дуу, дүрс бичлэгээр баримтжуулах, ардын язгуур урлагийн тоглолт, хүүхэд залууст чиглэсэн соёлын өвийн боловсрол олгох сургалт, соёлын өвийн цуврал кино үзвэр, танин мэдэхүйн лекц, эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн, олон нийтийн уралдаан наадам зэрэг соёлын өвийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг аймаг, орон нутгийн соёл урлагийн газар, нутгийн зөвлөл, боловсролын байгууллага, төрийн бус байгууллага, өвлөн уламжлагчид зэрэг олон талын оролцогчтойгоор тогтмол зохион байгуулахаар төлөвлөсөн.

Театр нээгдсэнээс хойш "Монгол цуур хөгжмийн уламжлалт урлаг"-ийг сурталчлах өдөрлөг, шилдэг өвлөн уламжлагч Г.Баяртайн “Дөрвөд, баяд бий биелгээний шавь сургалт”-ын төслийн тайлан тоглолт, “Олон угсаатны соёлын өв-Буриад ба Хамниган угсаатны соёл, уламжлал” лекц зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулсан ба соёлын биет бус өвийг хадгалж хамгаалах, сурталчлах, сургалт, судалгаа, бүртгэн баримтжуулалт хийх “Өв Эрдэнэ” театрын зорилтот үйл ажиллагааны 2023 оны календарьчилсан төлөвлөгөөг боловсруулсан.

“Олон угсаатны соёлын өв-Буриад ба Хамниган угсаатны соёл, уламжлал” лекц зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулсан ба соёлын биет бус өвийг хадгалж хамгаалах, сурталчлах, сургалт, судалгаа, бүртгэн баримтжуулалт хийх “Өв Эрдэнэ” театрын зорилтот үйл ажиллагааны 2023 оны календарьчилсан төлөвлөгөөг боловсруулсан.

Зураг 24. ”Өв Эрдэнэ” театрын нээлт.

2.5.2. *Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хүрээнд зүүн 3 аймгийн нутагт байх улс, аймгийн хамгаалалтын түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг танилцуулсан видео танилцуулга, бариматат нэвтрүүлгийг хийж, сошиал платформд байршуулж, олон нийтэд сурталчилна.*

Тухайн ажлын хүрээнд зүүн бүсийн (Дорнод, Хэнтий, Сүхбаатар) аймгийн нутаг дэвсгэр дэх Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 13 дугаар тогтоол, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/161 дугаар тушаалаар Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтад тус тус батлагдсан 30 дурсгалын танилцуулга бүхий видео контентыг бэлтгэж олон нийтийн түүх, соёлын дурсгалын танин мэдэхүйн хэрэгцээнд тулгуурлан соёлын өвийн үндэсний төвийн сошиал сувгуудаар дамжуулсан. Үүнд:

Хэнтий аймгийн нутаг орших Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтад батлагдсан 11 дурсгал

1. Өглөгчийн хэрэм,
2. Рашаан хадны цогцолбор дурсгал,
3. Дуурлиг нарсны хүннүгийн язгуартны оршуулгын газар,
4. Сэрвэн хаалганы бичээс,
5. Аваргын балгас,
6. Дуулга уулын хүннүгийн оршуулгын газар,
7. Салбар уулын бичээс,
8. Балдан Бэрээвэн хийдийн цогцолбор, бурхдын зураг, бичээс,
9. Дунд Жаргалантын цогцолбор дурсгал,
10. Гэлэн хэмээх хүн чулуун хөшөө,
11. Сэцэн ханы ордны цогцолбор

Аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтад батлагдсан 5 дурсгал

1. Ханзат хотын туурь,
2. Шавартайн чулуун зэвсгийн дурсгалт газар,
3. Гүн бүрдийн дурсгал,
4. Хар модон толгойн хадны зураг,
5. Цэнхэрмандалын бичээс

Дорнод аймгийн нутаг дэвсгэрт орших Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтад батлагдсан 3 дурсгал

1. Их Бурхантын цогцолбор,
2. Шонх Таван толгойн хүн чулуу,
3. Хэрлэн барс хотын туурь, суварга)

Аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтад байх 4 дурсгал

1. Норовлин уулын булш,
2. Чингисийн хэрмэн зам,
3. Тугийн сүмийн туурь,
4. Хөцөөгийн хоолойн цогцолбор дурсгал

Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт орших Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтад батлагдсан 7 дурсгал

1. Алтан овооны хүн чулуун хөшөөд,

2. Ламтын хүн чулуун хөшөөд,
3. Хөргийн хөндийн хүн чулуун хөшөөд,
4. Устай бургастайн чулуун зэвсгийн бууц,
5. Сөдөтийн цагаан чулууны бичээс,
6. Таван толгойн цогцолбор дурсгал,
7. Шивээтийн хүн чулуун хөшөөд)-ын танилцуулга бүхий 1-3 минутын видео контентын товч танилцуулгыг бэлтгэв.

Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэр дэх нийт Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтад батлагдсан 21, Аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтад батлагдсан 9 дурсгалт газар нийт 30 дурсгалт газрын 01:09:38 хугацаатай, 4.96 GB хэмжээтэй цахим файлыг Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хадгалав.



Зураг 25 . ТСҮХД 30 дурсгалт газрын танилцуулга бүхий контентыг сошиал платформд байршуулсан байдал.

2.5.3. *Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хүрээнд соёлын биет бус өвийн төрөл зүйлийг танилцуулсан видео танилцуулга хийж, сошиал платформд байршуулж, олон нийтэд сурталчилна.*

ЮНЕСКО-ийн СББӨ-ийн Төлөөллийн болон Яаралтай хамгаалах шаардлагатай 15 өв, Монгол улсын соёлын биет бус өвийн төлөөллийн үндэсний бүртгэлийн 15 өв нийт 30 соёлын биет бус өвийн танилцуулга бүхий 3 хүртэлх минутын видео контентыг олон нийтийн соёлын биет бус өвийн танин мэдэхүйн хэрэгцээнд тулгуурлан Соёлын өвийн үндэсний төвийн платформд байршуулав. Тус ажлын хүрээнд: ЮНЕСКО-ийн соёлын биет бус өвийн Төлөөллийн жагсаалтад бүртгэгдсэн 8 өв, Яаралтай хамгаалах шаардлагатай 7 өв, Монгол Улсын Монгол улсын соёлын биет бус өвийн төлөөллийн үндэсний бүртгэлийн 15 өв нийт 30 соёлын биет бус өвийн агуулгын боловсруулсан. Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд ай савын 2 өв, Ардын язгуур урлаг 9 өв, Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага 9 өв, Байгалийн болон сав шим ертөнцийн тухай мэдлэг, зайн үйл 1 өв, Уламжлалт арга ухаан 7 өв, Уламжлалт гар урлал 2 өв нийт 30 соёлын биет бус өвийн 01:20:35 хугацаатай, 5.78 GB багтаамж бүхий цахим файлыг соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хадгалав. Мөн олон улсын түвшинд ЮНЕСКО-гийн ивээл дор II зэрэглэлийн төв болох Ази-Номхон далайн бүс нутгийн Соёлын биет бус өвийн мэдээлэл, хамтын ажиллагааны төвийн IchLinks www.ichlinks.com портал дээр байршуулан түгээн сурталчилж байна.

Зураг 26 . СББӨ-ийн 30 контентыг сошиал платформд байршуулсан байдал.

2.5.4*. Соёлын өвийн мэдээ, мэдээлэл сэтгүүл болон соёлын өвийг бүртгэх, хадгалж хамгаалах арга зүйн гарын авлага хэвлэн, соёлын байгууллага, соёлын өвийн ажилтан, олон нийтэд түгээнэ.*

“Монгол Улсын баримтат өвийн бүртгэл”-д нэр дэвшүүлэх дурсгалыг бүртгэх аргачлал гарын авлагыг боловсруулж, хянуулж хэвлэхэд бэлэн болгосон. Цаасны хэмжээ А/6 86 нүүр бүхий аргачлал, зөвлөмж багтаж байгаа бөгөөд 2022 онд багтаж Соёлын яамны санхүүжилтээр хэвлэгдэнэ. Уг “Монгол Улсын баримтат өвийн бүртгэл”-д нэр дэвшүүлэх дурсгалыг бүртгэх аргачлал гарын авлагын цахим хувилбарыг тус Үндэсний төвийн ncch.gov.mn цахим хуудсанд байршуулсан.

ЮНЕСКО-гийн Соёлын өвийн хадгалалт, сэргээн засварлалт, судалгааны олон улсын төвөөс музейн үзмэр, эд өлгийн зүйлсийг онцгой нөхцөлд нүүлгэн шилжүүлэхэд зориулсан Emergency Evacuation of Heritage Collections (Эрсдэлийн үед соёлын өвийг нүүлгэн шилжүүлэх) гарын авлагыг англи хэлнээс орчуулж түгээх оюуны өмчийн эрхийн зөвшөөрлийг тус байгууллагаас албан ёсны эрхтэй хэвлэн, түгээв. Тус бүтээл нь А5 хэмжээтэй, 56 нүүр бүхий удиртгал, үнэлэх, Бэлтгэх, Баримтжуулаад, савлаад хөдлөх, Нүүлгэн шилжүүлэх, хадгалах гэсэн 5 дэд сэдэвт агуулгатай бөгөөд музейн тухай хуульд заасанчлан музейн сан хөмрөгийг гамшиг болон аюулын үед нүүлгэн шилжүүлэх журмыг боловсруулахад гарын авлага, эх сурвалж болох юм.

2.5.5. *Соёлын биет бус өвийн олон улс, бүсийн хэмжээний уралдаан наадам зохион байгуулахад мэргэжил арга зүй, бүртгэл судалгаа, баримтжуулалтын чиглэлээр хамтран оролцож, соёлын өвийг мэдээллийн сан үүсгэнэ.*

- ЮНЕСКО-гийн санхүүжилтээр хэрэгжсэн “Монгол ардын уртын дуу лимбэдэх уламжлалт арга-битүү амьсгааг хойч үед өвлүүлэн уламжлуулах, тогтворжуулах нь” төслийн хүрээнд өвлөн суралцагчдын дунд 2022 оны 6 дугаар сард уралдаант наадам, үзлэг зохион байгуулж, олон нийтэд түгээн сурталчлав. Үүнд:

- “Монгол уртын дуу лимбэдэх уламжлалт арга-Битүү амьсгаа өвийг өвлөн суралцагчдын Анхдугаар уралдаан”-нд Улаанбаатар хот болон Говь-Алтай, Дорноговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Хөвсгөл зэрэг 7 аймгийн нийт 11 багш, 40 шавь суралцагч оролцсон, "

- Уртын дуу лимбэдэх уламжалт арга битүү амьсгаа-Тогтвортой хөгжил” Эрдэм шинжилгээ-Онол практикийн бага хурал,

- “Монгол уртын дуу лимбэдэх уламжлалт арга-битүү амьсгаа” Гала тоглолт, “Монгол лимбэчид ба өвлөн уламжлагчид” Монгол лимбэчдийн намтар, танилцуулга бүхий 500 ш ном, “Монгол лимбэчдийн бүтээлийн дээжис” СД 300 ш байна.



Зураг 27. “Монгол ардын уртын дуу лимбэдэх уламжлалт арга-битүү амьсгааг хойч үед өвлүүлэн уламжлуулах, тогтворжуулах нь” төслийн хаалт

- Дорнод аймгийн Хөлөнбуйр суманд зохион байгуулагдсан "Баргажин -2022" наадамд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, өвлөн уламжлагчийг баримтжуулан нийт 24GB гэрэл зураг, 300 GB дүрс бичлэгийн баримтжуулалт хийв.

Зураг 28. Баргажин наадам

- “Нүүдэлчин Монгол 2022” Соёлын биет бус өвийн наадмын хүрээнд “Соёлын өвийн хүрээ”-“Нүүдлийн соёл иргэншлийн үнэт зүйлс- Хүн төрөлхтний соёлын биет бус өв” өргөөний үйл ажиллагааг хариуцан ажиллахын сацуу тус наадмыг зохион байгуулах, шүүх, Соёлын яамны харьяа байгууллагуудыг арга зүйгээр хангаж ажиллав.

Зураг 29. “Нүүдэлчин Монгол 2022”

- Хэнтий аймгийн Батноров суманд жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Талын түмэн адуу-2022” соёл, аялал жуулчлалын эвентийн хүрээнд Соёлын яам, Соёлын өвийн үндэсний төв, ШУА-ийн Археологийн хүрээлэн, Чингис хааны өв соёлын хүрээлэн хамтран соёлын биет болон биет бус өвийг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор соёлын өвийн танин мэдэхүйн мэдлэг, ойлголт, Монгол уран дархан, Батноров хийцийн онцлог, уламжлал, Батноров хийцийн бүтээлийн танилцуулгыг олон нийтэд хүргэж зохион байгуулсан.

Зураг 30. Талын түмэн адуу-2022

2.5.6. *“Соёлын бүтээлч сар” төрөлжсөн үйл ажиллагааг зохион байгуулж, төрөлжсөн хэлэлцүүлэг зохион байгуулж, үр дүнг олон нийтэд сурталчилж, тайлагнана.*

Соёлын өвийн судалгаа, хадгалалт хамгаалалт, өнөөгийн байдлын олон талт сэдвийн хүрээнд 1 эрдэм шинжилгээний хурал, 1 зөвлөгөөн, 3 хэлэлцүүлэг, 2 сургалт, хүүхэд залуусын соёлын боловсролд зориулсан 3 сурталчилгааны ажлыг Соёлын яам, бусад холбогдох газрууд болон Үндэсний төв бие даан зохион байгуулсан.

“Монголын уламжлалт анагаах ухаан” сэдэвт эрдэм шинжилгээний хурал, бэсрэг үзэсгэлэн:

Соёлын яам, Соёлын өвийн үндэсний төв хамтран “Монголын уламжлалт анагаах ухаан” сэдэвт эрдэм шинжилгээний хурал, бэсрэг үзэсгэлэн зохион байгууллаа. Тус эрдэм шинжилгээний хурлаар уламжлалт анагаах ухааны олон хэлбэрийг судлах, хадгалан хамгаалах, сурталчлах, сэргээн ашиглахад тулгамдаж байгаа асуудлуудыг хэлэлцүүлэв. Хурлын үеэр Монгол Улсын Үндэсний номын сан, Богд хааны ордон музей, Байгалийн түүхийн музей, Ач анагаах ухааны их сургуультай хамтарсан уламжлалт анагаах ухааны үзлэг оношилгоо, уламжлалт

анагаах ухаанд холбогдох үзмэр, эд өлгийн зүйл, сэдвийн хүрээн дэх судалгааны бүтээлүүдийн бэсрэг үзэсгэлэнг гарган олон нийтэд хүргэв. Тус үйл ажиллагаанд Соёлын яамны Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга болон мэргэжилтнүүд, Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар, нийслэлийн Соёл урлагийн газар, улсын болон орон нутгийн музейн захирал, албан хаагчдын төлөөлөл, Ач анагаах ухааны их сургууль, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн багш, оюутнууд хамтран ажилладаг байгууллагуудын төлөөлөл, сонирхогчид ирж нийт 120 орчим хүн хамрагдлаа. Энэхүү эрдэм шинжилгээний хурал нь Монголын уламжлалт анагаах ухааны түүхэн хөгжил, бүтээл туурвилыг таниулах, уламжлалт анагаах ухааны мэдлэг, арга ухааныг олон нийтэд сурталчлах, өвлөн уламжлуулах, хэрэглээ, ач холбогдолыг нэмэгдүүлэхэд тодорхой үүрэг гүйцэтгэлээ.

Зураг 31. "Монголын уламжлалт анагаах ухаан" сэдэвт эрдэм шинжилгээний хурал, бэсрэг үзэсгэлэнгийн үйл ажиллагаа

"Соёлын өв-тогтвортой хөгжил" соёлын өвийн улсын хоёрдугаар зөвлөгөөн:

"Соёлын өв - тогтвортой хөгжил" соёлын өвийн улсын хоёрдугаар зөвлөгөөнийг 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Соёлын өвийн үндэсний төвийн байранд зохион байгууллаа. Монгол үндэстэн, угсаатны үнэт зүйлс болох соёлын өвд түшиглэсэн соёл, аялал жуулчлал, бүтээлч үйлдвэрлэлийн орон зайг хөгжүүлэх, тогтвортой хөгжлийг бий болгох зорилго бүхий тус зөвлөгөөн "Соёлын өв-тогтвортой хөгжил" сэдвийн хүрээнд, өнөөгийн хөгжлийн түвшин, цаашдын чиг хандлагаа тодорхойлоход чиглэгдсэн.

Тус зөвлөгөөнд Соёлын яам, ЗГХА Соёл, урлагийн газар, Эдийн засаг, хөгжлийн яам, Цахим хөгжлийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Гадаад харилцааны яам, Цагдаагийн ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Оюуны өмчийн газар, ЮНЕСКО Монголын Үндэсний Комисс, аймаг, нийслэлийн соёл, урлагийн газар, улс, аймгийн музей, сумдын соёлын төвийн төлөөлөл оролцож:

- Соёлын өвийг хамгаалах, сэргээх, хөгжүүлэх талаар Монгол Улсыг хөгжүүлэх урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогод туссан зорилт арга хэмжээг хэрэгжүүлэхэд салбар дундын хамтын ажиллагаа чухал үүрэгтэйг хүлээн зөвшөөрч;
- Төрийн болон төрийн бус байгууллага болон иргэний нийгмийн байгууллага бусад оролцогч талууд соёлын өвийг хамгаалах хүрээнд идэвхтэй хамтран ажиллахыг уриалж;

- Соёлын өвийн анхдугаар зөвлөгөөнөөс гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийг хангахад төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагууд хүчин чармайлт гаргаж ажилласныг сайшааж;
- Соёлын өвийг хамгаалах, сэргээх, хөгжүүлэх талаар иргэн, бүлэг хүмүүсийн дэвшүүлж буй санал санаачилгыг төрөөс хөхиүлэн дэмжиж, шаардлагатай туслалцаа үзүүлэх хэрэгцээ байгааг сануулж цаашид тогвортой хөгжлийг бий болгох зөвлөмж гаргав.

Зөвлөгөөнд соёлын өвийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон орон нутгийн 60 гаруй байгууллага, хувийн хэвшлийн 10 гаруй байгууллага, нийт 130 гаруй төлөөлөгч оролцов.

Зураг 32. “Соёлын өв-тогтвортой хөгжил” соёлын өвийн улсын хоёрдугаар зөвлөгөөн

“Олон угсаатны соёлын өв” цуврал арга хэмжээ:

Монгол Улсын олон угсаатны соёлын онцлог, олон талт байдлыг таниулан сурталчлах, олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх зорилго бүхий “Олон угсаатны соёлын өв” цуврал арга хэмжээг зохион байгуулж танхим болон цахим хосолсон хэлбэрээр олон нийтэд хүргэлээ.

Арга хэмжээний хүрээнд “Дөрвөд, баяд бий биелгээ” өвийг сурталчлах өдөрлөг, “Урианхай түмний соёл”, “Буриад, Хамниган угсаатны уламжлалт соёл” сэдэвт цуврал арга хэмжээг зохион байгуулж 350 орчим иргэнд таниулан сурталчилав. Цуврал арга хэмжээнд Баяд бий биелгээч Г.Баяртай, Угсаатны зүйч доктор (Ph.D), профессор М.Ганболд, Мандах Их Сургуулийн ахлах багш, Түүх угсаатан судлаач, доктор (Ph.D), дэд профессор О.Баттуяа нар олон угсаатны соёлын өв, уламжлалын талаарх мэдлэг ойлголт өгөв.

Зураг 33. “Олон угсаатны соёлын өв” цуврал арга хэмжээ

“Дэлхийн өв-Бурхан Халдун” эвент:

Орон нутагт дэлхийн өвийн тухай мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, сурталчлах, өвийн газар нутагт очсон мэт бодит мэдрэмжийг өгөх виртуал аялал, дурсгалт газрын үнэ цэн, ач холбогдлыг таниулах зорилготой “Дэлхийн өв-Бурхан Халдун” эвентыг Соёлын өвийн үндэсний төв, Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийн хамгаалалтын захиргаатай хамтран "Бэрх Олон Улсын Сургууль", "Бэрх хотын ЕБС"-ийн багш, сурагчдад амжилттай зохион байгуулав. Бэрх хот дахь Олон улсын сургуулийн 112 сурагчдад соёлын өвийн тухай танилцуулга хийж, тус сургуулийн түүх-нийгмийн танхимыг ЮНЕСКО-д бүртгэгдсэн соёлын биет бус өвийн танилцуулга бүхий самбараар тохижуулав.

Зураг 34. “Дэлхийн өв-Бурхан халдун” эвент

“Соёлын өвийн мэдлэг, ойлголт” сургалт:

"Соёлын бүтээлч сар" аяны хүрээнд Соёлын яам, Соёлын өвийн үндэсний төв, Монголын Бурханы шашинтны төв Гандантэгчэнлин хийд хамтран сүм хийдийн түүхэн дурсгалт барилга байгууламж хийгээд соёлын өвд хамаарах бурхан шүтээн, тахил, эд өлгийн зүйлийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилготой **“**Соёлын өвийн мэдлэг, ойлголт” сэдэвт сургалтыг 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр Монголын Бурханы Шашинтны төв Гандантэгчэнлин хийдийн Батцагаан дуганд танхим болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулсан. Тус сургалтаар Монголын Бурхан шашинтны төв Гандантэгчэнлин хийд, орон нутаг дахь хийдийн тэргүүн лам нарт соёлын биет болон биет бус өвийн талаарх мэдлэг ойлголт, соёлын өвийг хамгаалах хууль эрх зүй, соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн тухай, соёлын өвийн хадгалалт, хамгаалалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Соёлын яамны Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Даваацэрэн “Төрөөс хэрэгжүүлж буй соёлын өвийн бодлого”, Соёлын өвийн үндэсний төвийн захирал, доктор (Ph.D) Г.Энхбат “Соёлын өвийн мэдлэг, Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн сангийн тухай”, Соёлын өвийн үндэсний төвийн Ерөнхий бүртгэл, мэдээллийн санч Б.Эрдэнэсувд “Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн сан дахь бурхны шашны холбогдолтой өвийн танилцуулга”, Соёлын өвийн үндэсний төвийн Баримтат өв хариуцсан бүртгэл, мэдээллийн санч Х.Түмэнбаяр “Бурхны шашны холбогдолтой баримтат өв”, Соёлын өвийн үндэсний төвийн Бүртгэл, мэдээллийн газрын дарга А.Саруул “Сүсэг бишрэл ба соёлын биет бус өв”, Соёлын өвийн үндэсний төвийн Хадгалалт хамгаалалт, технологийн судалгааны газрын дарга, доктор (Ph.D) М.Оюунтулга “Соёлын биет өвд хадгалалт хамгаалалтын шинжлэх ухааныг ашиглах нь” сэдвээр илтгэл хэлэлцүүлж, оролцогчдын зүгээс асуусан асуултад хариулан ярилцлага өрнүүлсэн. Сургалтад танхимаар 38, цахимаар 26 лам, хувраг хамрагдав.

Зураг 36. Соёлын өвийн мэдлэг, ойлголт" сургалт

2.5.7.*"Соёлын биет бус өвийг үндэсний болон дэлхийн хэмжээнд сурталчлан алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагчид мөнгөн шагнал олгох журам"-ын хэрэгжилтийг ханган, Соёлын яаманд нэр дэвшсэн өвлөн уламжлагчдын мэдээллийг нэгтгэн хүргүүлнэ.*

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 354 дүгээр тогтоолын хавсралт "Соёлын биет бус өвийг сурталчлан алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагчид мөнгөн шагнал олгох журам"-ын дагуу шагналд нийт 19 өвлөн уламжлагч нэр дэвшсэн байна. Эдгээр 19 өвлөн уламжлагч нь эх хэл болон аман уламжлал илэрхийллүүд 2, ардын язгуур урлаг 4, үндэсний уламжлал зан үйл, ёслол, байр наадам 4, уламжлалт арга ухаан 1, ардын уламжлалт гар урлаг 8 байна. Нэр дэвшигчдээс Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 475 дугаар тогтоолоор "Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалт"-д бүртгэгдсэн 5 хүн байв.

Нэр дэвшсэн 19 өвлөн уламжлагчдыг тус бүрчлэн 8 байгууллагаас санал авах ажлыг зохион байгуулж 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр Соёлын биет бус өвийн мэргэжлийн зөвлөлд хүргүүлсэн. 2021 онд Соёлын биет бус өвийг сурталчлан алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагчаар Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын малчин, хөхүүр урлаач Д.Гүндэгмаа шалгарсан.

САНАЛЫН ДЭЛГЭРЭНГҮЙ

	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар	Шинжлэх Ухааны академи	ЮНЕСКО-гийн Монголын үндэсний зөвлөл	СУИС-Эрдмийн зөвлөл	Монголын Урлагийн Зөвлөл	Соёлын өвийн сүлжээ, харилцаа холбоны зөвлөл	Байгаль, соёлын өвийг хамгаалах сан	Соёлын биет бус өвийн нийгэмлэг
Н. Гүндэгмаа	1	0	0	0	1	1	1	1

Зураг 35. 2021 оны шилдэг өвлөн уламжлагч Д.Гүндэгмаа

2.5.8. *ЮНЕСКО-д бүртгэгдсэн 15 соёлын биет бус өвийг сурталчлах, үзэсгэлэн зохион байгуулахад музейг мэргэжил арга зүйгээр ханган хамтран ажиллана.*

ЮНЕСКО-ийн соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэгдсэн 15 соёлын биет бус өвийг сурталчлахад дараах 4 музейтэй хамтран 6 арга хэмжээг зохион байгуулж, мэргэжил арга зүй, холбогдох гэрэл зураг, өвлөн уламжлагчийн мэдээллээр ханган, зохион байгуулагдсан арга хэмжээнд илтгэл, танилцуулга хийлээ. Үүнд:

- Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейд "Монгол шагайн харваа"; “Уул овоо тахих зан үйл”



Зураг 36. Дүрслэх урлагийн музейтэй хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээ

- Монголын Театрын музейд “Монгол бий биелгээ, уламжлалт бүжгийн урлал”, Монгол Лимбэчдийн уртын дуу тоглох уламжлалт арга барил-битүү амьсгаа”

Зураг 37. Монголын театрын музейтэй хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээ

- “Чойжин ламын сүм музей; “Монгол цуур хөгжмийн уламжлалт урлаг”

Зураг 38. Чойжин ламын сүм музейтэй хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээ

- Байгалийн түүхийн музей "Шувуучлахуй", "Ботго авахуулах зан үйл” өв

Зураг 39. Байгалийн түүхийн музейтэй хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээ

ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД:

3.1.4 *Байгууллагын 2022 оны үйл ажиллагаанд батлагдсан төсвийн хэрэгжилтийг ханган ажиллана.*

2022 онд 1,378,494.9 төгрөгийн төсөв батлагдснаас 1-11 сарын хугацаанд 936,624,498.32 төгрөгийг төсвийн хуваарийн дагуу зарцуулж, хуулийн хугацаанд төсвийн зарцуулалтын мэдээллийг Шилэн дансанд байршуулсан. Шилэн дансны шалгалтаар I улиралд 97.3%, II улиралд 98.6%, III улиралд 99.1 %-тай дүгнэгдсэн бөгөөд IV улирлын шилэн дансны шалгалт 2023 оны 1-р сард дүгнэгдэнэ.

III улирлын байдлаар санхүүгийн аудитын явцын шалгалт эхлээгүй байгаа бөгөөд санхүүгийн баримтуудыг үдэж хавтаслан бэлтгэл ажил хангагдсан. Байгууллагын үндсэн үйл ажиллагаа чиг үүргийн хэрэгжилтийг хангаж батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан.

3.2.2 *Ажилтны ажлын бүтээмж, гүйцэтгэл, ур чадварыг журмын дагуу шалгуур үзүүлэлтээр дүгнэн ур чадварын нэмэгдэл, үр дүнгийн урамшуулал, шагнал олгож, үнэлж, урамшуулна.*

2022 оны 9 дүгээр сард зохион байгуулагдсан Соёл, урлагийн ажилтны өдрийг тохиолдуулан ур бүтээлтэй ажиллаж байгаа шилдэг 2 ажилтан “Соёлын тэргүүний ажилтан” цол, тэмдгээр шагнагдсан.

Үндэсний төвд ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан 8 ахмад, олон жил үр бүтээлтэй ажиллаж буй 50-иас дээш настай 14 ажилтан (нийт 22 хүн)-г Ардын хувьсгалын 100, 101 жилийн ойн медалиар шагнуулахаар яаманд хүргүүлсэн ба одоогоор хариу шийдвэр ирүүлээгүй байна.

Жил бүрийн 12 дугаар сард тэмдэглэн өнгөрүүлдэг манай улсад орчин цагийн музей үүсч хөгжсөний ойг тохиолдуулан Монгол Улсад музейн үзмэрийг сэргээн засварлах (1988 оноос эхлэн) байгууллагын суурийг тавилцаж, хөгжүүлэх үйлсэд тууштай, үр бүтээлтэй ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан ууган ажилтнуудын нэг болох 1 өндөр настанг салбарын шагнал “Соёлын тэргүүний ажилтан” цол, тэмдгээр, 2 өндөр настаг төрийн одон “Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар шагнуулахаар хамт олны хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, зохих материалыг бүрдүүлэн Соёлын яаманд хүргүүлхэд бэлэн болгосон.

Нийт ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг сар бүр дүгнэж, ур чадварын нэмэгдлийг 25 хүртэл хувиар тооцож, 11 дүгээр сарын байдлаар 58 ажилтанд 104,330,792.46 төгрөгийн ур чадварын нэмэгдлийг;

Үндэсний төвийн захирлын 2022 оны А/19 тоот тушаалаар шинэчлэгдэн батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”-д үр дүнгийн урамшууллыг улирал тутамд олгох тухай нэмэлт өөрчлөлт орж, 2 дугаар улирлаас эхлэн хэрэгжүүлж эхэлсэн ба 3 дугаар улирлын байдаар 58 ажилтанд 42,353,781.4 төгрөгийн үр дүнгийн урамшууллыг тус тус олгосон байна.

Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийн үр дүнг жилийн эцэст дүгнэж сайн ажилласан 10 хүртэл ажилтанг мөнгөн урамшууллаар шагнахаар төлөвлөсөн. Засгийн газрын тогтоолын дагуу олгож байгаа ур чадварын болон үр дүнгийн мөнгөн урамшуулал нь ажилтнуудын мэдлэг чадварыг нэмэгдүүлэх хөшүүрэг болж ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэхэд эерэг нөлөө үзүүлж байна.

3.2.5. *Сэргээн засварлах ажилд химийн бодис ашиглах, худалдан авах тусгай зөвшөөрлийг холбогдох дэд байгууллагаас авч, үйл ажиллагаандаа ашиглана.*

Сэргээн засварлах ажилд химийн бодис ашиглах тусгай зөвшөөрөл авахтай холбогдуулан Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Химийн хортой аюултай бодисын тухай, Хог хаягдлын тухай зэрэг холбогдох хууль тогтоомж, Химийн бодисын агуулах MNS 6458:2014 Монгол Улсын стандартын шаардлагуудыг ханган ажиллаж, Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас “Химийн бодис ашиглах тусгай зөвшөөрөл”-ийг 2022 оны 9 дүгээр сард авсан. Химийн бодис ашиглах тусгай зөвшөөрлийн хүрээнд:

- Хан-Уул дүүргийн Онцгой байдлын газраар хянуулж “Химийн ослоос урьдчилан сэргийлэх, ослын үед ажиллах төлөвлөгөө”-г батлуулсан (2022.7.07),
- нийслэлийн Мэргэжлийн хяналтын газраас “Химийн бодисын агуулахын дүгнэлт” гаргуулсан (2022.7.18),
- нийслэлийн Байгаль орчны газраар “Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн Ерөнхий үнэлгээ” хийлгэсэн (2022.8.03),

- тусгай зөвшөөрөлтэй компанитай химийн бодис нийлүүлэх, шилжүүлэх, хог хаядлыг устгалд оруулах гэрээнүүдийг байгуулсан,
- стандартад нийцүүлэн химийн бодис агуулах агуулах өрөөг засаж тохижуулсан,
- сэргээн засварлагчдыг хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслээр хангасан,
- химийн бодистой ажиллах үеийн аюулгүй ажиллагааны дотоод журмыг боловсруулсан,
- хадгалалт хамгаалалт, технологи судалгааны газар Ариутгалын технологич (химич) гэсэн орон тооны үндсэн ажлын байрыг бий болгосон зэрэг шат дараалсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж, Монгол Улсын байгаль орчин хийгээд химийн бодисийн ашиглалттай холбогдох хууль тогтоомжуудыг мөрдөж, хөдөлмөрийн эрүүл ахуй аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

3.2.6. *Сэргээн засварлалтын ажилд хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор сургалт зохион байгуулж, ажилчдын эрүүл мэндийг хамгаалж, урьдчилан сэргийлнэ.*

Химийн бодис хадгалах, ашиглах, харьцах, хөдөлмөр хамгаалал аюулгүй байдлын сургалтыг 2 удаа зохион байгуулсан ба сургалтад 15 сэргээн засварлагч, хадгалалт хамгаалалтын 3 ажилтан хамрагдав. Сургалтаар химийн бодистой харьцах, ашиглах үед хэрэглэх багаж хэрэгслийн талаарх мэдлэг ойлголтоо дээшлүүлсэн.

Ажилтнуудыг химийн бодистой харьцах, хөдөө орон нутаг томилолтоор ажиллах үед хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны заавар зөвлөгөөг өгч "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны заавар зөвлөгөөний дэвтэр"-т тэмдэглэж байна. Хөдөлмөр хамгаалал аюулгүй байдал, "Ковид-19" цар тахлаас урьдчилан сэргийлж 120.000 төгрөгийн үнэ бүхий 7 хайрцаг маск, 5 ширхэг гар ариутгах бодисоор хангасан нь хадгалалт хамгаалалт болон сэргээн засварлах газрын мэргэжилтнүүд анхан шатанд химийн бодис хэрэглэгдэхүүнээс урьдчилан сэргийлж, аюулгүй байдлыг ханган ажиллах боломж бүрдсэн.

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

Зорилт 4.1 Соёлын өвийн чиглэлээр иргэн, хуулийн этгээдэд лавлагаа, мэдээлэл өгөх, хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах, соёлын өвийг таньж тогтоох үйлчилгээг чанартай шуурхай үзүүлж, салбарын ажилтныг мэргэжил арга зүйгээр ханган, авилгаас ангид, санхүүгийн сахилга баттай байж, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг байгууллагын вэб хуудас, цахим орчинд нээлттэй мэдээлнэ.(Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.3 дахь заалт)

4.1.1 *Иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр соёлын өвийн лавлагаа, мэдээллийг түргэн шуурхай олгож, зөвлөмжийг байгууллагын вэб хуудас, цахим орчинд байршуулна.*

2022 онд 64 байгууллага, 490 иргэнд мэргэжил аргазүйн зөвлөгөө, 38 байгууллага, 8 иргэнд лавлагаа мэдээлэл олгов.

Мэргэжил аргазүйн зөвлөгөө:

- Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллого, бүртгэн баримтжуулалтын чиглэлээр 21 аймгийн Соёл, урлагийн газрын соёлын өв хариуцсан мэргэжилтэнүүдэд;
- Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэлийн чиглэлээр Чингис хаан музей, Үндэсний төв архив, Ховд их сургууль, Дотоод хэргийн их сургууль, “Женкотур бюро” ХХК, Нисэхийн түүхийн музей, Хэнтий аймгийн музей, Хэнтий аймгийн Баян-Овоо сумын ОНСТ, Сүхбаатар аймгийн 4 сумдын ОНСТанхим нийт 11 байгууллага, 42 иргэнд;
- Баримтат өвийн бүртгэл, урьдчилсан жагсаалтын чиглэлээр 32 байгууллага, 446 иргэнд;
- Соёлын биет бус өвийн бүртгэлийн чиглэлээр 20 байгууллага, 2 иргэнд.

Лавлагаа, мэдээлэл:

- Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл, археологийн хайгуул, малтлага судалгааны чиглэлээр 3 иргэн, 12 хуулийн итгээдэд нийт 15 лавлагаа, мэдээлэл;
- Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл, мэдээлэл, судалгааны чиглэлээр 18 байгууллага, 2 иргэнд нийт давхардсан тоогоор 26 удаагийн лавлагаа, мэдээлэл, 3.17GB цахим файл;
- Соёлын биет өвийн талаарх лавлагаа, мэдээллийг 8 байгууллагад, соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч 3 иргэнд бүртгэгдсэн тухай тодорхойлолтыг тус тус албан бичгээр хүргүүлэв.

Нийт давхардсан тоогоор 102 байгууллага, 498 иргэнд мэргэжил аргазүйн зөвлөгөө болон соёлын өвийн мэдээлэл лавлагаа олгож, төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэв.

***4.1.2** Иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр соёлын биет өвийг таньж тогтоох үйлчилгээ үзүүлж, дүгнэлт гарган, хариуг албан бичгээр хүргүүлнэ.*

2022 онд иргэн, байгууллагын нийт 210 ширхэг эд зүйлийг таньж тогтоох үйлчилгээ үзүүлж, хариуг албан бичгээр хүргүүлэв. Үүнээс 4 удаагийн 108 ширхэг эд зүйлд шинжээчийн дүгнэлт, 12 иргэний 40 ширхэг эд зүйлийг тодорхойлж Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгэсэн, 2 иргэний 2 ширхэг эд зүйлийг түүх, соёлын дурсгалт зүйлд хамаарахыг, 18 иргэн, аж ахуй нэгжийн 90 ширхэг эд зүйлийг түүх соёлын дурсгалт зүйлд хамаарахгүйг тус тус тодорхойлсон. Ажлын үр дүнд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлийн хэрэгжилт хангагдаж, соёлын өвийн хамгаалалт сайжрахад тодорхой хувь нэмэр оруулав.



СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ

2022 оны 10 дугаар сарын 07-ны өдөр Улаанбаатар хот

Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газраас ирүүлсэн 01/427 тоот албан бичиг, мөн 2022 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн Шинжээч томилж, шинжилгээ хийлгэх тухай тогтоолд заасан"...2203000156 дугаартай 82 ширхэг эд зүйлийг..." соёлын өв мөн эсэхийг ТОГТООХДОО:

- Соёлын өвийн үндэсний төвийн Хадгалалт хамгаалалт, технологи судалгааны газрын дарга, доктор М.Оюунтулга, Ерөнхий буртгэл, мэдээллийн санч Б.Эрдэнэсувд, Баримтат өв хариуцсан буртгэл, мэдээллийн санч Х.Түмэнбаяр нар шинжээчээр ажиллав.

ТОГТООСОН НЬ:

- Уг эд зүйлийг биетээр нь нүдээр үзэж, хийсэн арга ажиллагаа, материал зэргийг тусгай мэдлэг, мэргэжлийн дадлага туршлага дээрээ тулгуурлан, ЕРТА /Трилон-Б/ уусмалаар тестелж, шинжлэн тогтоов.

ДҮГНЭХ НЬ:

1. **Эдгээр дурсгалт зүйлс нь соёлын өвд хамаарах эсэх,**
2. **Соёлын өвийн аль ангилалд хамаарах,**
3. **Эдгээр дурсгалт зүйлсийн зах зээлийн үнэлгээг тогтоолгох** гэсэн асуултанд хариу дүн шинжилгээг хийж, дүгнэлтийг (Хүснэгт №1,2,3) хүргүүлж байна.

Хэрэгт шалгагдаж буй нийт 82 ширхэг зоосыг 3 ангилан тодорхойлов.

Үүнд:

- Гялгар уутан савтай, хатуу цаасаар битүүмжилсэн 12 ширхэг-1 дүгээр хэсэг,
- Гялгар уутан савтай 8 ширхэг зоос-2 дугаар хэсэг,
- Хуванцар савтай 62 ширхэг зоос-3 дугаар хэсэг

2.	Зоос 1.2.	Диаметр 3.1 см. *"Нэетэрхий эрдэнэ"* хэмээх хятад ханз бичигтэй, хүрэл зоос	1.2.	
3.	Зоос 1.3.	Диаметр 3.1 см. Бичвэрийг тайлах боломжгүй, хүрэл зоос	1.3.	
4.	Зоос 1.4.	Диаметр 3.4 см. Бичвэрийг тайлах боломжгүй, хүрэл зоос	1.4.	
5.	Зоос 1.5.	Диаметр 3.2 см. *"Нэетэрхий эрдэнэ"* хэмээх хятад ханз бичиг бүхий хүрэл зоос	1.5	
6.	Зоос 1.6.	Диаметр 3.1 см. *"Нэетэрхий эрдэнэ"* хэмээх хятад ханз бичиг бүхий хүрэл зоос	1.6.	

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ, ТЕХНОЛОГИ СУДАЛГААНЫ ГАЗАР
ОРЦ, НАЙРЛАГА ТОДОРХОЙЛОХ ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

2022 оны 11 дугаар сарын 17-ны өдөр Улаанбаатар хот

Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэсээс ирүүлсэн 8/9338 тоот албан бичиг, мөн 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн Шинжээч томилж, шинжилгээ хийлгэх тухай тогтоолд заасан "...Г-716 дугаартай хэрэгт шалгагдаж байгаа Ховд аймгийн Бүрэт сумын нутгаас олдсон гах эд зүйлийн..." орц найрлагыг тогтоох шинжилгээг зөөврийн XRF (X-ray fluorescence) рентген флуоресценцийн төхөөрөмж ашиглан хийв.

Төхөөрөмжийн загвар: OXFORD X-MET 7500

Тохиргоо: Alloy_FP тохиргоогоор 30.5 секунд шинжилгээ хийв.

Эд өлгийн зүйлсийн мадаагаар:

№	Нэр	Тоо ширхэг	Хэмжээ, жин	Зураг	Химийн элементийн найрлага Oxford x-met 7500 (Soil_LE_FP)
1.	Хүрэл тогоо	1 ш	Жин-1.1 кг, Өндөр-15.7 см, Аяганы голч-12.9 см		**Cu-61.83% As-11.23% Pb-4.29% Bi-1.11% Fe-0.52% Sb-0.52% Sn-0.38% Ni-0.16% Ag-0.12% Zn-0.04% Mn-0.04% Se-0.04% Zr-0.00%** Cu-Зэс **As**-Хүнцэл **Pb**-Хар тугалга **Bi**-Висмут **Fe**-Төмөр **Sb**-Сурьма **Sn**-Цагаан тугалга **Ni**-Никель **Ag**-Мөнгө **Zn**-Цинк **Mn**-Манган **Se**-Селен **Zr**-Цирконий
2.	Хүрэл толь	2 ш	1. Жин-112 гр, Хэмжээ-12x7.6 см 2. Жин-97 гр, Хэмжээ11.9x7.6 см		**Cu-80.42% As-3.84% Sn-2.98% Pb-1.33% Fe-0.96% Ag-0.15% Sb-0.12% Ni-0.09% Zn-0.09% Bi-0.03% Mn-0.03% Se-0.01% Zr-0.00** Cu-Зэс **As**-Хүнцэл **Sn**-Цагаан тугалга **Pb**-Хар тугалга **Fe**-Төмөр **Ag**-Мөнгө **Sb**-Сурьма **Ni**-Никель **Zn**-Цинк **Bi**-Висмут **Mn**-Манган **Se**-Селен **Zr**-Цирконий

Соёлын өвийн үндэсний төвийн 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 01/777 албан бичгийн хавсралт

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

ТОДОРХОЙЛОЛТ

2022 11 сарын 22-ны өдөр Улаанбаатар хот

Ирэгэн Сүхцарангийн Менхбадрагчаа ирүүлсэн "...Зааг тэрэгэн гах газраас олдсон шиг металл эд зүйл олсон болно. Иймд тус эд зүйлийг соёлын өвд хамаарах эсэхийг тогтоож өгнө үү..." хүсэлтийн дагуу уг эд зүйлийг биетээр нь үзэж, хийсэн арга ажиллагаа, материал зэргийг шинжин, тусгай мэдлэг, мэргэжлийн дадлага туршлага дээрээ тулгуурлан түүх, соёлын дурсгалт зүйл, соёлын өв болохыг тодорхойлов.

Товч мэдээлэл

Нэр: Сэлэм

Хэмжээ: Урт-76см, ергөн- 3см, бариулны урт-13.5см

Материал, хийц: Төмөр, мөнгө, зэс

Дурсгал: Шүрэн шиштэгтэй өнгөт металл чимэглалтай нимгэн төмөр бариултай хат багатай төмөр сэлэм. Монгол даркны арганд салмийн их бие хэсгийг горидсон дараа нь ирэгсэн байна. Он цагийн яацад хэлбэрээ алдсан. Бариулыг их биеэс нь шууд нарийссан гаргаж үзүүрийг нь тавласан. Нимгэн төмөр бариул эзэд сорогдсон, хоёр хэсэг салсан. *(нимгэн төмөр бариул нь дотроо модон бариултай байсан бөгөөд он цаашін яацад алга болсон)* Ишний ард жижиг зэс санктай. Бариул нь Төвөд маягийн хөөмөл чимэглалтай. Мөн 2 зэс бөгж нимгэн төмөр хийцтэй балгатгай. Материал (хат багатай) шинж байдал (Төвөд маягийн хөөмөл чимэглалтай)-аас үзэхэд, үүгээр зорилгоор нь дайн байгаваны зорилгоор биш шашны зан үйлийн зорилгоор зэд болоотой.

Металлын орц найрлагыг тогтоох шинжилгээг зөөврийн XRF (X-ray fluorescence) рентген флуоресценцийн төхөөрөмж ашиглан хийж тодорхойлоогдсон хавсаргав.

Гэрэл зураг

1/2

Соёлын өвийн үндэсний төвийн 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 01/777 албан бичгийн хавсралт

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

ТОДОРХОЙЛОЛТ

2022 оны 11 сарын 18-ны өдөр Улаанбаатар хот

Ирэгэн Баттөмөрийн Дулмаагийн ирүүлсэн "...Сангийн бойлор (том)-1ш, Сангийн бойлор (урт)-1ш, Сангийн бойлор (жижиг)-1ш, Төмөр ваарын тавиур, ВааР-2ш, Модон бариултай тосны сав-1ш, Рашаны дашмаг (төмөр)-1ш, Саалийн хувин (модон тонотой)-1ш эд зүйлсийг түүх, соёлын дурсгалт зүйл, соёлын өвд хамаарах эсэхийг тодруулах..." хүсэлтийн дагуу тухайн эд зүйлсийг түүх, соёлын дурсгалт зүйлд хамаарах эсэхийг ТОГТООХДОО:

- Уг эд зүйлийн биетээр нь үзэж, хийсэн арга ажиллагаа, материал, дурсгал зэргийг шинжин тусгай мэдлэг, мэргэжлийн дадлага туршлага дээрээ тулгуурлан тогтоов.

ТОГТООСОН НЬ:

Товч тодорхойлолт

Нэр: Сангийн бойлор (том)

Хэмжээ: Сангийн бойлор: өндөр-32см, таглайгаа-45.5см, ергөн-38см, амсрын диаметр-19.5см

Таг: өндөр-19.4см, диаметр-18.2см

Материал, хийц: Гууль цутгамал, шинэ цагийн хийц

Дурсгал: Хоёр луун сэнхтэй хоёр бөөрөндөө лууны дүрстэй турван хөлтэй гууль цутгамал сангийн бойлор. Бойлрын аргэн тойрон дурсгалсан хэв, чимэглэлийг орчин цагийн будаач материалаар паалаанг дуурайлган хийсэн. Дээрээ арслангийн дүрс бүхий бариултай, цацат болон сарьсан багаваахайг цоолборлон дурсгалсан. Таглы хэв, чимэглэлийг орчин цагийн будаач материалаар паалаанг дуурайлган дурсгалсан байна.

Энхжуу "Сангийн бойлор" эд зүйл нь хийц, хэв шинжийн хувьд орчин цаг бүтээгдсэн гуп түүх, соёлын дурсгалт зүйл соёлын өвд хамаарахгүй болно.

Гэрэл зураг:

Нэр: Сангийн бойлор (урт)

Хэмжээ: Сангийн бойлор: өндөр-5.4см, таглайгаа-10.5см, ергөн-5.7см, урт-31.4см

Материал, хийц: Өнгөт металл цутгуур, шинэ цагийн хийц

Зорилт 4.2 Соёлын өвийг бүртгэх, хадгалж хамгаалах чиглэлээр музей, соёлын байгууллагын ажилтнуудад төрөлжсөн мэргэжил арга зүйн зөвлөгөө бүхий сургалт зохион байгуулж, мэргэжлийн ур чадвар, чадавхыг сайжруулна. ("Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа /2021-2030 он/ Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 5. Соёл урлагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгож, хүний нөөцийг хөгжүүлэх тогтолцоог бүрдүүлсэн байна" зорилт, Соёлын Яамны Стратегийн зорилт 1.Соёлын салбарын бодлого, хөгжлийн хэтийн чиглэлийг судалгаа шинжилгээнд тулгуурлан тодорхойлж, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.)

***4.2.1** Музей, соёлын салбарын байгууллагын ажилтнуудад соёлын өвийн бүртгэл, судалгааны чиглэлээр сургалт зохион байгуулж, сургалтын хэрэгжилтийн үр дүнг тухайн байгууллагаас авна.*

Тайлант хугацаанд 12 удаагийн сургалт зохион байгуулав.Үүнд:

- Соёлын өвийн шилжилт хөдөлгөөн, тоон дүн, мэдээллийг нэгтгэх, тайлагнахад шат шатны бүртгэл, мэдээллийн санг мэргэжил, арга зүйгээр хангах зорилго

бүхий “Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санчдын чадавхыг бэхжүүлэх нь" сургалтыг зохион байгуулав. Тус сургалтаар соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэлт, төрөлжсөн бүртгэлийн мэдээлэл, хадгалалт хамгаалалтын үнэлгээ хийх арга зүй, соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн ашиглалт, соёлын өвийн үзлэг, тооллогын явцын мэдээ, бүртгэлийн цахим программын хэрэглээний тухай мэдлэг, ойлголтыг нэмэгдүүллээ.

- "Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн бүрдүүлэлт, бүртгэн баримтжуулалтын арга зүй" сэдэвт сургалтыг Хэнтий аймгийн музей, Ховд аймгийн музей, Хархорум музей, Нисэхийн түүхийн музейн ажилтнуудад тус тус зохион байгуулав.
- Хэнтий аймгийн Соёл, урлагийн газрын хүсэлтийн дагуу тус аймагт зохион байгуулагдсан "Соёлын ажилтны сургалт, зөвлөгөөн" арга хэмжээнд оролцон "Аймаг, сумын соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэлт" сэдэвт сургалтыг арга зүйгээр хангаж зохион байгуулав.
- Баримтат өвийн төрөлжсөн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх аргазүйн танхимын болон цахим сургалтыг Чойжин ламын сүм музей, Дүрслэх урлагийн музей, Үндэсний түүхийн музей, Сүхбаатар, Өвөрхангай, Дорнод, Баян-Өлгий аймгийн Соёл, урлагийн газар, Соёлын төвийн ажилтнуудад зохион байгуулав.

Үр дүнд: Аймаг, нийслэлийн Соёл, урлагийн газрын 22 мэргэжилтэн, төрийн болон орон нутгийн өмчийн 42 музейн 88 ажилтан, 21 сумын соёлын төвийн эрхлэгч, соёлын өв хариуцсан ажилтан сургалтад хамрагдаж, мэргэжил арга зүйгээр хангагдсан байна.

Зураг 40. “Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санчдын чадавхыг бэхжүүлэх нь" сургалт

Зураг 41. "Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн бүрдүүлэлт, бүртгэн баримтжуулалтын арга зүй" сургалт

Зураг 42. "Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн бүрдүүлэлт, бүртгэн баримтжуулалтын арга зүй" сургалт

***4.2.2** Музей, соёлын салбарын байгууллагын ажилтнуудад соёлын өвийн хадгалалт хамгаалалтын чиглэлээр чадавхи бэхжүүлэх сургалт зохион байгуулж, сургалтын хэрэгжилтийн үр дүнг тухайн байгууллагаас авна.*

Музей, эрдэм шинжилгээний хүрээлэн, архивын газар, их дээд сургууль зэрэг 13 байгууллагын 193 (давхардсан тоогоор) ажилтан албан хаагчдад дараах сэдвүүдээр 9 удаа сургалт зохион байгуулсан.

- Чойжин ламын сүм музейн ажилтнуудад “Цаасан суурьтай баримтат өвийн хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалт”;
- БНСУ-ын Солонгос улсын Соёлын өвийн судалгааны үндэсний төвтэй хамтран “Чулуун соёлын өвийн хадгалалт хамгаалалт”;
- Оросын Холбооны улсын автономит БНБУ-ын Өвөр байгалийн музей, Богд хааны ордон музей, Дүрслэх урлагийн музейн мэргэжилтнүүдэд “Онол практик хосолсон сургалт”;
- Улаанбаатар музейн албан хүсэлтийн дагуу музейн сан хөмрөг үзэсгэлэнгийн танхимд хадгалалт хамгаалалтын анхан шатны зөвлөгөө өгч “Соёлын өвийн хадгалалт хамгаалалтын шинжлэх ухаан”;
- Токио хотын хадгалалт хамгаалалтын хүрээлэнгийн мэргэжилтнүүдтэй хамтран "Музейн орчин дахь органик хүчлийн нөлөө болон түүнээс сэргийлэх аргачлалын тухай" сэдэвт цахим сургалт;

- Соёлын өвийн үндэсний төв, Уран зургийн галерейн ажилтнуудад “Соёлын өвийн хадгалалт хамгаалалтад хэрэглэж байгаа химийн бодис, бодистой ажиллах аюулгүй ажиллагаа”;
- Нийслэлийн архивын газрын албан хүсэлтийн дагуу цаасан суурьтай баримтат өвийн сан хөмрөгийн хадгалалт хамгаалалт хийж буй байдалтай танилцаж анхан шатны зөвлөгөө өгч, сургалт тус тус зохион байгуулсан.
- Дэлхийн өвийн конвенцийг Монгол Улс хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, чадавхыг бэхжүүлэх зорилгоор ЮНЕСКО-гийн ивээл дор II зэрэглэлийн олон улсын төв болох Дэлхийн соёлын өвийн сургалт, судалгааны төв ВИТРАП Шанхай болон СӨҮТ-ийн хооронд “Хамтын ажиллагааны Санамж бичиг” байгуулсаны дагуу “Дэлхийн өвийн хадгалалт хамгаалалтын чадавхийг бэхжүүлэх нь” 3 өдрийн цахим сургалт, “Дэлхийн өвийн хамгаалалтын менежментийг боловсронгуй болгох нь” цахим хэлэлцүүлэгийг тус тус зохион байгуулав. Уг арга хэмжээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёлы урлагийн газар, Соёлын өвийн үндэсний төв, Орхоны хөндийн соёлын дурсгалт газар, Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолбор, Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат шүтлэгт газар нутгийн хамгаалалтын захиргаа, “Дэл уулын гайхамшиг” ТББ зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудын нийт 33 холбогдох мэргэжилтэн, албан хаагчид оролцлоо.

Сургалтаар соёлын биет өвийн хадгалалт хамгаалалтын шинжлэх ухааны олон талт суурь судалгааны аргазүйг олон улсын жишигт нийцсэн хэлбэрээр туршлага солилцож, органик болон органик бус материалын хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалт, хүрээлэн буй орчны эрсдэл, тогтвортой орчин бүрдүүлэлт зэрэг судалгааны аргазүйг онол, практик хосолсон хэлбэрээр дунд болон ахисан шатны мэдлэгийг дотоод гадаадын мэргэжилтнүүдэд хамтарсан болон бие даасан хэлбэрээр өгч соёлын биет өвийн хадгалалт хамгаалалтын шинжлэх ухааны мэдлэгийг чадавхжуулсан.



СЕРТИФИКАТ

Н. Цэнгэлмаа танаа

2022 оны Соёлын өвийн хадгалалт хамгаалалтын анхан шатны сургалтын хөтөлбөрт идэвхтэй оролцсон тул энэхүү баталгаажуулж олгов.

Сургалтын нэр : (A) XRF ашиглан соёлын өвд ул гэмтэх учруулах шинжилгээний арга

(B) Цаас - Ширхэлэгийн шинжилгээний үндэс

Сургалтын хугацаа : 2022 . 08. 15 ~ 08. 19

2022. 08. 19

Cho Nam

Ж. Хашбат

НЭМЭЛТ АЖЛЫН ХҮРЭЭНД:

***5.1** Чингис хааны музейн үзүүлэгт дэглэх соёлын өвийн сэргээн засварлалт.*

Чингис хаан музейд 4959 ш үзмэрийг сэргээн засварлаж хүлээлгэн өгсөн. Үүнд:

- Төмөр эдлэл 2433 ш, мөнгө 1854 ш, алт, алтаар бүрсэн 175 ш, хүрэл эдлэл 264 ш, органик 46 ш, шавар 77 ш, чулуун эдлэл 15 ш, яс 14 ш, гууль 28 ш нийт 4906 ш олдворт хадгалалт хамгаалалтын болон сэргээн засварлалтын ажлыг гүйцэтгэж, тайланг бүрэн бичиж хүлээлгэн өгсөн.



Соёлын өвийн үндэсний төвийн захирлын
2022 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн
А/16 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ ГАЗАР
СЭРГЭЭН ЗАСВАРЛАЛТЫН АЖЛЫН ТАЙЛАН
№СӨҮТ2022.Н-1.11

1. Үндсэн мэдээлэл:

1	Өмчлөгч	Монгол улс
2	Эзэмшигч	ЧИНГИС ХААН музей
3	Соёлын өвийн нэр	Очирваань бурханы цамын баг
4	Төрөл зүйл	Цамын баг
5	Хувийн дугаар	ДҮМ1976.16.10
6	Материал, хийсэн арга	Гипс, төмөр, будаг, цутгуур
7	техник	
8	Бүтээлчийн нэр	
9	Тоо ширхэг	1

Хэмжээ:

Өндөр	
Урт	
Өргөн	
Зузаан	
Голч	
Жин	
Бусад хэмжээс:	

Сэргээн засварлахын өмнө

Сэргээн засварласны дараа

Зураг 41. Чингис хаан музейн үзмэр, эд өлгийн зүйлийн сэргээн засварлалт

- Үндэсний төвд хадгалагдаж байсан Ховд аймгийн Мөнххайран сумын Борт багийн нутаг “Үзүүр гяланг”-аас олдсон 41 ширхэг олдвор, 12 ширхэг чулуун дурсгалыг сэргээн засварлаж нийт 53 ширхэг үзмэр, эд өлгийн зүйлсийг тус музейд хүлээлгэн өгөв.

Д/д	Үзмэрийн нэр	Харьяалагдах байгууллага	Тоо ширхэг	Тайлбар
1	Эсгий хэтэвч	1.Чингис хаан музей 2022/01	1ш	Үзүүр гялангийн олдвор 2022.04.29
2	Ясан сам		1ш	
3	Хатгамалтай эсгий хэтэвч		1ш	
4	Даавууны тасархай		3ш	
5	Модон эдлэл /ац хэлбэрийн/		1ш	
6	Гутал		1 хос	
7	Малгай		1ш	
8	Эсгий цүнх		1ш	
9	Морины тоног хэрэгсэл		1 иж /бүрдэл 8ш/	
10	Торгон эмжээртэй даавуун дээл		1ш	
11	Даавуун дээл		1ш	
12	Нэхмэл эдлэл		1ш	
13	Эсгий оймс		1 хос	
14	Өмд		3ш /1 өмдний бүчний тасархай/	
15	Моюнчурын хөшөө		3 хэсэг	
16	Таван толгойн хүн чулуун хөшөө		2ш	
17	Хар балгасын гэрэлт хөшөө		1ш (Нэг талдаа цууралттай)	
18	Хар ямаатын чулуу (хуулбар)		1ш	

- "Чингис хаан" музейн үзмэрт зориулж орон нутгийн музейгээс үзмэр татан авах ажлын хүрээнд тус төвийн Сэргээн засварлах газрын мэргэжилтнүүд сав, баглаа боодол, аюулгүй тээвэрлэлт хийх зөвлөмжийг боловсруулан Дорноговь аймаг, Өвөрхангай аймгийн Хархорин сумын музейд ажиллав.

Зураг 42. Чингис хаан музейд орон нутгийн музейгээс үзмэр татан авах ажил

Сэргээн засварлалт хийгдэснээр музейн үзмэрийн тоо нэмэгдэж, олон нийтэд дэглэн үзүүлэх, түүхийн баримтад өвийг олон нийтэд таниулах боломжийг бүрдүүлсэн ба үзмэрийн хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалт хийх үйл ажиллагааг багаар хамтран ажиллаж зохион байгуулах аргазүйг нарийвчилсан байдлаар зохион байгуулах туршлагатай болсон.

***5.2** СӨУНБМСангийн дуу дүрс бичлэгийн бүртгэлийн нэгдсэн систем бий болгох.*

“Соёлын биет бус өвийн дуу, дүрс бичлэгийн студи”-ийг 2022 оны 2 дугаар улирлаас шинээр ашиглалтад оруулаа. Тус студи байрлах өрөөг тохижуулж, Betacam, UVW, DV, SVHS хальсыг дижитал хэлбэрт хөрвүүлэхэд шаардлагатай дуу, дүрс бичлэгийн тоног төхөөрөмж худалдан авч, суурилуулав. Тайлант хугацаанд DV хэлбэртэй 60 минутын 280 ширхэг хальсыг дижитад хувилбарт шилжүүлж, 280 цагийн, 2.81 TB багтаамжтай цахим файлыг түүний агуулга бүхий 370 хуудас бичвэрийг СӨУНБМСанд товьёгжуулж хадгалаад байна. Студи ашиглалтад орсноор СӨУНБМСанд хадгалагдаж байгаа Betacam, UVW, DV, SVHS хальсны бичлэг дижитал хэлбэрт хөрвүүлэгдэн Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 24.3 дахь заалт хэрэгжиж, Соёлын биет бус өв, өвлөн уламжлагчийн өвөлсөн ардын дуу, бий биелгээ, морин хуурын татлага, домог хууч яриа, зан үйлийн олон төрөл зүйлийн дахин давтагдашгүй дүрс бичлэг, баримтыг устах эрсдэлээс хамгаалах, өвийг судалгааны эргэлтэд оруулах, контент бүтээх, цахим сан үүсгэх, судлах, сурталчлах, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломж бүрдэж байна.

Зураг 36. Дуу дүрс бичлэгийн студи

***5.3** Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын хувийн хэрэг, хөтлөх зааврыг холбогдох байгууллагуудад хүргүүлж, үр дүнг нэгтгэх.*

Үндэсний төвийн захирлын 2022 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн А/15 дугаар тушаалаар батлагдсан “Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын хувийн хэргийн маягт”-хөтлөх зааврыг аймаг, нийслэлийн Соёл, урлагийн газруудад албан бичгээр хүргүүлж, хариу ирүүлсний дагуу Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын RICH 3.0 программд түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын төрөлд 1121 дурсгалт газрын 2915 дурсгал бүртгэгдсэнээс шороон туурь, үлдэгдэл, суваг, шуудуу зэрэг төрлийг хамруулалгүй орхиж, Эртний хотын туурь, Сүм хийд, туурь, Түүхэн дурсгалт байшин, Суврага гэсэн зүйлд хамаатах 676 дурсгалт газрын товч мэдээллийг нэгтгэв. Үүнээс “Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-д 57 дурсгалт газар, “Аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-д 88 дурсгалт газар, "Дүүргийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт"-д 30 дурсгалт газар, Нийт 175 дурсгалт газрыг тус тус хамгаалалтын зэрэглэлд хамруулсан байна. Хамгаалалтын зэрэглэл бүхий 175 дурсгалыг төрөл зүйлээр нь ангилахад эртний хотын туурь-60, түүхэн дурсгалт байшин-54, сүм хийд, туурь-51, суврага-10 байна. Дурсгалын ашиглалтын байдлыг нэгтгэхэд ашиглалтай-67, ашиглалтгүй-106 дурсгал, ашиглалтын байдал тодорхойгүй-2 дурсгал байна. Хамгаалалтын зэрэглэл бүхий 175 дурсгалын

хадгалалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор Соёлын яамны төлөвлөлтөд хамрагдсан, аялал жуулчлалын бүс нутагт байрлаж байгаа, эвдрэл гэмтэл нь шууд ил харагдаж байгаа зэрэг мэдээлэлд түшиглэн төлөвлөлтийг:

- Хүчитгэх, бэхжүүлэх шаардлагатай-47
- Сэргээн засварлах шаардлагатай-56
- Сэргээн засварлах шаардлагагүй-72 хэмээн ангилж, холбогдох дурсгалыг төлөвлөлтийн дагуу нэгтгэв. Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын хувийн хэргийн маягт”-аар түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын ашиглалтын байдалд судалгаа, хяналт хийхэд чухал ач холбогдолтой.

Соёлын өвийн үндэсний төвийн захирлын 2022 оны 5 дугаар сарын 09-ны өдрийн А/10 дугаар тушаалын хавсралт хавсралт

ТҮҮХЭН ДУРСГАЛТ БАРИЛГА, АРХИТЕКТУРЫН ДУРСГАЛЫН ХУВИЙН ХЭРГИЙН МАЯГТ

Нэг. Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын үндсэн мэдээлэл

Хувийн хэрэг бүрдүүлсэн огноо:.....
Дурсгалт газрын нэр:.....
Дурсгалт газрын бүртгэлийн дугаар:.....

Нэрс	МД	Улс	Аймаг, нийслэл	Сум, дүүрэг	Баг, хороо	Газрын нэр, гудамж		
Засаг захиргааны нэгж	1.1							
Түүхэн үе	1.2							
Барилгын он, цаг хугацаа	1.3							
Дурсгалын анхны зориулалт	1.4							
Өмчлөлийн хэлбэр	1.5	Төрийн	Орон нутгийн	Олон нийтийн	Шашны	Иргэний	Дундын	Бусад
Одоогийн ашиглалтын хэлбэр	1.6							
Эзэмшлийн хэлбэр	1.7	Төрийн	Орон нутгийн	Төрийн бус байгууллага	Аж ахуйн нэгж	Хувь хүн	Дундын	Бусад
Үл хөдлөх хөрөнгийн гарчилгээ	1.8	Гэрчилгээний дугаар		Эзэмшигчийн нэр				
Газрын гарчилгээ	1.9	Гэрчилгээний дугаар		Эзэмшигчийн нэр				
Кадастрын зураг	1.10	Нэгж талбарын дугаар			Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан хадгалсан эсэх			
					Тийм		Үгүй	

Хоёр. Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалд хийсэн судалгааны ажлын мэдээлэл

Хувийн хэрэг бүрдүүлсэн огноо:.....
Дурсгалт газрын нэр:.....
Дурсгалт газрын бүртгэлийн дугаар:.....

Дурсгалын нэр:.....
Дурсгалын бүртгэлийн дугаар:.....

Нэрс	МД	Хугацаа (оноор)	Төсөвт ертөг (сая.төг)	Судалгаа хийсэн хүн хүч	Судалгаа хийсэн байгууллага	Ном, сэтгүүл, тайлангийн нэр	Судалгааны тайланг хадгалж байгаа газар
А	Б	1	2	3	4	5	6
Эвдрэл гэмтлийн судалгаа	2.1						
Барилга байгууламжийн материалын судалгаа	2.2						
Агаарын чанар, тоосжилт тодорхойлох судалгаа	2.3						
Өнгө будгийн судалгаа (эрдэс, элемент, цавуулаг, давхарга)	2.4						
Нийгмийн орчны нөлөөллийн судалгаа	2.5						



Соёлын өвийн үндэсний төвийн захирлын 2022 оны 5 дугаар сарын 09-ны өдрийн А/10 дугаар тушаалын хавсралт хавсралт

ТҮҮХЭН ДУРСГАЛТ БАРИЛГА, АРХИТЕКТУРЫН ДУРСГАЛЫН ХУВИЙН ХЭРЭГ ХӨТЛӨХ ЗААВАР

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалт, хүчитгэлийн нөхцөл байдлын талаарх бодит мэдээллээр, удирдах дээд болон эрх бүхий байгуллага, хуулийн этгээд, олон нийтийг хангах зх сурвалж бариулт болно.
2. Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.2; 21.1; 21.2; 23.2 дахь заалтын дагуу Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын хадгалалт хамгаалалтын мэдээллийг бүрдүүлж, нэгтгэхэд энхүү маягтыг ашиглана.
3. Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын хувийн хэрэг нь:
   Нэг. Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын үндсэн мэдээлэл,
   Хоёр. Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалд хийсэн судалгааны ажлын мэдээлэл,
   Гурав. Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын эвдрэл гэмтэл, түүнийг зассан тухай мэдээлэл,
   Дөрөв. Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалыг сэргээн засварласан тухай ерөнхий мэдээлэл гэсэн дөрвөн төрлийн хуснэгтэн мэдээллээс бүрдэнэ.
4. Дан болон цөцөлбор байдлаар орших түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалуудад судалгааны ажил, хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалт, хүчитгэлийг хэрхэн хийсэн, судалгаа шинжилгээ, барилга байгууламжийн ажлын зураг байгаа эсэх, хэсэчлэсэн болон бүтэн байдлаар сэргээн засварласны дараах тайланг хадгалсан эсэх, ямар байгууллага хэрхэн хариуцах, хяналт тавьдаг зэрэг нарийвчилсан мэдээлэл цуглуулна.
5. Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын хувийн хэргийг тухайн барилга байгуулламжийг эзэмшигч, өмчлөгч хүлээн эттэвч, хувь хүн, аж ахуйн нэгж хөтлөн явуулах ба дээрх нэр бүхий дөрвөн төрлийн маягтыг үүсгэлгүй нэг бүрээр тоочилсон үг хэрэглэхгүй, бүрэн гүйцэд, үнэн зөв, алдаагүй бөглөнө.
6. Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын хувийн хэргийг жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны дотор Соёлын өвийн үндэсний төвд хүргүүлнэ.
7. Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын хувийн хэргийн зх хувийг хариуцагч байгууллагын бүртгэл, мэдээллийн санд хадгалах ба хуулбар 1 (нэг) хувийг цаасан хэлбэрээр болон цахимаар Соёлын өвийн үндэсний төвд хүргүүлнэ.
8. Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын хувийн хэргийн маягтыг хүргүүлэхдээ хянасан байгууллагын захирал, хувийн хэрэг хөтлөсөн албан тушаалтан нар тус бүр гарын үсэг зурж, байгууллагын тамга тэмдэг дарж баталгаажуулсан байна.
9. Өмнөх жилүүдэд хийдсэн сэргээн засварлалтын ажил болон холбогдох мэдээллийг нөхөж бүрдүүлнэ.

2

10. Хувийн хэрэг хөтлөх ажлыг маягтын дагуу мэдээллээр хангаж, баяжуулалт хийх замаар жил бүр шинэчилнэ.
11. МД-мерийн дугаар болно.
12. Худалдсан дугаарлалтыг худалдс бүрийн баруун доод буланд "тухайн худалдсны дугаар/нийт худалдсны тоо" гэсэн форматаар бичнэ. Жишээ нь, тухайн маягт нийт 10 худалдстай бол 1/10 гэх мэт.
13. Соёлын өвийн үндэсний төвийн захирлын баталсан түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын хувийн хэргийн маягтын асуулга, асуултыг өөрчлөхийг хориглоно.

Нэг. Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын үндсэн мэдээлэл

Хувийн хэрэг бүрдүүлсэн огноо: Тухайн барилга дээр хувийн хэрэг хөтлөсөн өдрийг он/сар/өдөр даравллаар бичнэ үү.

Дурсгалт газрын нэр: (Цөцөлбор болон дан байдлаар орших барилга байгууламжийн ерөнхий нэрийг бичнэ үү. Жишээ нь, Богд хааны ордон музейн цөцөлбор, Чин ван Ханддоржийн байшин гэх мэт)

Дурсгалт газрын бүртгэлийн дугаар: (Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын бүртгэлийн дугаар болох 8-9 оронтой тоог бичнэ үү. Жишээ нь, 11 22 001 5)

1.1.Засаг захиргааны нэгж: Харгалзах мөрөнд ... улс ... аймаг/хот, ... сум/дүүрэг, ... баг/хороо, ... нэртэй газар гэсэн дарааллаар одоо байгаа хаягийг бичнэ үү.
1.2.Түүхэн үе: Монгол нутаг дахь эртний улсын үе, Их Монгол Улсын үе, Манжийн эрхшээлийн үе, Богд хаант Монгол Улсын үе, БНМАУ-ын үе гэх мэтээр бичнэ үү.
1.3.Барилгын он, цаг хугацаа: Анх хэдэн онд барьж байгуулсан болохыг бичнэ үү. Хэрэв тодорхой бус байвал тоймлож бичнэ үү. Жишээ нь XVI зууны эхэн үе гэх мэтээр.
1.4.Дурсгалын анхны зориулалт: Тухайн барилга анх ямар зориулалттаар баригдсан болохыг бичнэ үү. Сум хийд, хоршоо, эмнэлэг, сургууль, засаг захиргаа, театр, үйлдвэр гэх мэтээр.
1.5.Өмчлөлийн хэлбэр: Төрийн, орон нутгийн, олон нийтийн, шашны, иргэний, дундын гэсэн сонголтоос аль нэгийг сонгож харгалзах нүдэнд (+) тэмдэглэгээ хийнэ үү. "Бусад" сонголтыг сонгосон бол харгалзах мөрөнд бичиж оруулна уу.
1.6.Одоогийн ашиглалтын хэлбэр: Одоогийн байдлаар ямар зориулалтаар, ямар байгууллага үйл ажиллагаа явуулж байгааг бичнэ үү.
1.7.Эзэмшлийн хэлбэр: Төрийн, орон нутгийн, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүн, дундын гэсэн сонголтоос аль нэгийг сонсож харгалзах нүдэнд (+) тэмдэглэгээ хийнэ үү. "Бусад" сонголтыг сонгосон бол харгалзах мөрөнд бичиж оруулна уу.
1.8.Үл хөдлөх хөрөнгийн гарчилгээ: Гарчилгээний дугаар, эзэмшигчийн нэрийг товчлохгүй бүтнээр бичнэ үү.
1.9.Газрын гарчилгээ: Гарчилгээний дугаар, эзэмшигчийн нэрийг товчлохгүй бүтнээр бичнэ үү.

***5.4** Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллого зохион байгуулахад хамтран оролцох.*

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 26.1 дэх, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын даргын 2022 оны А/10, А/14 тоот тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллого-2022”-ыг зохион байгуулан ажиллав.

<u>Улсын комисс тооллогын бэлтгэл ажлын хүрээнд:</u>

- “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллогын удирдамж, ажлын төлөвлөгөө, түүх, соёлын үл хөдлөх дурсгалын төрөл тус бүрийн онцлогт тохирсон хадгалалт хамгаалалтын мэдээлэл цуглуулах маягтыг боловсруулан батлуулсан;
- Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэлийн www.rich.mongoluv.mn цахим программыг ашиглалтал оруулсан;

- “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллого-2022” мэргэжил арга зүйн нэгдсэн сургалтыг улсын хэмжээнд зохион байгуулсан;
- “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллого-2022” гарын авлагыг боловсруулан 21 аймаг, нийслэлийн соёл, урлагийн газар, 330 сум, нийслэлийн 9 дүүрэгт хүргүүлсэн;
- “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллого-2022”-ын бүртгэлийн тооллогын дэвтрийг боловсруулан, хэвлүүлж, аймаг, нийслэлийн Салбар комисст хүлээлгэн өгсөн.

<u>Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллогын үйл явц, үр дүн:</u>

- Улсын комиссоос Салбар комисст чиглэл, арга зүйн зөвлөгөө өгөх, www.rich.mongoluv.mn программд мэдээлэл оруулах, тооллогын тайлан бичих заавар зөвлөмжийг нийт 6 удаагийн цахим хурал, сургалтаар өгсөн;
- Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллоготой холбоотой мэдээллийг Соёлын өвийн үндэсний төвийн вэб хуудас, сошиал сувгуудаар цаг тухай бүрт дамжуулан хүргэсэн;
- Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллогын хээрийн үзлэг судалгаа улсын хэмжээнд 2022 оны 08 дугаар сараас эхлэн 11 дүгээр сарын 20-ны хооронд бүрэн дууссан;
- Тооллогын хээрийн үзлэг судалгааны үеэр 3 удаа явцын мэдээг аймаг, нийслэлийн Салбар комиссоос хүлээн авч нэгтгэн танилцуулсан;
- Улсын хэмжээнд нийт 9266 дурсгалт газар тооллогод хамрагдахаас 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 9137 дурсгалт газар буюу 98.6%-ийн мэдээлэл программд бүртгэсэн байна. Тооллогын тайланг аймаг, нийслэлээс хүлээн авч нэгтгэх ажил явагдаж байна.

Үр дүнд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 26.1 дэх заалт хэрэгжиж, Монгол Улсын нутаг дэвсгэр орших түүх, соёлын үл хөдлөх дурсгалын нэмэлт хөгжүүлэлт хийгдсэн программ ашиглалтад орж, хадгалалт, хамгаалалтын нөхцөл байдлын нэгдсэн үнэлгээг улсын болон орон нутгийн хэмжээнд нэгтгэх, дурсгалын төрөл тус бүрийн эвдрэл, гэмтлийг тодорхойлох, зарим алдаатай мэдээллийг засаж сайжруулах, статистик мэдээллийг баяжуулах, олон нийтийн оролцоо, хяналтыг сайжруулах боломжийг бүрдүүлэв.



ДӨРӨВ. ТӨСӨВ САНХҮҮ

4.1 Төсвийн төлөвлөлт:

Төсвийн тухай хуулийн 8.4.1-т заасны дагуу 2023 оны төсвийн саналыг 2,392,716,800 төгрөгийн төсөв төсөвлөн хугацаанд нь хүргүүлсэн бөгөөд нийт төсвийн 85 хувийг “Цалин хөлс болон нэмэгдэл урамшил”, 4,5 хувийг “Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал”, 7,5 хувийг “Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал” 3 хувийг байгууллагын үйл ажиллагаатай холбоотой зардал эзэлж байна.

Иймд 2023 оны төсөвт түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах зардал, сургалт, үйлдвэрлэлийн дадлага хийх сургалтын зардал зэргийг тус тус тусгасан. Түүнчлэн 60х40 метрийн хэмжээтэй, газар доорх давхар болон нэг, хоёрдугаар давхраас бүрдсэн нийт 8000 м^2 талбайтай, 130 гаруй өрөө тасалгаа бүхий байрны арчилгаа тордолгооны зардал болон албан хаагчдад компьютер тоног төхөөрөмжийн дутагдалтай байна.

4.2 Төсвийн зарцуулалт:

Нийт батлагдсан төсвийн 85 хувийг “Цалин хөлс болон нэмэгдэл урамшил”, 4,5 хувийг “Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал”, 7,5 хувийг “Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал” 3 хувийг байгууллагын үйл ажиллагаатай холбоотой зардал 11 сарын байдлаар 1,297,152,600 төгрөгийн төсвөөс 936,624,498.32 төгрөгийг зарцуулсан. 2022 оны цалингийн төсөв 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар гаргав.



Он	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
2020	539,609,600.0	438,819,798.3	100,798,801.7
2021	512,609,500.0	481,874,451.5	30,375,048.5
2022	1,019,513,000.0	642,817,000.45	376,695,999.6

2020-2022 оны түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах зардал:



Он	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
2020	8,913,500	8,913,500	-
2021	3,697,400	3,697,400	-
2022	11,763,600	11,763,600	-

2020-2022 онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр:



Он	Нийт төсөл хөтөлбөр	Гадны төсөл хөтөлбөр (ЮНЕСКО болон ОУ-ын байгууллага)	Дотоодын төсөл хөтөлбөр (Дээд шатны байгууллага)
2020	181,837,484.8	93,190,484.8	88,647,000.0
2021	581,203,143.8	74,612,343.8	506,590,800
2022	308,953,164.4	95,233,164.4	213,720,000.0

4.3 Худалдан авалт

Гэрээт харуул хамгаалалтын тендерийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах хууль, тендер шалгаруулалтын онцгой журмын харьцуулалтын аргаар зохион байгуулж “Шүтээн-уул” ХХК шалгаран гэрээт харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлж байна.

Соёлын баримтат өвийг сэргээн засварлах шаардлагатай тоног төхөөрөмжийг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.1-ийг үндэслэн шууд гэрээ байгуулах аргаар худалдан авсан.

Үндсэн хөрөнгө	Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
2021	2,155,801,896.51	277,097,014	31,015,889.39	2,401,883,021.12
2022	2,401,883,021.12	41,703,500	-	2,443,586,521.12



4.4 Шилэн дансны хэрэгжилт

Манай байгууллага нь Шилэн дансны тухай хуулийн 6-р зүйлд заасны дагуу төсөв санхүүгийн тайлан мэдээг https://shilendans.gov.mn/ сайтад сар бүрийн 07-ны дотор байршуулдаг бөгөөд 3 дугаар улирлын байдлаар 99.1 хувьтай дүгнэгдсэн.



2022 оны үр дүнд суурилсан санхүүжилтийн биелэлтийг тайлагнах хүснэгт

№	Шалгуур үзүүлэлт	Хүрсэн түвшин	Тайлбар
1	Хөтөлбөр арга хэмжээний орлого /мянган төгрөгөөр/	1,297,152.6	Үндсэн үйл ажиллагаа-1,158,861.4 Харуул хамгаалалт-32,986.7 Түүх, соёлын дурсгалт зүйлийн хамгаалалт-11,763.6 Бусад урсгал шилжүүлэг- 93,540.9
2	Хөтөлбөр арга хэмжээний зардал /мянган төгрөгөөр/	936,624.4	Үндсэн үйл ажиллагаа-799,504.1 Харуул хамгаалалт-32,964.5 Түүх, соёлын дурсгалт зүйлийн хамгаалалт-11,763.6 Бусад урсгал шилжүүлэг- 92,392.2
3	2022 оны орлого /мянган төгрөгөөр/	-	-
4	2021 оны орлого /мянган төгрөгөөр/	-	-
5	Нийт төсөв /мянган төгрөгөөр/	1,374,753.3	2022.1.1 -ний батлагдсан төсвөөр 1,395,862.5₮ 2022.5.1 -ний төсвийн тодотголоор 1,374,753.3
6	Ур чадвар дээшлүүлсэн албан хаагчдын тоо	8	Монгол бичгийн 2 удаагийн сургалт-53 Архив, бичиг хэрэг-2 Соёлын боловсролын сургагч багш-1 Мэргэшүүлэх сургалт-27
7	Нийт албан хаагчдын тоо	58	Удирдах-11 Гүйцэтгэх-41 Үйлчлэх-6
8	Үйлчлүүлэгчийн тоо	-	-
9	Суурин хүн амын тоо	209,524	Хан-Уул дүүрэг

ТАВ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ, ДҮГНЭЛТ

5.1 2022 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний тоон дүн

№	Үзүүлэлт	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Бүрэн хэрэгжүүлсэн арга хэмжээ	Гүйцэтгэл дутуу арга хэмжээ	Хэрэгжүүлээгүй арга хэмжээ
1.	Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтын хүрээнд	2	2	2		
2.	Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд	5	32	30	2	

3.	Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд	2	11	9	1	1
4.	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд	2	6	6		
Төлөвлөгөөнд тусгагдсан		**11**	**51**	**47**	**3**	**1**
Нэмэлт ажлын хүрээнд			4	4		
Нийт		**11**	**55**	**51**	**3**	**1**

5.2 2022 онд хэрэгжээгүй арга хэмжээний мэдээлэл

№	Арга хэмжээ	Хувь	Шалтгаан	Цаашид авах арга хэмжээ	Тайлбар
1	2.3.5. Дүрслэх урлагийн музей, Улсын драмын эрдмийн театр, Дуурь бүжгийн эрдмийн театрын барилгыг хүчитгэх ажилд хамтран оролцох.	70	Дүрслэх урлагийн музей зураг төслийн ажил хийгдээд явж байгаа. Улсын Драмын эрдмийн театр 4 удаа тендер зарлаад амжилтгүй болсон.	Тендер шалгаруулалтад шалгарсан компанид тухай бүр зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, хамтран ажиллана.	Тендер шалгаруулалт дуусаад хүчитгэх ажил эхлээд байгаа Улсын Дуурь бүжгийн эрдмийн театрийн барилгын гадна засварын гүйцэтгэлийн ажилтай 2022 оны 11 дүгээр сарын 21, 26-ны өдрүүдэд танилцаж 2022 оны 02/458 тоот албан бичгээр тус барилгын гадна засварын ажилд зөвлөмж хүргүүлэв.
2	2.4.6. “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц”-ын хамгаалалтын бүс дэх соёлын биет бус өвийн бүртгэл, судалгаа хийж, төрөлжсөн мэдээллийн сан үүсгэсэн байна.	70	Соёлын яамнаас чиглэл ирээгүй.		“Эрдэнэбүрэн”-УЦС баригдах бүс нутагт орших түүх, соёлын үл хөдлөх дурсгалын археологийн авран хамгаалах ажил, зарим дурсгалыг нүүлгэн шилжүүлэхэд анхаарах, СББӨ-д сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийн талаар төслийн нэгжид 2022 оны 01/262 тоот албан бичгээр зөвлөмж хүргүүлсэн.

3	3.1.1. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллогыг мэргэжил, арга зүйгээр ханган хамтран зохион байгуулж, тайлан дүн мэдээг улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хүлээн авч хадгална.	0	Соёлын яамнаас чиглэл ирээгүй.	Хуулийн дагуу тооллого зохион байгуулахад хамтран ажиллах	
4	3.1.5. Төрийн болон орон нутгийн музейн камер, дохиоллын системийг шинэчлэх ажилд хамтран оролцоно.	30	Соёлын яамнаас төрийн болон орон нутгийн музейн камер, дохиоллын системийг шинэчлэх, тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг Соёлын өвийн үндэсний төвийг хамтран оролцуулахаар төлөвлөгөөнд тусгасан боловч ямар нэгэн чиглэл өгөөгүй.	Соёлын яам төсөв, тодорхой чиглэл өгөх	Соёлын өвийн үндэсний төвөөс төрийн болон орон нутгийн музейгээс хяналтын камержилт, хамгаалалтын системийн мэдээллийг цуглуулах 16 үндсэн, 60 дэд асуулга бүхий судалгааны маягт боловсруулан 43 байгуулагад хүргүүлэн дүн мэдээг Соёлын яаманд хүргүүлсэн.

--o0o--